НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2018 он

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1 "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" бодлогын баримт бичигтэй уялдуулан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс дүүрэг хариуцан хэрэгжүүлэх 37 төсөл арга хэмжээний биелэлт 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 76,4 хувьтай хэрэгжсэн бөгөөд биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

Засгийн газрын гишүүд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан санамж бичиг, хамтран ажиллах гэрээний 2017 оны хэрэгжилтийг холбогдох хэлтэс, албадаас хүлээн авч нэгтгэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст Тамгын газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 03/434 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд нийт 6 санамж бичиг, хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж, 5 санамж бичиг 100 хувь, 1 санамж бичиг 60 хувийн хэрэгжилттэй, дундаж биелэлт 93.3 хувьтай хэрэгжсэн байна. 2018 онд санамж бичиг, гэрээний хүрээнд зохион байгуулсан ажлын үр дүнг 2019 оны 03 дугаар сард нийслэлийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс хариуцан хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний 2018 оны биелэлтийг жилийн эцсийн байдлаар тооцож хэрэгжилт үр дүнг тайлагнахаар ажиллаж байна.

1.3 Улсын болон нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг боловсруулахдаа 2016 онд иргэдээс авсан санал асуулга дээр тулгуурлан Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 244, 2014 оны 43 дугаар тушаалд тус тус нийцүүлэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчидтэй зөвшилцөн, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг боловсруулсан. Жагсаалтад туссан хөрөнгө оруулалтын ажлуудын байршлыг хороодын нутаг дэвсгэрт очиж, зураг авалт хийн баталгаажуулсан.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 369.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 21 төсөл, арга хэмжээний жагсаалт, 2018 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний шинэчилсэн жагсаалтыг батлах Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолын төслийг боловсруулан холбогдох тайлбар танилцуулгын хамт 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 03/81 тоот албан бичгээр хүргүүлж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2 дугаар сарын 21-ний өдрийн А/10 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад өөрчлөлт оруулан батлуулсан. Уг тогтоолыг үндэслэн дүүргийн Засаг даргын 2018 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн А/74 дүгээр захирамжаар дүүргийн Орон нутгийн хөгжлүүйн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 21 төсөл арга хэмжээний жагсаалтыг батлуулсан.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны А/35 дугаар тогтоолыг үндэслэн дүүргийн Засаг даргын 2018 оны А/241 дүгээр захирамжаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 21 төсөл арга хэмжээний жагсаалтыг шинэчлэн батлуулсан.

Дүүргийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/09 дүгээр захирамжаар дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг байгуулж, 2018 оны 3 дугаар сарын 21-ний өдөр нэгдсэн хуралдааныг зохион байгуулан, нийт хэрэгжүүлэх 40 төсөл арга хэмжээний явцын талаар мэдээлэл бэлтгэн, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь намын бүлгүүдэд ажлын явцыг албан тоотоор хүргүүлэн бүлгийн хуралдаанд танилцуулсан.

2018 оны дүүргийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 40 төсөл арга хэмжээг салбараар харуулбал:





Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээ
Хүснэгт-1

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хороо	Төсөвт өртөг /сая.төг/
1	46 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих /240 ортой/	3	862.7
2	"Тэрмэстий" өрхийн эрүүл мэндийн төвийн байрны их засвар	2	30.0
3	Нүхтийн нийт 32 гудамжнуудын замыг тэгшлэх	6	30.0
4	Дэнжийн 2, Сонсголонгийн 5 дугаар гудамжуудыг Жишиг гудамж болгон тохижуулах ажил	8	30.0
5	Буянт-Ухаагийн 24 буюу Сонсгологийн гүүрний баруун талд байрлалтай тоглоомын талбайд шаарлагатай тоглоом, тоног төхөөрөмж суурилуулах ажил	16	30.0
6	5-н худгийн засварын ажил	14	10.0
7	15 дугаар сургуулийн спорт заалны засварын ажил	3	30.0
8	Дүүргийн Эрүүл мэндийн төвийн үүдний засвар	3	60.0
9	Дүүргийн Эрүүл мэндийн төвийн Яармаг салбарын кабинет тохижуулах ажил	6	40.0
10	Зам талбайн тохижилт	15	10.0
11	18, 21, 22-р байрны гадна талбай, Төрийн банкны байрны хажуугийн явган хүний замын засварын ажил	1	30.0
12	32 дугаар сургуульд эко анги байгуулах	11	50.0
13	Арцатын 14-ийн гудамжуудыг засаж тэгшлэх ажил	4	30.0
14	35 дугаар цэцэрлэгийн барилгын нэмэлт ажлын санхүүжилт	11	19.3
Дүн			**1,262.0**

Хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээ:
Хүснэгт-2

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хороо	Ажлын явц %	Батлагдсан төсөвт өртөг /сая.төг/
1	Зураг төсөв	Нийт 23 ажил	70	100.0
2	10, 12, 13, 14 дүгээр хороодын нутаг дэвсгэрт шинээр автобусны буудал барих	10.12.13.14	30	90.0
3	Нисэх-Яармагт 4 улирлын цэцэрлэгт хүрээлэн байгуулах	4.5.6.7.8	30	420.0
Дүн				**610.0**

Хэрэгжээгүй төсөл арга хэмжээ:

Хүснэгт-3

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хороо	Батлагдсан төсөвт өртөг /сая.төг/
1	Ахмадын төвийн тохижилт	15	20.0
2	Яармагийн 19, 20, 21 дүгээр гудамжны нийт 20 өрхийг цэвэр усны шугамтай холбох	5	30.0
	Дүн		**50.0**

Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт:

2019 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг дараах үндсэн шаардлагыг харгалзан төлөвлөв. **Үүнд:**

1. Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт удаашралтай хөрөнгө оруулалт шаардлагатай заалтын биелэлтийг хангуулах;
2. Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан зорилтын хэрэгжилтийг хангуулах;
3. Дэргэдэх хэлтэс, албад, хороод, иргэдээс ирүүлсэн шаардлагатай хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;

Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Ахмадын сувилал барих, Туул, дунд голын дагуух дүүргийн нутаг дэвсгэрт амралт, үйлчилгээний эко зурвасуудыг байгуулах зэрэг нийт 15 заалтын хэрэгжилтийг хангуулахаар төлөвлөн 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан. 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 06 дугаар тогтоолоор 4.4 тэрбум төгрөгийн 34 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан.

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт:

Хүснэгтээр харуулбал:

№	Төсөл арга хэмжээний нэр	Хороо	Байршил	Төсөвт өртөг /сая.төг	2019 онд санхүүжих дүн /сая.төг/
	Шинэ			**4784.0**	**3784.0**
1	Зураг төсөв			200.0	200.0
2	Ахмадын сувиллын барилга барих	8	Жаргалантын ам	1800.0	800.0
3	Туул голын эрэг дагуу эко зурвас байгуулах	15	Туул голын эрэг дагуу	200.0	200.0
4	19-ийн үйлчилгээний төв орчмын тохижилт	2	Нийтийн эзэмшлийн зам талбайд	60.0	60.0
5	Спорт хорооны бялдаржуулах танхимын тохижилт	3	Биеийн тамир, спорт хороо	50.0	50.0

6	Явган хүний зам, авто замын уулзваруудад байр зүйн тэмдэглэгээ хийх	-	Нийтийн эзэмшлийн зам талбайд	100.0	100.0
7	Хороодын нэг цэгийн үйлчилгээний тохижилт, хаягжуулалт, гадна фасадны дизайныг нэгдсэн нэг стандарттай болгох	1,2, 15	1,2, 15 дугаар хорооны байр	90.0	90.0
8	Хороодын нэг цэгийн үйлчилгээний тохижилт, хаягжуулалт, гадна фасадны дизайныг нэгдсэн нэг стандарттай болгох	4, 5, 6, 7, 8	4, 5, 6, 7, 8 дугаар хорооны байр	150.0	150.0
9	Хороодын нэг цэгийн үйлчилгээний тохижилт, хаягжуулалт, гадна фасадны дизайныг нэгдсэн нэг стандарттай болгох	10,13, 14, 16	10,13, 14, 16 дугаар хорооны байр	120.0	120.0
10	Эрүүл мэндийн төвийн Яармаг салбарын барилгын засвар	6	ЭМТ-ийн Яармаг салбар	72.0	72.0
11	Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд автомашин худалдан авах	-	-	70.0	70.0
12	Ковш худалдан авах	-	-	180.0	180.0
13	Грейдер худалдан авах	-	-	220.0	220.0
14	Чанд авиа ӨЭМТ-ийн засвар	6	Чанд Авиа ӨЭМТөв	31.0	31.0
15	63 дугаар сургуулийн хүүхэд зөөврийн автобусны граж	4	63-р сургуулийн хашаанд	30.0	30.0
16	Иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авах мобайл аппликейшн хийх	-	-	65.0	65.0
17	Төрийн албан хаагчдын албан хэрэгцээнд компьютер, тоног, төхөөрөмж худалдан авах	-	-	150.0	150.0
18	Татварын хэлтсийн байрны засвар	3	Татварын хэлтэс	180.0	180.0
19	Нийтийн бие засах газар байгуулах	11	Нийтийн эзэмшлийн зам талбайд	300.0	300.0
20	Усан сан /зөөврийн/, гүний худаг засварлах	-	Нийтийн эзэмшлийн зам талбайд	80.0	80.0
21	4 хороонд жишиг гудамж байгуулах /гэрэлтүүлэг, камержуулалт, явган хүний зам бүхий/	-	Нийтийн эзэмшлийн зам талбайд	200.0	200.0
22	Цахилгааны хүчдэл сайжруулах	-	-	60.0	60.0

23	32 дугаар сургуулийн урлаг заалаңд сандал авах, хөл бөмбөг, сагсан бөмбөгийн талбай байгуулах	11	32-р сургууль	35.0	35.0
24	Соёлын Ордны засварын ажил	3	Соёлын Ордон	30.0	30.0
25	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт	15	Нийтийн эзэмшлийн зам талбайд	100.0	100.0
26	6, 7 дугаар хорооны голын засмал замын гадаргын ус зайлуулах шугам татах	6, 7	6, 7-р хорооны дунд зам	60.0	60.0
27	Төлөөлөгчдийн үйл ажиллагааңд шаардлагатай /мэдээллийн/ тоног төхөөрөмж худалдан авах	-	-	70.0	70.0
28	Гудамжны тохижилт	16	7-р гудамж	30.0	30.0
29	67 дугаар цэцэрлэгийн биеийн тамирын заалны өргөтгөл	1	67-р цэцэрлэг	21.0	21.0
30	60 дугаар сургуулийн гадна авто зогсоол	7	60-р сургууль	30.0	30.0
	Он дамжих			**621.2**	**621.2**
1	Нисэх-Яармагт 4 улирлын цэцэрлэгт хүрээлэн байгуулах	10	10 дугаар хороо	420.0	420.0
2	10, 12, 13, 14 дүгээр хороодын нутаг дэвсгэрт шинээр автобусны буудал барих	10,12, 13,14	10,12,13, 14 дүгээр хороо	90.0	90.0
3	5 дугаар хороо. Яармагийн 19, 20, 21 дүгээр гудамжны нийт 20 өрхийг цэвэр усны шугамтай холбох	5	20 дугаар гудамж	30.0	30.0
4	Зураг төсөв	-	-	81.2	81.2
	Нийт дүн			**5405.2**	**4405.2**

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй 19 төсөл арга хэмжээний ажлын явц:

Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээ:

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хороо	Төсөвт өртөг /сая.төг/
1	Явган хүний зам засах ажил	1	21.9
2	Хашаа жигдрүүлж будах	7	7.0
3	Хаягжуулалт	7	4.0
4	60-р сургуулийн урд ахмадын төвийн засвар, тохижилт	8	6.5
5	29-р цэцэрлэгийн хашаанд хүүхдийн тоглоом худалдан авах, суурилуулах	5	9.8
6	19-р байрны дэргэд тоглоомын талбайд тоглоом худалдан авах, суурилуулах, засварлах	3	35.3
7	Сонсголонгын 1-р гудамжны урд талд тоглоомын талбай засварлах	8	20.0
8	Нүхтийн 30-р гудамж цагдаагийн 2-р хэлтсийн зүүн хойд хэсэгт ахмадын төвийн засвар, тохижилт	6	16.4
9	Явган хүний зам, сүүдрэвч барих	12	14.1
10	Нийтийн эзэмшлийн зам талбай гэрэлтүүлэг	15	30.0
11	Нийтийн эзэмшлийн зам талбай гэрэлтүүлэг	4	20.0
12	Таксины зогсоол байгуулах	14	11.3
13	Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг	15	21.5
14	Нийтийн эзэмшлийн зам талбай камержуулалт	9	21.8
15	Явган хүний зам барих	5	4.1
16	Гүний худаг гаргах	13	9.5
17	Нийтийн эзэмшлийн зам талбай камержуулалт	10	23.6
18	Нийтийн эзэмшлийн зам талбай Камержуулалт	16	27.7
19	Камержуулалт	2	26.4
	Дүн		**330.9**

Хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ:

Хүснэгт-2

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хороо	Ажлын явц %	Батлагдсан төсөвт өртөг /сая.төг/
1	Гүний худаг	11	30	35.0
2	Явган хүний зам засах	4	30	3.8
	Дүн			**38.8**

Дүүрэгт 2019, 2020 онуудад хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санал ирүүлэх тухай Засаг даргын Тамгын газрын дарга, Засаг даргын Нэгдүгээр орлогчийн албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн, шаардлагатай хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний мэдээллийн сан бүрдүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар иргэдээс санал авах ажиллагаа:

Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал асуулга зохион байгуулах тухай дүүргийн Засаг даргын А/104 дугаар захирамж, ажлын төлөвлөгөөг батлуулан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал асуулгын хуудасны загварыг 16 хороо тус бүрээр боловсруулан 2017 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын тайланг оруулж дүүргийн нийт өрхийн тоогоор 47202 ширхэг саналын хуудас хэвлүүлэн хороодод хүргүүлж санал асуулга авах ажлыг хуулийн хугацаанд зохион байгуулсан.

/Саналын хуудасны урд, ар тал/

Санал асуулга авах хугацаанд хорооны Засаг дарга, Зохион байгуулагч нартай уулзаж ОНХС-н хөрөнгөөр 2019 онд хийх хөрөнгө оруулалтын санал асуулгын явцтай танилцаж, гарын авлагаар ханган мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

/Хороодын албан хэрэгцээнд зориулж тараасан гарын авлаганы нүүр/

Санал асуулгад 16 хорооны нийт өрхийн 75,6 хувь буюу 35723 саналын хуудсаар, давхардсан тоогоор 176633 санал ирүүлсэн.

Дүүрэгт хэрэгжүүлэх шаардлагатай төсөл арга хэмжээний 71303 ширхэг санал ирсэн бөгөөд дараах 4 төсөл, арга хэмжээ хамгийн их санал авсан байна.

1. Камержуулалт хийх санал хамгийн өндөр буюу 21209 ширхэг
2. Цэцэрлэгт хүрээлэн байгуулах санал 17050 ширхэг
3. Автомашины далд ба ил зогсоол 16721ширхэг
4. Гэрэлтүүлэг хийх санал 16323 ширхэг

Хороонд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл арга хэмжээний 71303 санал ирсэн бөгөөд дараах 4 төсөл, арга хэмжээ хамгийн их санал авсан байна.

1. Орчны тохижилт хамгийн өндөр буюу 19686 ширхэг
2. Явган зам тавих ажил 18849 ширхэг
3. Гэрэлтүүлэг хийх санал 16515 ширхэг
4. Усан сан худаг барих санал 11151 ширхэг

Сангийн сайдын 43-р тушаалын 7.3-д заасан дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой 40 төрлийн төсөл арга хэмжээний 19261 санал ирсэн. Үүнээс орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжгүй болон зохион байгуулалтын шинжтэй 57 төрлийн 19868 саналыг хасаж эрэмбэлэгдсэн жагсаалтыг хороодын Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн. 2018 оны 09 дүгээр сарын 06-21-ний өдрүүдэд дүүргийн 16 хорооны нутаг дэвсгэрт хэрэгжих төсөл,арга хэмжээний байршлыг газар дээр очин зурагжуулж жагсаалтыг бэлтгэн 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдөр ДИТХ-д өргөн барьсан. 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 06 дугаар тогтоолоор дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 629.8 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт:

Хүснэгт-1

№	Хороо	Төсөл арга хэмжээний нэр	Байршил	Төсөвт өртөг /сая.төг/
		Он дамжих		**22,017.3**
1	4	Явган хүний зам засах	Нийтийн эзэмшлийн талбайд	3,819.8
2	11	Гүний худаг	Нийтийн эзэмшлийн талбайд	18,197.5
		Шинэ		**629,859.1**
1	1,3	Камержуулалт	Нийтийн эзэмшлийн талбайд	68,171.7
2	2,5	Камержуулалт	Нийтийн эзэмшлийн талбайд	67,076.9

3	3,4	Гэрэлтүүлэг	Нийтийн эзэмшлийн талбайд	72,966.4
4	6,8	Камержуулалт	Нийтийн эзэмшлийн талбайд	67,288.5
5	9	Камержуулалт	Нийтийн эзэмшлийн талбайд	34,000.5
6	10,12	Гэрэлтүүлэг	Нийтийн эзэмшлийн талбайд	67,544.5
7	11	Гэрэлтүүлэг	Нийтийн эзэмшлийн талбайд	63,685.1
8	7,13,14	Камержуулалт	Нийтийн эзэмшлийн талбайд	52,648.5
9	15	Гэрэлтүүлэг	Нийтийн эзэмшлийн талбайд	88,560.1
10	16	Гэрэлтүүлэг	Нийтийн эзэмшлийн талбайд	47,916.9



2018 оны 3 дугаар сарын 26-ны өдөр 2, 6-р хороодын 18 хэсгийн ахлагч, хорооны иргэдэд цахимаар санал авах аппликейшны сургалтыг Хотын засаглалыг сайжруулах төслийн ажилтнуудтай хамтран зохион байгуулж иргэдээс цахимаар санал авах туршилтыг зохион байгуулж 4 дүгээр сарын 18-нд хаалт хийсэн.

"Нээлттэй Улаанбаатар" мэдээллийн системд дүүргийн төсвийн хөрөнгө, ОНХСангийн хөрөнгөөр 2018 онд хэрэгжүүлэх 40 төсөл арга хэмжээний мэдээллийг шивж байршуулсан.

Дүүргийн Засаг даргад эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээ:

Нийслэлийн Засаг даргын захирамжаар 6.2 тэрбум төгрөгийн 9 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх дүүргийн Засаг даргад шилжин ирсэн.

Дээрх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг түргэн шуурхай зохион байгуулах зорилгоор дүүрэгт Үнэлгээний хороодыг холбогдох хууль, журмын дагуу байгуулж нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газар болон холбогдох бусад газруудад зураг төсөв, баримт бичгийг ирүүлэх хүсэлт гарган худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж, 9 төсөл арга хэмжээний дунджаар хэрэгжилт 85 хувь байна.

Дүүргийн Засаг даргад худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээний жагсаалт:

№	Ажлын нэр	Хороо	Эх үүсвэр	2018 онд санхүүжих	Захирамж №
1	26 дугаар сургуулийн дээвэр засварын ажил	13	НОНХС	80.0	2018.03.02 А/199
2	Цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих, 240 ор /28 дугаар цэцэрлэг/	3	УТХО	1100	А/209 2018.03.02
3	41-р цэцэрлэгийн цэцэрлэгийн их засвар	3	НТХО	110.0	2018.01.26 А/80
4	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /114-р сургуууль/	10	УТХО	800	А/209 2018.03.02
5	Цэцэрлэгийн барилга, 150 ор /4-р сувилал/	3	УТХО	900	А/209 2018.03.02
6	13-р хорооны 1 дүгээр хэсгийн 2, 5 дугаар байрны фасад засварын ажил	13	НОНХС	30.0	А/357 2018.04.24
7	Гудамж талбайн камержуулалт	4, 5, 6, 7, 8	УТХО	354.0	А/350 2018.04.20
8	Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дулааны шугам сүлжээ, дэд станц	11, 15	УТХО	2600.0	А/323 2018.04.
9	Ухаалаг худгийн барилга, тоног төхөөрөмж	13	УТХО	300.0	А/697 2018.08.02
	Нийт дүн			**6,274.0**	

Графикаар харуулбал:



Дэд бүтэц, дахин төлөвлөлтийн ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Дэд бүтцийн төвд хамрагдах өрхийн төлөөлөлд 2 удаагийн сургалт зохион байгуулж 10 иргэдийн бүлэг байгуулан тэдгээрийн санал хүсэлтийг холбогдох байгууллагад уламжилснаар 9 дүгээр хорооны 9,10 дугаар хэсэг, Центр, Буянт-Ухаа 23-р гудамжны нийт 15 га газарт 200 нэгж талбарыг хамарсан Дэд бүтцийн төв байгуулах ажлын байршил

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 07 дугаар сарын 9-ний өдрийн 118 дугаар тогтоолоор батлагдсан. “Дэд бүтцийн төв”-н зураг төслийг “Palm Deirah” ХХК урьдчилсан байдлаар боловсруулан гүйцэтгэзд байна.

Дүүргийн 11, 15 дугаар хороонд Улсын төсвийн 3,6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 2018-2019 онд хэрэгжих инженерийн шугам сүлжээ, дэд станц шинээр барих ажлын техникийн нөхцөл гаргуулсан. Гүйцэтгэгчээр “Бумба-Од” ХХК шалгаран зураг төслийн ажлыг гүйцэтгэж байна.

Ус сувгийн удирдах газарт дүүргийн төсвийн 30 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжих 5-р хорооны 19, 20, 21 гудамжны 20 өрхийг цэвэр усны шугамд холбох техникийн нөхцөл гаргуулсан. Худалдан авах ажиллагааны албанд тендерийн бичиг баримт боловсруулагдаж байна.

Нийслэлийн зураг төслийн хүрээлэнгээс 4, 5, 6, 7, 8, 9, 15 дугаар хороодод 2025 он хүртэл хэрэгжих 30,2 км авто замын танилцуулга хийх ажлыг зохион байгуулж, тухайн байршилд оршин суух иргэдээс судалгаа авах хуудас тараасан.

Нисэх, Яармаг орчимд 2025 он хүртэл хэрэгжих 30,2 км авто замын төлөвлөгөөний зураг.

Дүүргийн Усан байгууламжуудын бүртгэл, ашиглалт хамгаалалт, засвар үйлчилгээг сайжруулах ажлын хүрээнд тус дүүрэгт улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр барьж, байгуулагдсан ашиглалтад оруулсан усан байгууламжийн ашиглалтын судалгааг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны дахин төлөвлөлтийн ажил:

Дүүргийн 4, 6, 13 дугаар хорооны иргэдээс “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулгах үйл ажиллагаа”-ны санал авч нэгтгэн Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газарт уламжилж, дүүргийн 3 дугаар хороо Ногооны 36 дугаар байрыг дахин төлөвлөлтөд хамруулж, барилгажуулах шийдвэр гаргаж өгөх хүсэлтийг Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газарт хүргүүлсэн. Дүүргийн нутаг дэвсгэрт орших 32 орон сууцны байрыг дахин барилгажуулахаар 11 багцад хувааж, төлөвлөлт хийснээс, 7 багцын 27 байранд төсөл гүйцэтгэгч шалгарч дахин төлөвлөлтийн ажил явагдаж байна. Үүнд баригдаж дууссан 5, баригдаж буй 5, барилгыг буулгасан 2, ажил эхлээгүй 15 дахин төлөвлөлтийн барилга байна. Улдсэн 4 багцын багц-6 /10 дугаар хороо Нисэхийн 34, 35/, багц-8 /12 дугаар хороо Биокомбинатын 39/ , багц-9 /3 дугаар хороо, Арьс ширний 31/, багц- 11 /Сүрьеэгийн эмнэлгийн ажилчдын 20 дугаар байр/ нийт 5 барилгыг буулган шинээр барих төсөл

хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах урилгыг өдөр тутмын хэвлэлд 10 гаруй удаа нийтэлсэн боловч санал ирээгүй улмаас гүйцэтгэгч шалгараагүй тул сонгон шалгаруулалтын урилгыг 11 дүгээр сарын 21-ны өдөр дахин нийтлүүлээд байна. Мөн багц-6 /10 дугаар хороо Нисэхийн 34, 35 байр/-ын дахин төлөвлөлтийг эрчимжүүлэх зорилгоор УИХ-н гишүүн Б.Энх-Амгалан, Барилга хот байгуулалтын яам, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид, Төрийн орон сууцны корпороцид тус тус 2018 оны 09 дүгаар сарын 17-ны өдрийн 03/450, 03/453 дугаар албан бичгээр уламжилсан.

АШХНЗОС-ны дахин төлөвлөлтийн ажлын явцын мэдээлэл.

ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН АЖЛЫН ЯВЦ /БАГЦ ТУС БҮРЭЭР/

1-р багц: 2-р хороо, Нэхмэлийн 1, 2, 5, 6, 7, 10, 11, 16-р байр

Гүйцэтгэгч: "Фүжи холдинг" ХХК

2-р багц: 2-р хороо, Нэхмэлийн 12, 13, 17, 18-р байр
Гүйцэтгэгч: "Фүжи холдинг" ХХК

3-р багц: 3-р хороо, Нэхмэлийн 14, 15, 19-р байр
Гүйцэтгэгч: "Нутгийн буян групп" ХХК

4-р багц: 3-р хороо, Нэхмэлийн 3, 4, 8, 9-р байр
Гүйцэтгэгч: "Эм Эм Жи Капитал" ХХК

5-р багц: 3-р хороо, АШ 25, 26-р байр Эрчим хүчний 21, Талхны 20
Гүйцэтгэгч: АШ 25 байр “Эфэс констракшн” ХХК, АШ 26 байр “ОХС” ХХК

7-р багц: 2-р хорооны БҮК 53, 54-р байр 0.42 га талбайд
Гүйцэтгэгч: “Шинэ гэр түншлэл” ХХК

10-р багц: 11 дүгээр хороо 36а, 36б байр
Гүйцэтгэгч: “Цэнгэлдэх ОСНААК” ХХК

ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН АЖИЛ ЭХЛЭЭГҮЙ БАГЦЫН МЭДЭЭЛЭЛ:

Дүүргийн 5-р хороо арьс ширний 80 айлын орон сууцны 10 дугаар байрыг буулгаж, 40 айлын орон сууцны барилгыг 2018 оны 12-р сард Улсын комисс ашиглалтад хүлээн авахаар ажиллаж байна.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 100 сая төгрөгийн хөрөнгөөр 2, 9, 10, 16 дугаар хороодод хэрэгжих нийтийн эзэмшлийн талбайд камержуулах, гэрэлтүүлэг хийх цэгийн дэлгэрэнгүй судалгааг холбогдох байгууллагуудтай хамтран судалсан. Камержуулалтын ажлын зургийн даалгаврыг боловсруулж дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүлээлгэн өгсөн. Ажлын зураг төсвийг “Оргилт-Од” ХХК гүйцэтгэсэн. Дүүргийн 9, 10, 16 дугаар хорооны камержуулах ажлыг “ЛЭДСИТИ” ХХК, 2 дугаар хорооны камержуулах ажлыг “Хунт Угалз Сайхан” ХХК тус тус гүйцэтгэж байна.

Дүүргийн 4, 15-р хороонд 3 байршилд 71,5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн ажлын зургийн даалгаврыг боловсруулж Худалдан авах ажиллагааны албанд хүлээлгэн өгсөн. Ажлын зураг төсвийг “Оргилт-Од” ХХК

гүйцэтгэсэн. Гэрэлтүүлэг угсралтын ажлыг “СБМ” ХХК болон “Тэнгэр цэгцрээ” ХХК хийж гүйцэтгэсэн.

БАРИЛГА, ЗУРАГ ТӨСЛИЙН АЖИЛ, ҮР ДҮНТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ:

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд:

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 4, 5, 6, 7, 8–р хороодод суурилуулах камержуулалтын ажлын даалгаврыг боловсруулан батлуулж худалдан авах ажиллагааны албанд хүргүүлэв. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 13-р хорооны 2,5 дугаар байрны фасад засварын ажлын төсвийг хийлгүүлэн Барилгын хөгжлийн төвд магадлал хийлгүүлэв.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд:

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 41 дүгээр цэцэрлэгийн гадна фасад засварын ажлын зураг төсвийг нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас авч техникийн тодорхойлолтыг боловсруулан Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн.

Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд:

Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газарт дүүргийн төсвийн хөрөнгө, дүүргийн орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний /зургийн/ нийт 22 ажлын даалгаврыг боловсруулан Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн.

Дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд тендер зарлах шаардлагатай ажлын зураг төсөв, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн боловсруулж хүлээлгэн ажиллав. Үүнд:

- 14 ажлын Зураг төсөвт магадлал
- 18 ажлын Техникийн тодорхойлолт
- 37 ажлын зургийн даалгавар тус тус боловсруулж батлуулан холбогдох газарт хүргүүлэн ажиллалаа.

Явцын болон гүйцэтгэлийн техник хяналтаар нийт 64 удаа ажилласан.

“Монголиан Артизан Чийзмэйкерс Юнион” ХХК-ний 150.000 долларын хөрөнгө оруулалтаар ашиглалтанд орсон, 12- хорооны нутаг дэвсгэрт байрлах бяслагны “MACU” үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

“Хорооны хөгжил-Төрийн үйлчилгээ” хөтөлбөрийн ажлын хүрээнд Нийслэлийн МХХ-т тус дүүргийн 12 дугаар хорооны Нэг цэгийн үйлчилгээний байрны барилгын төлөв байдалд дүгнэлт

гаргуулахаар албан бичиг хүргүүлж, Улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсан. 2018 оны 03 дугаар сарын 22-ны өдөр "Тохижилт, төрийн үйлчилгээг сайжруулах жил"- ийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлж байгаа 56 аж ахуйн нэгж байгууллагуудын дунд "Бүтээн байгуулалт-Хамтын ажиллагаа 2018" зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан.

Дээрх зорилтот ажлын хүрээнд иргэдэд төрийн үйлчилгээг тав, тухтай нөхцөлд шуурхай хүргэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хорооны нэг цэгийн үйлчилгээний барилгын засварын ажлын тооцоо, судалгааг хийж, 9-р хорооны нэг цэгийн үйлчилгээний байрны гадна фасад, дээвэр, нэг цэгийн үйлчилгээний заалны засварын ажил хийгдсэн.

Дүүргийн төсвийн 27.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 15-р сургуулийн Спорт заалны засварын ажил хийгдсэн.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 20.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1 дүгээр хорооны явган хүний зам засварын ажил хийгдсэн.

Дүүргийн төсвийн 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 15 дугаар хороо 130-р сургуулийн урд талын явган хүний замын тохижилтын ажил хийгдсэн.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 11.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 7 дугаар хорооны хашааг будаж жигдрүүлэх, хаягжуулах ажил хийгдсэн.

Дүүргийн төсвийн 30.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 дугаар хороо Дэнжийн 2-р, Сонсголонгийн 5-р гудамжийг жишиг гудамж болгон тохижуулах ажил хийгдсэн.

1.4 Үндэсний хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, НИТХ-аар батлагдсан, дүүргэт хэрэгжиж байгаа үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн 2017 он, 2018 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн.

Дүүргийн хэмжээнд Үндэсний хөтөлбөр “Хууль эрх зүй, төрийн захиргаа”-ны салбарт 4, “Байгаль орчин, дэд бүтэц”-ийн салбарт 7, “Эрүүл мэнд нийгэм, соёл боловсрол”-ын салбарт 13 , “Хүнс хөдөө аж ахуй”-н салбарт 7 буюу нийт 31 үндэсний хөтөлбөр хэрэгжиж байгаагаас 2017 оны жилийн эцсийн хэрэгжилт 90,1 хувь, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 85 хувьтай хэрэгжсэн байна.

Засгийн Газрын 89 дүгээр тогтоолын дагуу дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдалд хяналт, шинжилгээ хийж, Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тайлагнах, гүйцэтгэлийн дүгнэлт гаргах, хөтөлбөрийн “Хувийн хэрэг” хөтлөх талаар арга зүйн зөвлөгөө өгөх, холбогдох эрх зүйн актуудыг танилцуулах зорилгоор хөтөлбөр хариуцсан 24 албан хаагчдад 9 дүгээр сарын 7-ны өдөр арга зүйн сургалт зохион байгуулсан.

Сургалтын үр дүнд дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй бүх хөтөлбөрүүдэд шинээр мэдээллийн сан үүсгэж, хөтөлбөр бүрт цахим "Хувийн хэрэг" бий болгосон.

Үндэсний болон нийслэл, дүүргийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн 2017 он, 2018 оны эхний хагас жилийн тайлан, гүйцэтгэлийн дүгнэлтийн талаар Нийслэл дэх төрийн Аудитын газрын шалгалтын ажлын хэсэгт тайлбар өгч, холбогдох материалуудыг цахимаар хүргүүлсэн.

а) "Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилт

МУЗГ-ын 2016 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан "Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2018.03.06-ны өдрийн А/76 дугаар захирамжаар шинэчлэн байгууллаа. Хан-Уул дүүргээс 2018 онд нийт 884 өрхийг сонгож, өрх бүрээр дэлгэрэнгүй судалгаа гаргасан. Зорилтот өрхүүдийн амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр хариуцаж, хамтран ажиллах хэлтэс, албадын хуваарийг гаргасан.



- ✓ Тус дүүргийн 4 дүгээр хорооны зорилтот 2 өрхөд ТББ-аас гэр олгуулах тухай хүсэлт тавьж шийдвэрлүүллээ. /4 дүгээр хорооны иргэн Б.Энхболд, Г.Солонго/
- ✓ Хэрэгцээгээр нь ангилсан судалгаанд үндэслэн төрийн үйлчилгээг 874 иргэнд хүргэсэн.
- ✓ Сайн үйлсийн аян-102 иргэн
- ✓ Олон Улсын болон төрийн бус байгууллагын тусламж-69 өрх
- ✓ Хөдөлмөр эрхлэлт-Байнгын ажлын байр-24, Түр ажлын байр-53
- ✓ Иргэдийн зан үйл, дадал хэвшлийг өөрчлөх сургалт, сурталчилгаа- 559 иргэн тус тус хамрагдаад байна.

b) Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Жендэрийн салбар хорооноос Жендэрийн талаарх статистикийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардагдах жендэрийн статистик тоо мэдээллийг бүрдүүлж, дүүргийн бодлого боловсруулах түвшний ажилтнуудад хүргэн ажиллаж байна. Дүүргийн хүн ам 2017 оны эхний байдлаар 159465 хүн амын 75821 буюу 47,55 хувь эрэгтэй, 83644 буюу 52,45 хувь нь эмэгтэй байсан бол 2018 оны эхний байдлаар 169726 хүрснээс хүйсээр нь авч үзвэл 80603 буюу 47,49 хувь нь эрэгтэй, 89123 буюу 52,51 хувь нь эмэгтэй болж өссөн байна.





c) "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хэрэгжилт

Өрхийн хөгжлийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 884 өрхийн орон сууцны нөхцөлийн судалгааг гаргасан. Судалгаанд хамрагдсан өрхийн 445 өрх гэр, 382 өрх орон сууцанд /үүнээс: орон сууцны байшин 133, бие даасан тохилог сууц 184, оюутан, ажиллагчдын тохилог сууц 12, нийтийн зориулалтын бусад байр 63/, зориулалтын бус сууц 17, бусад хэлбэрийн 30 өрх байна. Тайлант хугацаанд 61 ахмад настан, 12 хөгжлийн бэрхшээлтэй иргэний "Түрээсийн орон сууц"-нд орох хүсэлтийг хүлээн авч судалгаанд нэгтгэж, 15 ахмад настны түрээсийн орон сууцанд хамрагдах хүсэлтийг ТОСК-д уламжилсан

d) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих хөтөлбөр

e) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх, асрамж халамжийн үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулан ажилласан.

f) Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2018 оныг "Иргэдийн оролцоотой-Амьдрах орчныг сайжруулах жил" болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018 оны А/44 дүгээр тушаалаар "Манай хороо-Миний гудамж" аяныг зарласан.

Энэхүү аяны хүрээнд дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний салбар зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийтийн ээмшлийн гудамж, зам талбай хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байгаа эсэхэд үнэлгээ хийх ажлыг "Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо"-той хамтран зохион байгууллаа.

Хан-Уул дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөлөөс 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөгөө боловсруулсан. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дараах ажлуудыг хэрэгжүүлээд байна. Үүнд:

- ✓ Нийгмийн халамжийн сан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж авч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг шинэчлэн гаргасан.

- ✓ "Монголын Рояаль Академи"-тай хамтран 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр "Эрүүл, аз жаргалтай ирээдүй" сайн үйлсийн аян, өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үйл ажиллагаанд тус дүүрэгт оршин суух буй байгууллагын асаргаатай, хөгжлийн бэрхшээлтэй 0-4 насны хүүхдүүд, тэдний эцэг эхчүүд нийт 100 гаруй хүн оролцсон. Үйл ажиллагаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний эцэг эхчүүдэд "Анунгоо" фармын мэргэжлийн эмч нар эрүүл мэндийн болон эмийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл зөвлөгөө өгч, нэг сарын витамины хэрэглээ болон ивээн тэтгэгчдийн гарын бэлэг гардууллаа.

- ✓ Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс хамтран 2018.05.24-ний өдөр зохион байгуулсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн өдөрлөг"-т оролцсон нийт 250 гаруй хүүхдэд "АПУ" ХК, "Витафит" группээс нийгмийн хариуцлагын хүрээнд бэлэг гардуулж, мэндчилгээ дэвшүүллээ

1.5 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

Нийслэлийн Засаг дарга болон Хан-Уул дүүргийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны "Аз жаргалтай хот" хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үр дүнгийн гэрээний төслийг боловсруулан нийслэлийн Засаг даргын Орлогч нар болон НЗДТГ-ын хэлтэс, албадын дарга, холбогдох мэргэжилтнүүдээс саналын хуудсаар санал авч, гэрээний төслийг 2018 оны 02 дугаар сарын 02-нд НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүлээлгэн өгч 02 дугаар сарын 05-нд үр дүнгийн гэрээ байгуулах ажил зохион байгуулагдсан.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны "Аз жаргалтай хот" хөтөлбөрөөс дүүрэг хариуцан хэрэгжүүлж буй 37 төсөл арга хэмжээ 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 78,9 хувь, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлээс дүүрэг хариуцан хэрэгжүүлж буй 11 төсөл арга хэмжээ 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 70 хувьтай хэрэгжсэн.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны "Аз жаргалтай хот" хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2018 оны биелэлтийг жилийн эцсийн байдлаар тооцож хэрэгжилт үр дүнг 2019 оны 01 сарын 05-ны дотор ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнахаар ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зохион байгуулалтын ажлуудаас:

Хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр:

Дүүргийн жижиг дунд бизнес эрхлэгчид болон шинээр бизнес эрхлэх сонирхолтой иргэдийг дэмжих зорилгоор "Оюуны өмчийг патентжуулах, маркетинг менежмент, фэйсбүүк хандалтыг хэрхэн нэмэгдүүлэх" сэдэвт сургалтыг зохион байгуулан жижиг дунд үйлдвэр эрхлэгч 48 иргэнийг хамруулсан.Орон сууцны нэг болон суурийн давхарт үйл ажиллагаа явуулж буй нийт 321 цайны газар, сүлжээ хоолны газар,

ресторан, баар, кафе, хүнсний дэлгүүр, минимаркет, супермаркетын нарийвчилсан судалгааг 3 удаа гаргаж, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэстэй хамтран 2 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Тохижилт, нийтийн аж ахуйн чиглэлээр:

Бүх нийтийн их цэвэрлэгээг 12 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 18117 ААНБ, 36358 иргэнийг хамруулан, гадна орчны цэвэрлэгээг хийлгэж 1626.2 тонн хог хаягдлыг 285 рейсээр төвлөрсөн хогийн цэгт ачиж тээвэрлэсэн.

Гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Жорлонгоо ариутгаж, хөрсөө хамгаалъя" аяныг зохион байгуулсан.

Суурьшлын бүсийн хөрсний доройтол ихтэй, бохирдсон газруудын судалгааг гаргаж, бохирдол ихтэй хогийн цэг, гуу жалга, нийтийн эзэмшлийн зам, талбай, жорлон дүүрч хальсан болон өтөг буудтай хашаа, гудамжнуудад 4 удаа ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулж гэр хорооллын нийт 3096 нүхэн жорлон, 573 бохирын цооног, нийтийн эзэмшлийн 409468 м^2 талбайг ариутган халдваргүйжүүлсэн. Дүүргийн нутаг дэвсгэрт хөрсний бохирдлын судалгааг үе шаттайгаар хийж хэрэгжүүлэн дүгнэлт гаргасан.

1.6 Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан, тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

Сууц өмчлөгчдийн холбоотой холбогдох асуудлыг судалж, түүний үйл ажиллагааг тодорхой болгон, норматив стандартыг бий болгох ажлын хүрээнд:

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Сууц өмчлөгчдийн холбоодын мэдээллийг шинэчлэн бүртгэлжүүлж "Эко Хан-Уул мэдээллийн сан"-д байршуулах зорилгоор СӨХ-дын хуучин гэрчилгээг шинэчлэн баталгаажуулж шинээр олгох ажлыг гүйцэтгэсэн. Одоогоор дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 193 сууц өмчлөгчдийн холбооны 157 нь гэрчилгээгээ шинэчлүүлсэн. Дүүргийн нутаг дэвсгэрт 2017 оннд 187 СӨХ, 2018 оны байдлаар 205 үйл ажиллагаа явуулж байна.

1.7 Дэд хөтөлбөрт тусгасан, тухайн байгууллагаас гүйцэтгэх ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

Тус дүүргийн хэмжээнд "Хууль эрх зүй, төрийн захиргаа"-ны салбарт 5, "Байгаль орчин, дэд бүтэц"-ийн салбарт 2, "Эрүүл мэнд нийгэм, соёл боловсрол"-ын салбарт 7 , "Хүнс хөдөө аж ахуй"-н салбарт 6 буюу нийт 20 нийслэлийн дэд хөтөлбөр хэрэгжиж байгаагаас 2017 оны жилийн эцсийн хэрэгжилт 91,8 хувьтай хэрэгжсэн.

Үндэсний болон нийслэл, дүүргийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн 2017, 2018 оны эхний хагас жилийн тайлан, гүйцэтгэлийн дүгнэлтийн талаар Нийслэл дэх төрийн Аудитын газрын Нийцлийн аудитын хэлтсийн шалгалтын ажлын хэсэгт ажлаа тайлагнан холбогдох материалуудыг хүргүүлсэн.

2017 оны нийслэлийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тооцон хуулийн хугацаанд НЗДТГ-ын ХШҮХ-т тайлагнасан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулан ДИТХ-аар батлуулсан "Ахмадаа дээдэлье", "Зөв хүн-Зөв ирээдүй", "Аз жаргалтай гэр бүл" , "Эко дүүрэг ногоон сургууль" хөтөлбөрүүдийг 2 дахь жилдээ хэрэгжүүлж байна.

2018 жилийн эцсийн байдлаар дүүргийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайланг хариуцсан хэлтэс, албадаар гаргуулан явц, үр дүнг тооцсон.

Дүүргийн дэд хөтөлбөрүүдийн биелэлт

/ 2018 оны



Дүүргийн дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлуудаас:

ЗӨВ ХҮҮХЭД-ЗӨВ ИРЭЭДҮЙ ХӨТӨЛБӨР

Хэрэгжүүлсэн төсөл үйл ажиллагааны тоо	Батлагдсан төсөв	Зарцуулсан төсөв	Төсвийн зарцуулалтын хувь
16	150,000,000		хувь

Хөтөлбөрийн үр дүн:

- Хөтөлбөрийн хүрээнд Дүүргийн ЕБС-ийн сурагч, багш, ажилтан, СӨБ-д хамрагдсан хүүхэд, багш ажилтан нийт 37535 хүний 84,7 хувь буюу 31807 хүүхэд, багш, ажилтныг боловсрол, соёл урлаг, спортын үйлчилгээнд хамруулсан байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн.
- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарт ахиц гарсан.
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын орчин нөхцөл сайжирсан.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 250.000.000 төгрөг батлагдсанаас 92.055.371 төгрөг зарцуулсан. Үүнээс:
  - 27,8 хувийг бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтад
  - 5,4 хувийг сурталчилгаа мэдээллийн ажилд
  - 51,5 хувийг хүүхэд залуучууд, багш ажилтны нийгмийн хөгжил, хамгаллын үйлчилгээнд
  - 15,2 хувийг сургалт, туршлага судлах үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ зорилт бүрээр

1-р зорилтын хүрээнд

1. 41 дүгээр цэцэрлэгийн харъяа ЗДТГ-ын Эко цэцэрлэгийн 1-8 дугаар сарын түрээсийн зардлыг төлөв. 7 200 000 төгрөгийг хөтөлбөрөөс санхүүжүүлэн үйл ажилагааг хэвийн явуулсан.

2. Хан-Уул дүүргийн 73 дугаар цэцэрлэгийн шинэ өргөтгөлийн бүлэгт зөөлөн эдлэл олгох төсөл хэрэгжүүлэв. Төслийг хэрэгжүүлэхэд нийт 1.617.000 төгрөгийг зарцуулсан.
3. Хан-Уул дүүргийн 60-р сургуулийн спорт заалны шалны засварыг хийв. Хөтөлбөрөөс нийт 20.500,000 төгрөгийг зарцуулсан.

2-р зорилтын хүрээнд

1. Хан-Уул дүүргийн 60-р сургуулийн сурагч Д.Цэвээндуламын ХБНГУ-ын Берлин хотод болох олон улсын EASTER CUP сагсан бөмбөгийн тэмцээнд оролцох замын зардлыг шийдвэрлэсэн. Нийт 25000 төгрөгийн замын зардлыг олгож дэмжлэг үзүүллээ.
2. Хан-Уул дүүргийн 7 дугаар хорооны иргэн Ц.Алтанзулын Ливан улсын Бейрут хотод болох жудо бөхийн олон улсын тэмцээнд оролцох замын зардлыг шийдвэрлэсэн. Нийт 1 000 000 төгрөгийн дэмжлэг үзүүллээ.
3. Хан-Уул дүүргийн сурагчдын бүжгийн хамтлаг БНХАУ-ын Манжуур хотод зохион байгуулагдах тэмцээнд оролцох төслийг хэрэгжүүлсэн. Төсөлд нийт 3 499 920 төгрөгийг зарцуулсан.
4. Хан-Уул дүүргийн ЕБС-ийн 5 сурагч Япон улсын Мусашираяама хотын төрийн байгууллагатай хийсэн гэрээний дагуу сурагч солилцооны хөтөлбөрт хамрагдав. Төслийг хэрэгжүүлэхэд хөтөлбөрөөс 13731451 төгрөгийг зарцууллаа

3-р зорилтын хүрээнд

1. "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"- ийг хороодод тэмдэглэн өнгөрүүлэх, баярт оролцох хүүхдэд өгөх бэлэг өгөх төслийг хэрэгжүүллээ. Төслийг хэрэгжүүлэхэд хөтөлбөрөөс 15 000 000 төгрөг зарцууллаа.

2. ЕБС-ийн 12 дугаар анги төгсөгч болон их дээд сургуулийн оюутан залуучууд чанартай боловсрол эзэмшихэд мэргэжил сонголт хэрхэн нөлөөлж буйг судлах, сурагчдын мэргэжил сонголтод төрийн бодлого дэмжлэгийг хүргэх "Сэтгэлийн үндэс" төсөл хэрэгжүүлэв. Тус төслийг хэрэгжүүлэхэд хөтөлбөрөөс 5 000 000 төгрөг зарцуулсан.

4-р зорилтын хүрээнд

1. Дүүргийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын бага хурал зохион байгуулах төслийг хэрэгжүүлэхэд хөтөлбөрөөс 3,000,000 төгрөг зарцуулсан.
2. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, нийгмийн ажилтнууд 20 хүн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймаг, Хөх хотод сургалтад хамрагдах зардал шийдвэрлэв. Төслийг хэрэгжүүлэхэд хөтөлбөрөөс 6000000 төгрөг зарцуулсан.
3. Монголын багш нарын баяр уртан сурагчдын дунд зохион байгуулсан ажлын үр дүнг дүгнэж ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулах төслийг хэрэгжүүлэхэд хөтөлбөрөөс 4500000 төгрөг зарцуулсан.

5-р зорилтын хүрээнд

1. Элсэлтийн шалгалтын сорилго шалгалтыг зохион байгуулахад ашиглах хариултын хуудсаар тест засах машин, программ хангамжийг төслийн хүрээнд нийлүүллээ. 3.500.000 төгрөгийг зарцуулсан.

6-р зорилтын хүрээнд

Хатрек ХХК-ийн Эко телевизийн хэрэгжүүлэх байгаль орчноо хайрлан хамгаалахад хүүхэд, залуучууд, иргэдийг уриалах агуулгаар бүтээсэн сурталчилгааны нэвтрүүлгийг түгээх зорилгоор "Тархиа ногооноор цэнэглэе" төслийг хэрэгжүүллээ. Төслийг хэрэгжүүлэхэд хөтөлбөрөөс 5.000.000 төгрөгийг шийдвэрлэсэн.

"АХМАДАА ДЭЭДЭЛЬЕ" ХӨТӨЛБӨР

Хэрэгжүүлсэн төсөл үйл ажиллагааны тоо	Батлагдсан төсөв	Зарцуулсан төсөв	Төсвийн зарцуулалтын хувь
7	100,000,000	90,201,000	90,2

Хөтөлбөрийн үр дүн:

- Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд нийт ахмад настны 56,8 хувь буюу 8320 ахмадыг боловсрол,соёл урлаг, эрүүл мэнд, спортын арга хэмжээнд хамруулсан.
- Төр болон төрийн бус байгууллагуудын ахмад настангуудад чиглэсэн үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн.
- Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах, эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй, эелтэй орчинг бүрдүүлэх, идэвх оролцоог нэмэгдүүлэхэд ахиц гарсан.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 100.000.000 төгрөг батлагдсанаас 90.201.000 төгрөг зарцуулсан. Үүнээс:
  - 11 хувийг бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтад
  - 5,5 хувийг сурталчилгаа мэдээллийн ажилд
  - 79,3 хувийг ахмад настны нийгмийн хөгжил, хамгааллын үйлчилгээнд
  - 4,2 хувийг сургалт, туршлага судлах үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ, зорилт бүрээр

1 дүгээр зорилтын хүрээнд

1. Сар шинийн баярыг угтан хороодоос ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор 1, 2, 3, 11, 15 дугаар хороо 2,500,000 төгрөг, 4,5, 6, 7, 8 дугаар хороо 2,500,000 төгрөг, 9, 10, 16 дугаар хороо 1,500,000 төгрөг, 12, 13, 14 дүгээр хороо 1,500,000 төгрөг, нийт 8,000,000 төгрөгийг "Ахмадаа дээдэлье" хөтөлбөрөөс санхүүжүүлсэн.

2 дугаар зорилтын хүрээнд

1. Хан-Уул дүүргийн зорилтот өрхийн 269 ахмад настанг ахмадын зориулалттай амралт, сувиллын газарт амруулах тухай 2018.03.21-ний өдрийн 4/15, 4/16, 4/17, 4/18, 4/19 тоот гэрээг байгуулж, хөтөлбөрөөс нийт 13,450,000 төгрөгийг санхүүжүүлсэн.
2. Дүүргийн 4 дүгээр хорооны иргэдэд үйлчлэх байранд ахмад настнуудын уламжлалт эмчилгээ, сувилгаа хийх төвийг байгуулахаар засварын ажил 90%-тай хийгдээд байна. Ахмадын өрөөг тохижуулах хаш чулуун ор, агаар цэвэршүүлэгч, хичээл сургалтын зориулалтаар 40 инчийн телевизор зэрэг тоног төхөөрөмжийг худалдан авч хөтөлбөрөөс 9,900,000 төгрөгийг санхүүжүүлсэн.

3 дугаар зорилтын хүрээнд

1. "Амар байна уу Хан-Уул аа" сар шинийн түмэнтэйгээ золгох баярын нэвтрүүлгийг Улаанбаатар хот, хөдөө орон нутгийн нийт 21 телевизээр иргэдэд хүргэсэн. Баярын нэвтрүүлгийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт 5,000,000 төгрөгийг хөтөлбөрөөс санхүүжүүлсэн.
2. Хан-Уул дүүргийн Ахмадын хорооноос гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр ӨМӨЗО-ны Хөлөн буйр Баруун сөнөд хошууны ахмадын хороотой ажлын туршлага солилцох сургалт семинарт Ахмадын хорооны дарга, ажилтнууд, хороодын Ахмадын зөвлөлийн дарга нар, ахмад настнуудын төлөөлөл нийт 50 хүн хамрагдлаа. Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт 3,800,000 төгрөгийг хөтөлбөрөөс санхүүжүүлсэн.

4 дүгээр зорилтын хүрээнд

1. "Замын зардлын дэмжлэг үзүүлэх" төсөл буюу тус дүүргийн 4 дүгээр хорооны иргэн, ахмад настан З.Нина 2018 оны 03 дугаар сарын 03-10-ны өдрүүдэд БНСУ-д зохион байгуулагдсан Дэлхийн аврага, Олон улсын "А" зэрэглэлийн хэт холын марафон гүйлтийн тэмцээнд амжилттай оролцож 100 км-т 1-р байр, 50 км-т 6 цаг 22 минут гүйж мөн 1-р байр эзэлсэн.Тус тамирчны замын зардалд дэмжлэг болгож 2,051,000 төгрөгийг хөтөлбөрөөс санхүүжүүлсэн.

"Олон улсын ахмадын баяр"- ыг Хан-Уул дүүргийн 16 хороодын ахмадуудаа хүндэтгэл үзүүлэх "Хороодод ахмадын баярыг зохион байгуулах" төсөл.Төслийг хэрэгжүүлэхэд хороо тус бүрд 3,000 000 төгрөгийг төсөвлөн шаардагдах нийт 48,000,000 төгрөгийг хөтөлбөрөөс санхүүжүүлсэн.

ХОРООДЫН ХӨГЖИЛ,ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХӨТӨЛБӨР

Хэрэгжүүлсэн төсөл үйл ажиллагааны тоо	Батлагдсан төсөв	Зарцуулсан төсөв	Төсвийн зарцуулалтын хувь
13	100,000,000	84,292,000	84 хувь

Хөтөлбөрийн дүгнэлт:

- Хан-Уул дүүргийн төрийн байгууллагад ажиллаж буй нийт албан хаагчдын 15,5 хувийг чадавхжуулах арга хэмжээнд хамруулсан бөгөөд 635 албан хаагчийг төрийн албан үүргээ чанартай гүйцэтгэх боломж нөхцлийг бүрдүүлсэн.
- Төрийн үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гарсан.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 250.000.000 төгрөг батлагдсанаас 84.292.000 төгрөг зарцуулсан. Үүнээс:
  - 11,8 хувийг бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтад
  - 4 хувийг төрийн албан хаагчийн нийгмийн хөгжил хамгаллын ажилд
  - 84,2 хувийг сургалт, туршлага судлах үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ, зорилт бүрээр

1-р зорилтын хүрээнд

1. Хороодын Засаг дарга, Дэргэдэх хэлтсүүдийн удирдах ажилтнуудыг чадавхжуулах сургалт

2. “Бүтээн байгуулалт-Хамтын ажиллагаа 2018” Иргэн-төрийн үйлчилгээний харилцааг бэхжүүлэх, үйл ажиллагааг өргөтгөх зорилгоор ААНБ, хороодын иргэдийн дунд уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах
3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, компьютер техник хэрэгслийн зөв зохистой хэрэглээг хэвшүүлэх сургалт

2-р зорилтын хүрээнд:

1. Khanuul.mn веб сайтаар дамжуулан дүүргийн иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай үзүүлэх зорилгоор бүрдүүлэх баримт, бичгийн жагсаалтыг харах, мөн дүүргийн 7777-1965 дугаарын утсаар төрийн үйлчилгээний мэдээллийг хүргэн ажиллаж байна.
2. Эко дүүрэг Хан-Уул Facebook page хуудсаар иргэдийн сонирхсон асуултад тухайн асуудал хариуцсан ажилтан цаг тухай бүрд нь хариулт өгч байна.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний үнэмлэхийг үнэ төлбөргүй олгож, сунгалт хийж байна.

3-р зорилтын хүрээнд:

1. Дүүргийн цагдаагийн I, II хэлтэс, хөдөлмөр халамж үйлчилгээ, бүртгэлийн хэлтэстэй хамтран гэр орончгүй иргэдийг бүртгэлжүүлж, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд бүрэн хамруулан “Гэртээ харих зам өдөрлөг”-ийг зохион байгуулж ажиллаа.
2. ХУД-ийн орон сууц, албан байгууллагуудыг камержуулах ажил хийгдэж байна.

4-р зорилтын хүрээнд:

1. Бүгд найрамдах Солонгос улсад туршлага солилцох үйл ажиллагаа
2. Татвар төлөгч таньдаа баярлалаа өдрүүдийг зохион байгуулах
3. Цагдаагийн 1-р хэлтсийн уттах үйлчилгээний засварын ажил хийх
4. Дэлхийн гал сөнөөгчдийн 13 дах удаагийн тэмцээнд оролцох
5. Эрүүл мэндийн эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах
6. Архангай аймгийн татварын хэлтэстэй туршлага солилцох үйл ажиллагаа
7. Хороодын эрүүл мэндийн төвийн хамтарсан багийн албан хаагчдад туршлага судлах сургалт зохион байгуулах

5-р зорилтын хүрээнд:

1. 12, 14-р хорооны шилэн кабел засварлах төсөл

6-р зорилтын хүрээнд:

1. Ёс зүйтэй төрийн албаа, түргэн төрийн үйлчилгээ сургалт зохион байгуулах тухай
2. Залуучуудын хөгжлийн дэмжих, хууль сурталчлах тухай

7-р зорилтын хүрээнд:

Тохижилт төрийн үйлчилгээг сайжруулах жил болгон зарласантай холбогдуулан дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх тухай

Дүүргийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, төсвийн зарцуулалтын хувь

2018 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар 3 хөтөлбөрийн хүрээнд 44 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж нийт батлагдсан төсвийн 18 хувийг бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтад, 29 хувийг сургалт, туршлага судлах үйл ажиллагаанд, 12 хувийг сурталчилгаа мэдээллийн ажилд, 41 хувийг иргэдийн хөгжил, нийгмийн хамгааллын ажилд зарцуулсан байна.

1.8 Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хувьд тухайн дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнтэй холбоотой мэдээлэл;

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч дүүргийн Засаг дарга нарын хооронд байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг орон нутгийн түвшинд хангуулахаар дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх 22 хэлтэс, албад ОНӨААТҮГ-уудын дарга, захирал нартай үр дүнгийн гэрээ байгуулах ажлыг 02 сарын 15-ны өдөр ДЗДТГ-ын даргын батлсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан.

/Үр дүнгийн гэрээ байгуулах үйл ажиллагаа/

Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 108 зорилтын 2018 он болон 2017-2018 оны биелэлтийг гаргасан бөгөөд 2018 оны биелэлт 91,9 хувь, 2017-2018 оны биелэлтийн дундаж урьдчилсан дүнгээр 89 хувьтай тус тус хэрэгжсэн байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15.7 дахь хэсэгт заасны дагуу, дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017, 2018 оны хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэхээр "Тогтвортой хөгжлийн санаачлага" ТББ-тай 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдөр гэрээ байгуулан хамтран ажиллаж 2018 оны 12 сарын 12-ны өдөр үнэлгээний тайланг хүлээн авсан. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 2019 оны 01 дүгээрсарын 20-ны дотор НЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлнэ.

Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай дүүргийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр албан даалгавар, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах хуваарь батлуулж холбогдох хэлтэс, албадад хүргүүлж, батлагдсан хуваарийг мөрдүүлж ажилласан. Үндсэн чиглэлийн биелэлтийг улирал бүр тооцон, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгүүлэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлж ажилласан бөгөөд жилийн эцсийн байдлаар биелэлтийг нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгүүлж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдөр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн. Нийт 106 төсөл арга хэмжээ 90,1 хувьтай хэрэгжсэн.

Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах тухай А/381 дүгээр захирамжийг боловсруулан батлуулж, 2018 оны 12 сарын 06-ны өдөр ажлын хэсэгт үндсэн чиглэлийн биелэлтийг танилцуулж, ажлын хэсгээс гарсан санал, дүгнэлтийг хэрэгжүүлж ажиллалаа. Мөн дүүргийн

эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн нарийвчилсан төлөвлөгөөг батлуулан хэвлүүлж холбогдох хэлтэс, албадад хүргүүлэн дүүргийн цахим хуудас, фэйсбүүк пэйж хуудас зэргээр олон нийтэд сурталчилан ажиллаж байна.

ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУДААС:

Тохижилт, үйлчилгээний чиглэлээр:

Дүүргийн хэмжээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах ажлын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж буй "Хог хаягдлаа эх үүсвэр дээр нь бууруулж, ангилан ялгаж хэвшье" аяны I үе шатанд дүүргийн ЗДТГ, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, Ерөнхий боловсролын 18 сургууль, 29 цэцэрлэг хог хаягдлаа ангилан ялгаж хэвшсэн.

Дүүргийн 1, 2, 3, 11, 15 дугаар хороодын оршин суугчдын төлөөлөл, СӨХ-ийн гишүүд, сургууль, ААНБ, цэцэрлэгийн ажилтнууд иргэдийн төлөөлөл 80 гаруй хүн оролцсон сонсголын үйл ажиллагаа зохион байгуулсан. II дугаар үе шатанд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгж байгууллага, СӨХ-той хамтарч ажиллах төлөвлөгөө боловсруулан үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд 120 ААНБ, 45 СӨХ хог хаягдыг ангилан ялгаж хэвшсэн байна.

2018 оны 11 дүгээр сараас эхлэн 1,2,3 дугаар хороодод 13 цэгээс ангилагдсан, дахивар хог хаягдлыг тээвэрлэх тусгай тоноглогдсон авто машиныг ажиллуулж эхэлсэн

бөгөөд 7 хоног бүрийн Лхагва гарагт шил, лааз, Бямба гарагт хуванцар, гялгар уут, Ням гарагт цаасны хог хаягдлыг шууд тээвэрлэн дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлж байна.

Ангилагдсан, дахивар хог хаягдал тээвэрлэх цэг: 1-р хорооны Эрэл хотхон, Наран хотхон, Шинэ Өглөө хотхон, 52-р сургууль, 67-р цэцэрлэг, Jetro худалдааны төвийн орчим, 2-р хорооны 65-р цэцэрлэг, 3-р хорооны Дүүргийн Иргэдэд Үйлчлэх Төв байр орчим, 4-р байр, 15-р сургууль, Эрчим 53-р байр, Нутгийн буян 14 СӨХ.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэнтэй хамтарч багш, сурагчдад дүүргийн хог ангилан ялгах үйл ажиллагааны явц болон дахин боловсруулах үйлдвэрийг танилцуулах “Эко аялал”-ыг 2 удаа зохион байгуулсан бөгөөд нийт 63 багш сурагчид оролцсон. Энэхүү “Эко аялал”-ыг сард 1 удаа уламжлал болгон зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдлын менежментийг сайжруулахаар эвгүй үнэр гарахгүй, өвөл хөлдөхгүй, хог тарьж орчныг бохирдуулахгүй, шавьж мэрэгч орохгүй, тагны дотор талд гал мэдрэгч унтраагчтай тул галын аюулгүй, хог тээвэрлэх машиныг хол байрлуулж ачих боломжтой зэрэг олон давуу талтай ухаалаг, эдийн засгийн хэмнэлттэй зөв шийдэл бүхий 3-5 м.куб багтаамжтай **"Эко бин"** ухаалаг хогийн савыг 52-р сургуулийн хашаанд суурилуулж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлын эхлүүлсэн.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдоос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу дүүргийн бүх ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд суурилуулах төсөл, төсвийг боловсруулах ажлын хүрээнд "Экобин" хогийн савыг багш, сурагчдад танилцуулах арга хэмжээг 2 удаа зохион байгуулж ажилласан.

Хог хаягдлын хяналт, менежментийг сайжруулах ажлын хүрээнд "Хог хаягдлыг дахин боловсруулахтай холбоотой" авто засварын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын автотээврийн хэрэгслийн ашиглалтаас үүдсэн хог хаягдлыг дахин боловсруулж, авто үйлчилгээний салбарын хог хаягдлын менежментийг сайжруулах, түүнчлэн хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах зэрэг чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг" байгуулсан.

"Үер усны аюулд өртөх магадлалтай газрын байршлын судалгааг гаргаж мэргэжлийн байгууллагад хүргүүлэх" заалтын хүрээнд: Хороолол дундах зам талбайн ус зайлуулах сувгууд болон үерийн далангийн судалгааг гарган, хяналт шалгалт хийж, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор хуваарийн дагуу сард 1 удаа цэвэрлэгээний ажлыг хийж ажилласан. Дүүргийн 4,5,6,7,8,9,10,11,12,13,14,15,16 дугаар хороодын үерийн ус зайлуулах далан суваг, авто замын доогуурх ус гадагшлуулах суваг, гэр хорооллын гудамжны дундах гуу, жалганд хуримтлагдсан 104.1 тонн хог хаягдлыг 54 рейсээр тээвэрлэсэн.

Хороолол дундах зам талбайн ус зайлуулах сувгууд болон үерийн далан хамгаалалтыг шинээр бий болгох ажлын хүрээнд:

Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 40.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 16 дугаар хороонд 22м үерийн ус зайлуулах суваг байгуулах, эргийн бэхэлгээний ажлыг гүйцэтгүүлсэн.

Гамшигт тэсвэртэй Улаанбаатар төслийн хүрээнд "Дэлхийн зөн" Олон Улсын байгууллагын 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 12 дугаар хорооны төв зам дагуу 1 км орчим үерийн ус зайлуулах суваг хоолойг шинэчлэн барьж, байгуулсан.

Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөр (5.7 сая) 14 дүгээр хорооны Өлзийт тосгонд төмөр гүүрэн гарц болон үерийн ус зайлуулах хоолойг шинээр барьж байгуулсан.

Дүүргийн 14 дүгээр хорооны 59-р бага сургууль, 165-р цэцэрлэгийн хичээлийн 2-р байрыг тойруулж 400 м үерийн усны суваг татах, 16 дугаар хорооны 243 дугаар цэцэрлэг төв шугамтай холбогдсон 107 м ус зайлуулах шугам барьж байгуулсан.

Харшлын өвчин үүсгэгч ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах арга хэмжээ авна.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн "Аян зохион байгуулах тухай" А/172 тоот тушаалаар "Шарилжгүй Улаанбаатар-3" аяныг дүүргийн хэмжээнд зохион байгуулах ажлын удирдамж, ерөнхий болон календарчилсан төлөвлөгөөг батлуулан ажилласан.

Шарилж, хөл газрын ургамлыг хадах, тайрах, цэвэрлэх нэгдсэн арга хэмжээг 2 удаа зохион байгуулж нийт 487769.5 м^2 талбайн шарилж, хөл газрын ургамлыг устгасан. Цэвэрлэгээнд давхардсан тоогоор Засаг даргын Тамгын газрын 8 хэлтэс, тасаг, Засаг даргын дэргэдэх 27 хэлтэс алба, 1046 ААНБ, 149 СӨХ, хог тээвэр, цэвэрлэгээ үйлчилгээний компаниуд, "Эко ногоон бүлэг"-ийн нийт 5451 хүн оролцсон.

Аяны хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хамтарч 36 хүний бүрэлдэхүүнтэй "Эко ногоон бүлэг"-ийг ажиллуулсан бөгөөд 1,2,3,4,5,10,11,15 дугаар хороодын нийтийн эзэмшлийн 29137.5 м^2 тадбайн шарилж, хөл газрын ургамлыг цэвэрлэж устгасан.

Нийслэлийн хэмжээнд Хан-Уул дүүрэг **"Шилдэг дүүрэг"**, 1,6 дугаар хороо **"Шилдэг хороо"**-оор тус тус шалгарсан.

Дүүргийн хэмжээнд ногоон байгууламжийн хэмжээг 2-3 дахин нэмэгдүүлнэ ажлын хүрээнд:

Эко дүүрэг болох зорилтын хүрээнд "Бүх нийтээр мод тарих өдөр"-ийн үйл ажиллагааг 5, 10 дугаар сард зохион байгуулж дүүргийн хэмжээнд 43000 мод бут сөөг тарьж, нийтийн эзэмшлийн зам талбай дахь ногоон байгууламж, зүлэгжүүлэлтийг 1 дахин нэмэгдүүлсэн.

Дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайд 14500 м^2 талбай, СӨХ-д 12500 м^2 талбай, нийт 27000 м^2 сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлсэн. Орон сууц болон гэр хорооллын нийтийн эзэмшлийн талбайг амралт, чөлөөт цагаа өнгөрөөх зориулалттай тохижуулах ажлын хүрээнд 1 дүгээр хороо, 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт иж бүрэн тохижилттой цэцэрлэгт хүрээлэнг байгуулсан.

Зураг. Дүүргийн 1 дүгээр хороонд "Шинэ Хан-Уул", 13 дугаар хороонд "Янгирт" цэцэрлэгт хүрээлэнг байгуулав.

Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 13 дугаар хорооны 2, 5 дугаар байрнуудын гадна фасад засвар, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 1 дүгээр хорооны 44-р байр, 2 дугаар хорооны 18-р байрны дээвэр засварын ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн.

Гэр хорооллын гэрэлтүүлэг, зам талбай, хайс хашааны стандарт, жишгийг шинэчлэн тогтоож мөрдүүлнэ гэсэн заалтын хүрээнд:

Дүүргийн хэмжээнд нийт 1251 у/м хайс хашаанд арчлалт хамгаалалтын ажил хийгдсэн.
Нийтийн эзэмшлийн гудамж, тайлбайд байрлах 680 м/урт хашлага, замын тэмдэг, тэмдэглэгээ, 40 ширхэг сандал, 65 ширхэг хогийн савыг дулааны улиралд 14 хоногт 1 удаа тогтмол угааж цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Гэр хорооллыг камерын системд бүрэн хамруулна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын хороод болох Яармагийн 4, 5, 6, 7, 8 дугаар хороонд нийт 132 камер шинээр суурилуулж, ашиглалтад оруулсан.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2, 9, 10, 16 дугаар хороонд 40 ширхэг камер шинээр суурилуулан ашиглалтад оруулсан.

"Гэмт хэргээс урьдчилан сэргийлье" аян, "Манай хороо-Миний гудамж" аяны хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн ААНБ, СӨХ, хороодыг идэвхжүүлж ажилласан. СӨХ болон аж ахуйн нэгж байгууллага өөрсдийн хөрөнгөөр нийт 817 камер шинээр суурилуулсан.

1.8 Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хувьд тухайн дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага"-ын баримт бичиг, "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Нийслэлийн Засаг дарга бөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр", дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг суурь болгон дэргэдэх хэлтэс, албад болон бусад холбогдох байгууллага, иргэдээс санал авч, улс, нийслэл, дүүргийн 2019 оны төсөвтэй уялдуулан дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж 5 бүлэг, 26 чиглэлийн 143 төсөл, арга эхмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн 2018 оны үндсэн чиглэлийн биелэлтийн хамт дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан ба 2018 оны 12 сарын 14-ний өдрийн дүүргийн ИТХ-ынээлжит VI дугаар хуралдаанаар хэлэлцэн 2018 оны үндсэн чиглэлийн биелэлтийг **"Бүрэн хангалттай"** дүгнэж, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2019 оны үндсэн чиглэлийн төслийг дэмжиж баталсан.

Үндсэн чиглэлийн төсөл боловсруулах ажлын хүрээнд: Дүүргийн эдийн засаг, нийгмийг

2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай Засаг даргын 2018 оны А/260 дугаар захирамжийн төсөл боловсруулан батлуулав. Энэ хүрээнд 2018 оны 08 сарын 20-ны өдөр ЗДТГ-ын болон дэргэдэх хэлтэс албадын 23 мэргэжилтэнд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль", ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах нийтлэг журам"-ын хүрээнд "Үндсэн чиглэлийн төсөл боловсруулахад анхаарах зарим асуудал" сэдэвт сургалт зохион байгуулсан.

Дүүргийн Засаг даргаар "Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн 03 дугаар улирлын хэрэгжилтийн явц, үр дүнг танилцуулах, удаашралтай байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, "Үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн тодорхой заалтуудыг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх, арга замыг тодорхойлох зорилго бүхий удирдамж батлуулж 09 сарын 24-ний үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнг танилцуулах арга хэмжээ;

ЗДТГ-ын даргаар "Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн төсөлд тусгахаар хэлтэс, албадаас ирүүлсэн төсөл арга хэмжээний санал нь Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалтыг бүрэн хангах боломжтой эсэх, төсөл, арга хэмжээний хүрэх түвшин, үр дүн, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлсон байдлыг холбогдох хэлтэс, албадын дарга, мэргэжилтнүүдтэй тусгайлан уулзаж тодруулга авч, төслийн шаардлагыг хангуулах зорилго бүхий хөтөлбөр батлуулж 09 сарын 19-ний өдөр үндсэн чиглэлийн төсөл танилцуулах арга хэмжээ;

2018 оны 10 дугаар сарын 03-ны өдөр үндсэн чиглэлийн төслийн хэлэлцүүлгийг дүүргийн 16 хорооны төлөөлөл 70 иргэний дунд зохион байгуулж үндсэн чиглэлийн төслийн танилцуулга хийж, оролцсон иргэдээс үндсэн чиглэлд тусгах санал авах ажиллагаа;

2018 оны 10 сарын 04-ны өдөр Тогтвортой хөгжлийн саначилга ТББ-тай хамтран дүүргийн иргэдийн төлөөлөл 16 иргэнийг хамруулан фокус ярилцлага;

2018 оны 09 дүгээр сарын 24-өөс 2018 оны 10 сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд үндсэн чиглэлийн төслийг khanuul.mn сайтад байршуулж цахимаар санал авах ажиллагаг тус тус зохион байгуулсан.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах нийтлэг журмын дагуу үндсэн чиглэлийн төсөл боловсруулахад мэргэжлийн судалгааны байгуулага болох "Тогтвортой хөгжлийн санаачилга" ТББ-тай хамтран ажиллаж төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, нөлөөллийн урьдчилсан үнэлгээний ажлыг гүйцэтгэсэн.

Дүүргийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

"Мэтгэлцээн хөтөлбөр" 2018 оны 1 дүгээр сарын 11, 02 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулсан Карл Поппериын мэтгэлцээний сургагч багш, мэтгэлцэгч, шүүгч бэлтгэх сургалтад нийт 50 багш, 42 сурагчдыг хамруулсан.

Мэтгэлцээний клубүүдийн үйл ажиллагааны үр дүнг тодруулах зорилгоор дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 2018 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулахад ерөнхий боловсролын 16 сургуулийн багшийн 12 баг өрсөлдсөнөөс 1-р байрт 115-р сургууль, 2-р байрт 75-р сургууль, 3-р байрт Монгол оюун сургуулийн багш нарын баг, сурагчдын 16 багаас 1-р байрт 52-р сургуулийн "Unime" баг, 2-р байрт 118-р сургуулийн "Гэрэлт ирээдүй баг", 3-р байрт 114-р сургуулийн "Оргил" баг тус тус шалгарлаа.

“Замын хөдөлгөөний цагаан толгой-2018” тэмцээн: Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, хөдөлгөөнд соёлтой оролцох дадлага эзэмшүүлэх зорилгоор Цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулагдаг “Замын хөдөлгөөний Цагаан толгой-2018” тэмцээнийг 2018.04.27- оос 30-ны өдрүүдэд зохион байгуулаа.

Тэмцээний 5 төрөлд нийт 27 цэцэрлэгийн 324 хүүхэд, 27 багш, 27 эцэг эх оролцож өрсөлдөө. Тэмцээнд оролцсон хүүхэд бүрт Дүүргийн Засаг даргын гарын бэлгийг гардуулан өглөө.

Монгол Улсын иргэний андгай өргөх ёслол: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын Газраас уламжлал болгон зохион байгуулдаг Монгол Улсын иргэний андгай өргөх ёслолыг 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдөр, 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр болж дүүргийн 16 нас хүрч буй залуучуудын төлөөлөл 219 сурагч иргэний үнэмлэхээ гардан авлаа.

“Их нүүдэл” шатрын тэмцээн: Нийслэлийн засаг даргын нэрэмжит өсвөрийн шатарчдын “Их нүүдэл тэмцээнийг 2018 оны 10 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулав. Тэмцээнд дүүргийн ерөнхий боловсролын 14 сургуулийн 336 сурагч оролцлоо.

“Ногоон гэрэл-Цагаан шугам” тэмцээн: Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, хөдөлгөөнд соёлтой оролцох дадал төлөвшүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын “Ногоон гэрэл-цагаан шугам” тэмцээн 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулагдлаа. Тэмцээнд 15 дугаар сургууль 1 дүгээр байр, 52 дугаар сургууль 2 дугаар байр, 41 дүгээр сургууль 3 дугаар байр, 32 дугаар сургууль

Тусгай байрыг тус тус эзэлж алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа. Нийт оролцогч хүүхдүүдэд бэлэг өгөв.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Кейс хэлэлцүүлэг: Дүүргийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулах, хамгаалалын үйлчилгээний чанарыг сайжруулах, нийгмийн ажил үйлчилгээг мэргэжлийн түвшинд хийх, холбон зуучлах, хамтран ажиллах ажиллагааг сайжруулах зорилготой кейс хэлэлцүүлгийг 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Дэлхийн зөн Монгол ОУБ-тай хамтран, 16 хорооны нийгмийн ажилтан болон ГБХЗХХ-ийн мэргэжилтнүүдийн дунд амжилттай зохион байгууллаа.

СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР

"Хаявал хог-бүтээвэл баялаг" үйл ажиллагаа: "Тогтвортой хөгжил-2030" зорилтын хүрээнд байгаль орчныг хайрлан хамгаалах, экологийн боловсролыг бүх нийтэд үе шаттайгаар эзэмшүүлэн зохистой хэрэглээг бий болгох зорилгоор ХУД-ийн хороодын иргэд, ЕБС-ийн дизайн технологийн багш нар, сурагчдыг хамруулан зохион байгууллаа. Аяны үйл ажиллагааны явц, үр дүнг тайлагнаж 2018 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр ерөнхий боловсролын 8 сургуулийн багш сурагчид, 9 хорооны иргэдийг хамарсан сургалт, туршлага танилцуулах үйл ажиллагаа, тэмцээн, бүтээлийн үзэсгэлэн зэрэг 4 үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан.Үйл ажиллагаанд нийт 90 гаруй иргэд, сурагчид хамрагдав.

"Хүүхдийн урлагийн их наадам": 2018 оны 04 дүгээр сарын 03-06-ны өдрүүдэд дүүргийн Засаг даргын нэрэмжит "Хүүхдийн урлагийн Их наадам"-ыг зохион байгууллаа. Уг наадам нь Хүүхэд өсвөр үеийнхэнд Монгол үндэстний урлагийн их өв санг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэх, сурталчлах, тэдний авьяас чадварыг хөгжүүлэх зорилготойгоор 3 насны ангиллаар СӨБ-ын 4, ЕБС-ийн 8 төрлөөр зохион байгуулагдсан. Урлагийн их наадамд дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн нийт 40 цэцэрлэг, 18 сургуулийн 1771 хүүхэд багачууд

оролцож авьяас билгээ сорьсон. 2018 оны Хобби урлагийн их наадмын шилдэг цэцэрлэгээр Амилагийн Багачууд, шилдэг сургуулиар 18 дугаар сургууль шалгарлаа.

Сурагчдын найрал дууны наадам: Д.Лувсанш аравын нэрэмжит Хүүхдийн найрал дууны Улсын 26 дугаар наадмын 1 дүгээр шатны шалгаруулалт 2018 оны 10 дугаар сарын 16 нд зохион байгуулж Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын 14 сургуулийн 1030 сурагч хамрагдав.

Дээлтэй Монгол наадам: 2018 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Нийслэлийн Соёл, урлагийн газраас зохион байгуулсан "Дээлтэй монгол-2018" наадмын баярын жагсаалд төр захиргааны байгууллага, 16 хороодын иргэдийг хамарсан 240 иргэн оролцсон.Наадмын үеэр Монгол үндэсний тоглоом наадгайн өргөөг байгуулан 22 нэр төрлийн 300 гаруй тоглоомыг байрлуулж тоглох арга аргачлалыг англи хэл дээр орчуулан иргэд, жуулчдад танилцуулж ажилласан.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн үнэлгээ: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2018 оныг "Иргэдийн оролцоотой-Амьдрах орчныг сайжруулах жил" болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018 оны А/44 дүгээр тушаалаар "Манай хороо-Миний гудамж" аяныг зарласан. Энэхүү аяны хүрээнд дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний салбар зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байгаа эсэхэд үнэлгээ хийх ажлыг "Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо"-той хамтран зохион байгууллаа.

Үнэлгээнд тус дүүргийн 16 хорооноос алслагдсан болон төвийн хороодоос сонгон явган хүний замд үнэлгээ хийхийн зэрэгцээ, дүүргийн хэмжээн дэх нийтийн эзэмшлийн талбай, автобусны буудлууд болон төрийн үйлчилгээний байгууллагууд, соёлын үйлчилгээнд хүрч очих хэсгүүдийн явган хүний зам, замын гарцуудад түүвэрчилсэн байдлаар үнэлгээ хийлээ. Үнэлгээ хийхдээ "Авто замын байгууламж Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам Техникийн шаардлага MNS 5826-2006", "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй

иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056-2009" стандартуудын хэрэгжилтэд судалгаа хийж ажилласан. Үнэлгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрсдийн оролцоотой, сайн дурынхны тусламжтай хийж гүйцэтгэлээ.

"Эрүүл, аз жаргалтай ирээдүй" сайн үйлсийн аян: "Монголын Рояаль Академи"-тай хамтран 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр "Эрүүл, аз жаргалтай ирээдүй" сайн үйлсийн аян, өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үйл ажиллагаанд тус дүүрэгт оршин сууж буй байгууллагын асаргаатай, хөгжлийн бэрхшээлтэй 0-4 насны хүүхдүүд, тэдний эцэг эхчүүд нийт 100 гаруй хүн оролцлоо. Үйл ажиллагаанд оролцсон хүүхдүүд, тэдний эцэг эхчүүдэд "Анугоо" фармын мэргэжлийн эмч нар эрүүл мэндийн болон эмийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл зөвлөгөө өгч, нэг сарын витамины хэрэглээ болон ивээн тэтгэгчдийн гарын бэлэг гардууллаа.

Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаа: Тус дүүрэгт оршин сууж буй нийт **14853** ахмад настны судалгааг шинэчлэн гаргасан.

Хан-Уул дүүргийн ахмад настны тоо хороогоор



Сар шинийн баярыг угтан тус дүүргийн зорилтот өрхийн ахмад настнуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг хороо тус бүр хуваарь гарган зохион байгууллаа. Зорилтот өрхийн 2000 ахмад настанд дүүргийн Засаг даргын гарын бэлгийг, харьяалалгүй 1600 ахмад настанд дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс, нийт 3600 ахмад настанд хүндэтгэл үзүүлсэн.

Ахмадын бүлэг үүсгэн, бүлгийн үйл ажиллагааг дэмжин, ахмадын зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх арга хэмжээ: Хан-Уул дүүргийн ахмад настнууд руу чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг ТББ-аар гүйцэтгүүлэх ажлын хүрээнд "MSDI Шинэ Хөгжлийн Түлхүүр" ТББ-тай хамтран "Үнэ цэнэтэй ахмадууд- эко ахмадын хуримтлалын бүл" төслийг хэрэгжүүлэхээр 2018.03.05-ны өдөр 04/12 тоот гэрээ байгууллаа. Төсөлд нийт 300 ахмадыг хамруулах ба нийслэлийн хэмжээнд хэрэгжих ахмадууд руу чиглэсэн анхны загвар төсөл болгох зорилтыг тавин ажиллаж байна. Төсөл 2018.03.01-12.31-ийг хүртэлх хугацаанд хэрэгжинэ.

Төслийн зорилго: Төсөлд хамрагдсан ахмад настнууд өөрсдийн эдийн засгийн боломж нөөцийг нээн илрүүлэх, ахмадууд өөр хоорондоо нэгдэн хамт олны хадгаламжийн бүлэг байгуулан, дундын хуримтлалын сантай болох, эдийн засгийн чадавхаа нэмэгдүүлэх, чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөхөд оршино. Төслийн хүрээнд хороодын ахмадын зөвлөлийн дарга нартай 2 удаагийн сургалт, 3, 4, 8, 13, 14, 15, 16 дугаар хороодод төслийн танилцуулга хийх уулзалтыг зохион байгуулаад байна.

Ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ: 2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар Олон улсын ахмадын баяыг тэмдэглэн өнгөрүүлэх тухай асуудлыг хэлэлцэн "16 хороодод ахмадын баярыг зохион байгуулах тухай" төслийг баталсан. Тус төслийн дагуу хороо тус бүр өөрийн нутаг дэсвгэрт ахмадуудад хүндэтгэл үзүүлж, тэмцээн уралдаан, урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулсан.

Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдэд чиглэсэн "Гэртээ харих зам" хөтөлбөрийн хэрэгжилт: Дүүргийн Засаг даргын 2017 оны А/24 дүгээр захирамжаар тус дүүргийн нутаг дэвсгэрт орон гэргүй, тэнэмэл байдлаар амьдарч буй иргэдийг нийгэмшүүлэх "Гэртээ харих зам" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.

2018 оны 1 дүгээр улиралд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний "Түр хоноглох байранд байрлуулах" үйлчилгээг "Хаган Богда" Боловсролын төв НҮТББ-тай 2018.01.01-2018.03.01-ний хугацаанд хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. Энэ хугацаанд 1-р сард 34 иргэнд-10590,0 2-р сард 30 иргэн-7700,0 мянган төгрөгийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн байна. Түр хоноглох байранд байрлаж байсан иргэдээс эрэгтэй 36, эмэгтэй 8, Хүүхэд 6, хөгжлийн бэрхшээлтэй 5, Ахмад настан 2, хөдөлмөрийн насны 21 иргэн байсан. Иргэдийн нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцан, нөхцөл байдлын үнэлгээ хийсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран "Гэртээ харих замд сайн дурын нийгмийн ажилтны оролцоо" сэдэвт хэлэлцүүлгийг 2018.05.22-ны өдөр зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт "Гэртээ харих зам" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн гишүүд, хороодын Засаг дарга нар, тэнэмэл иргэдийг түр хоноглуулах үйлчилгээ үзүүлдэг "Хаган Богда" ТББ болон сайн дурын идэвхтнүүд оролцож, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажлуудыг зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

- ✓ Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, сайн дурын идэвхтнүүд хамтран нэгдсэн арга хэмжээг 2018 оны 6 дугаар сард зохион байгуулах
- ✓ 2018 оны III улиралд сайн дурын идэвхтнүүдийн оролцоотойгоор тус дүүргийн нутаг дэвсгэрт тэнэмэл байдлаар амьдарч буй иргэдийн ихээр цуглардаг газруудад очин, нөхцөл байдлын үнэлгээ, судалгааг нарийвчлан хийж, нийгэмшүүлэх ажилд бэлтгэх
- ✓ Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг түр хоноглох байранд байрлуулж, нийгэмшүүлэх ажлыг хамтран хэрэгжүүлэх

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР

"Мөнгөн Улаанбаатар-2018" цасны баяр: 2018 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Хандгайтын "Янзага" зусланд зохион байгуулагдсан "Мөнгөн Улаанбаатар-2018" цасны баяр, биеийн тамир, спортын өвлийн үйл ажиллагаанд Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, хороодын нийт 849 албан хаагчид оролцлоо. Хэлтэс, албадын ажилтан, албан хаагчдын дунд спортын 3 төрлөөр тэмцээн уралдаан зохион байгуулсан. Хан-Уул дүүрэг байгууллагын нийлбэр дүнгээр нийслэлийн хэмжээнд "Тэргүүн байр"-нд шалгарч, Өргөмжлөл, Цом, мөнгөн шагналаар шагнагдсан.

"Улаанбаатар өвлийн наадам-2018: Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, хүйтний улирлын үндэсний тоглоом наадгай соёлыг сурталчлах зорилгоор "Улаанбаатар өвлийн наадам-2018" 2018 оны 02 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулагдсан. Үүнд тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, хороодын 461 иргэд амжилттай оролцож 7 дугаар хороо Нийслэлийн 9 дүүргийн 152 хороодоос "Үндэсний хувцастай иргэдийн парад"-д Тэргүүн байр эзэлсэн.

Дүүргийн Засаг даргын нэрэмжит "Цом"-ын аварга шалгаруулах спортын 5 төрөлт тэмцээн: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын хорооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Засаг даргын нэрэмжит "Цом"-ын аварга шалгаруулах спортын 5 төрөлт тэмцээн 2018 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 2018 оны 05 дугаар сарын 20-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Засгийн газрын 2011 оны

02 дугаар сарын 01-ны 32, 05 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх , биеийн тамир, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгох ажилтан, албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх 24 хэлтэс, албадын 48 багийн давхардсан тоогоор 800 гаруй ажилтан, албан хаагчид спортын 5 төрөл /Боулинг, дартс, сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөг/-өөр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөөс байгууллагын нийлбэр дүнгээр:

3-р байрт Татварын хэлтэс
2-р байрт Цагдаагийн хоёрдугаар хэлтэс
1-р байрт Цагдаагийн нэгдүгээр хэлтэс тус тус шалгарч шилжин явах "Цом", өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

"Амны хөндийн эрүүл ахуй"-н сургалт: Нийслэлийн эрүүл мэндийн газар, Гүүд нейборс ОУБ, Боловсролын хэлтэстэй хамтран дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш, сургалтын менежер,эмч нарт 2018 оны 4 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд "Амны хөндийн эрүүл ахуй"-н чиглэлээр сургалт зохион байгуулсан. Уг сургалтад нийтдээ 450 орчим багш нар хамрагдлаа.

"Сүрьеэгүй дүүрэг" уулзалт хэлэлцүүлэг, сургалт, сурталчилгаа

Сүрьеэ өвчинтэй тэмцэх дэлхийн өдрийг тохиолдуулан "Сүрьеэгүй Хан-Уул" өдөрлөгийг 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан.Уг өдөрлөгийн хүрээнд сүрьеэгийн халдвар, халдварын тархалт, халдвараас сэргийлэх талаарх мэдээллийг хийж, иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх замаар эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж, "Сүрьеэгийн халдвараас сэргийлэх", "Ханиаж найтаах соёл", "Гар угаах дараалал", "Маскны зөв хэрэглээ" зэрэг 5 төрлийн 1000 ширхэг гарын авлага бэлтгэн тараасан.

Сүрьеэгийн тархалт, өвчлөлийг бууруулахад олон талын хамтын оролцоог нэмэгдүүлэх, нөлөөлөл, хамтын ажиллагаа сайжруулан "Сүрьеэгүй дүүрэг" болох идэвх санаачилгыг өрнүүлэх зорилгоор Эрүүл мэндийн төвийн эмч, хороодын Засаг дарга нар, хөгжлийн

нийгмийн ажилтнууд, ӨӨМТ-ийн дарга нар оролцсон нөлөөллийн уулзалт хэлэлцүүлгийг 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Глобаль сан, Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоотой хамтран зохион байгууллаа.

Ахмад настныг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах: Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах шаардлагатай 5243 ахмадуудад халдварт болон халдварын бус өвчний урьдчилан сэргийлэх үзлэгийг дотор, мэдрэл, эмэгтэйчүүд, хавдар, нүд, чих хамар хоолой, сүрьеэ зэрэг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэй баг хийж эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.

Мансууруулах бодис, архи тамхины хор хөнөөлөөс сэргийлэх сургалт: Мансууруулах бодис, архи, тамхины хор хөнөөл сэдвийн хүрээнд 10 удаагийн сургалтыг 9 ерөнхий боловсролын сургууль, 6 их дээд сургуулиудад зохион байгуулсан. Сургалтад 2176 ахлах ангийн сурагч, 1286 оюутан, нийт 3462 оюутан, сурагч хамрагдлаа.

Томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа: Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын хангах, идэвхжил, дэгдэлтийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу эмч, ажилчид, төрийн болон төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 400 эмч нарт "ХӨЦМ-ийн маягтаар 0-5 хүртэлх насны хүүхдийг үнэлж ангилах", "Давтан үзлэгийн хоног", "Хэзээ яаралтай эргэн ирэх", "Өвчтэй хүүхдийн хооллолт" зэрэг сургалтуудыг 8 удаа зохион байгуулсан. "Томуугаас хэрхэн сэргийлэх", "Зөв ханиаж, найтаах соёл" зэрэг сэдвүүдээр 5759 иргэд, эцэг, эхчүүдэд сургалт зохион байгуулсан. Дүүргийн Нисэх, Яармагийн бүсийн Ерөнхий боловсролын сургуулиудын 1-3 дугаар ангийн 3329 сурагчдыг агаар цэвэршүүлэх шүүлтүүртэй амны хаалтаар хангах ажлыг 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан.

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

Гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай өрхийг цахилгаан эрчим хүчээр үе шаттай хангах ажлын хүрээнд:

Эрчим хүчний сайдын 2017 оны төсвийн багцад тусгагдсан дүүргийн 3, 12, 13, 14 дүгээр хороодын хүчдэлийн уналттай болон шинэ сууршлын бүсийн гэр хорооллын 757 айл өрхийг цахилгаан хангамжаар хангах 16 төсөл, арга хэмжээ гэрээний дагуу түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр хийгдэж ашиглалтанд хүлээлгэж өгсөн.

Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулж, нэгдсэн удирдлагын системд бүрэн холбоно.

Нэгдсэн удирдлагын системд холбогдоогүй байсан 22 байршлыг засваржлаж дүүргийн гэрэлтүүлгийн нэгдсэн удирлагын системд бүрэн холбосон. Нийслэл болон дүүргийн төсвийн хөрөнгөөр 4, 14, 15 дугаар хороодод нийт 90 ширхэг гэрэлтүүлэг шинээр хийгдсэн.

Дүүргийн орон сууцны хороолол дундах нөхөөс хийж, засварлах шаардлагатай 41 байршлын судалгааг гаргаж, Нийслэлийн авто зам хөгжлийн газарт хүргүүлж 1, 2, 3, 11, 15 дугаар хороодын нутаг дэвсгэрийн 5 байршлын орон сууцны хороолол дундах нийт 600 м^2 асфальтан замын засварын ажил хийгдсэн.

Үндэсний үйлдвэрлэгч "ГОЁО" ХХК нийтийн эзэмшлийн 600 м зам талбайг цардмалжуулж, шинээр авто машины зам хийсэн.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 11 дүгээр хороо БогдЖавзандамбын гудамжны 1134 м^2 талбайд авто замын асфальтан бетон хучилтын ажил хийгдсэн.

"Манай хороо - Миний гудамж" аяны хүрээнд аж ахуйн нэгж байгууллагуудын гадна тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор Засаг даргын Тамгын газраас уриалга гаргаж 1500 аж ахуйн нэгж байгууллага болон сургууль цэцэрлэгүүдэд хүргүүлсэн.

Аяны хүрээнд идэвхтэй оролцсон 10 айл өрхөд 200 ширхэг мод бут сөөг, 13 дугаар хорооны жишиг гудамжны 37 айл өрхөд 300 ширхэг улиас мод өгч урамшуулсан.

Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийн хүрээнд идэвхи санаачлагатай оролцсон Арвижих СӨХ-д 100 ширхэг хайлаас, 2 ширхэг тэхийн шээг, Булгат мөрөн ХХК-д 10 ширхэг голт бор, 100 ширхэг шар хуайс, Оргил СӨХ-д 70 ширхэг хайлаас, 100 ширхэг шар хуайс, Цоглог СӨХ-д 50 ширхэг хайлаас, Хан оргил СӨХ-д 60 ширхэг шар хуайс тус тус өгч урамшуулсан.

Туул, Дунд голын дагуух дүүргийн нутаг дэвсгэрт амралт, үйлчилгээний эко зурвасуудыг байгуулна.

Дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Туул гол дагуу "Туулын хар шугуй" ТББ-тай хамтран 1627 ширхэг мод, бут, сөөг тарих ажлыг зохион байгуулсан.

Ширий Ширий амьдрах ухаан Төрийн бус байгууллага 45 хүний бүрэлдэхүүнтэйгээр Маршалын гүүр болон Зайсангийн гүүрнээс баруун тийш Туул гол дагуух 1 км орчим газарт цэвэрлэгээ хийж иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх хоггүй орчинг бүрдүүлсэн. Цэвэрлэгээнээс гарсан 1 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн.

Дүүргийн хэмжээн дэх зам талбай, олон нийтийн эзэмшлийн газруудад мөрдөгдөх аюулгүйн зааварчилгаа, тэмдэг тэмдэглэгээг шинэчлэн сайжруулах ажлын хүрээнд:

Дүүргийн 15 дугаар хорооны Гандийн гудамжинд 4 ширхэг, Нарны замд 1 ширхэг тэмдэг тэмдэглээг шинээр суурилуулсан. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 1, 15 дугаар хорооны орон сууцны хороолол дундах хүүхдийн тоглоомын талбайд 64 ширхэг анхааруулах самбар шинээр байршуулсан.

Дүүргийн хэмжээнд 174 ширхэг тэмдгийн арчлалт хамгаалалт, Нарны зам болон Махатма Гандийн түр замуудад нийт 193,3 м^2 тэмдэглэгээ, Таван толгойн гүүрний урд хурд 76 м^2 сааруулагч, Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч ААНБ-уудын хүнд даацын автомашины тээвэрлэлтийн замд 2 хурд сааруулагч, 8 ширхэг замын тэмдэг тэмдэглэгээг тус тус байршуулсан.

Гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай, чийрэгжүүлэлтийн талбайг шинээр барьж байгуулна.

Дүүргийн төсөв болон дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн нийт 91,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4 хүүхдийн тоглоомын талбай, Нийслэлийн төсвийн 220.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 хүүхдийн тоглоомын талбай, 2 ААНБ өөрийн хөрөнгөөр 2 хүүхдийн тоглоомын талбайг тус тус шинээр байгуулсан.

Дүүргийн төсвийн 30.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 16 дугаар хорооны Сонсголонгийн гүүрний баруун талд тоглоомын талбайг шинээр байгуулсан.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 9,9 сая төгрөгийн хөрөнгөөр 5 дугаар хорооны 29-р цэцэрлэгийн хашаанд тоглоом суурилуулах ажил хийгдсэн.

Улс, нийслэлийн төсвийн 220 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 хүүхдийн тоглоомын талбайг шинээр байгуулсан.

Нийслэлийн төсвийн 65.0 сая төгрөгийн хөрөнгөөр 1, 10 дугаар хороонд ахмад настны чийрэгжүүлэлт, залууст зориулсан спортын талбай байгуулсан.

"Тереза эх" ахмадын асрамжийн төв өөрийн 50.0 сая төгрөгийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн талбайд иж бүрэн хүүхдийн тоглоомын талбайг шинээр байгуулсан.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР: Дүүргийн 10, 12, 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хайрга, дайрга олборлох үйл ажиллагаа явуулж буй 11 аж ахуйн нэгж байгууллагын 2017, 2018 онд батлагдсан "Байгаль орчны менежмент"-ийн төлөвлөгөөний дагуу хийгдсэн нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

"Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ"-г хийлгэхэд Засаг даргын санал авахаар ирүүлсэн 125 албан бичгийг танилцуулж, дэмжсэн саналыг Байгаль орчин аялал жуулчлалын яам, Нийслэлийн Байгаль орчны газарт хүргүүлсэн.

АГААРЫН БОХИРДЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд "Байгальд ээлтэй техник технологийн" үзэсгэлэн худалдааг 1 сарын хугацаанд хороодод бүсчлэн зохион байгуулж, 9340 иргэнийг хамруулсан.

Түүхий нүүрсийг хориглох тухай тогтоолуудыг таниулах сургалтыг нийт 22 удаа зохион байгуулж, хороодын нийт

290 албан хаагч, 10600 иргэн, 416 аж ахуйн нэгж байгууллагын 11306 ажилтныг хамруулсан.

ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр орчин үеийн шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн дүүргийн бүтээн байгуулагчдыг дэмжиж ажиллана.

Орчин үеийн техник технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж байгаа үйлдвэрүүдтэй үе шаттайгаар танилцаж судалгааны мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа хөнгөн үйлдвэрүүдийн техник технологи, тоног төхөөрөмжтэй танилцаж 80 үйлдвэрийг "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн хангуулах" улсын үзлэгт хамруулан ажилласан.
- Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран орчин үеийн техник технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа томоохон үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг танилцуулах, туршлага судлуулах ажлыг зохион байгуулсан.

Дүүрэгт жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих борлуулалтын нэгдсэн төвийг байгуулж, "Хан-Уул брэндинг" шинээр бий болгоно.

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй нийт 500 үйлдвэр эрхлэгчдийн бүртгэл судалгааг Эко Хан-Уул мэдээллийн санд оруулсан. 2018 онд шинэлэг бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй 29 үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сонгон, "Хан-Уулд үйлдвэрлэв" цуврал сэтгүүлийг 700 ширхэг хэвлэж олон нийтэд сурталчилж ажилласан.

Дүүргийн газар тариалан эрхлэгчдийг эрсдэлээс хамгаалах үүднээс даатгалд хамруулах чиглэлээр сургалт, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангана.

Дүүргийн газар тариалан эрхлэгчдийн зөвлөгөөнийг 200 гаруй ногоочдыг оролцуулан зохион байгуулж, дүүргийн газар тариалангийн салбарын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг танилцуулан газар тариалан эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг эрсдэлээс хамгаалах даатгалд хамруулах, даатгалын ач холбогдлын талаар мэдээлэл хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Дүүргийн нутаг дэвсгэрт газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 480 иргэн, 28 иргэн аж ахуйн нэгжийн судалгааг шинэчлэн гаргаж, “Өрх бүрт жимс” арга хэмжээг хэрэгжүүлэн 400 өрхөд үхрийн нүдний суулгацыг үнэ төлбөргүй олгож, 1200 суулгацыг иргэдэд хөнгөлөлттэй зээлээр, 10 төрлийн хүнсний ногооны үрийг 200 өрхөд тус тус олгосон.

Дүүргийн газар тариалан эрхэлдэг 28 иргэнд Тариаланчийн баталгаат тэмдэг олгож, 14 иргэн, аж ахуйн нэгжид хүнсний ногооны гарал үүслийн гэрчилгээ олгосон.

Тариалан эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих зорилгоор “Монгол ногоо” төсөлтэй хамтран 10, 13 дугаар хорооны ногоо худалдан борлуулах төв, Ажилчны алдар талбайд хүнсний ногооны үр, үрсэлгээний худалдан борлуулах түр цэгийг тус тус байгуулан борлуулалтыг дэмжиж ажилласан.

Дүүргийн тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор "Глобал коммунитис" төсөлтэй хамтран Ажилчны алдар талбайд хүнсний ногооны үр, үрсэлгээ, шинэ ургацын хүнсний ногооны үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 18 иргэн, аж ахуйн нэгжийн борлуулалтыг дэмжин ажиллаж, 70 гаруй сая төгрөгийн борлуулалт хийсэн.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор дүүрэгт соёл урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

Нийслэл Улаанбаатар хотын түүх, аж үйлдвэрийн үүсэл хөгжил, үйлдвэр, аж ахуйн газрын үйл ажиллагаатай танилцах “Өртөөлчилсэн эко аялал”-ыг Еренхий боловсролын 16 сургуулийн сурагчдад, түүх соёлын дурсгалт газар, биет өвийг танилцуулах судалгааг хичээлийг 32 дугаар сургуультай хамтран тус тус зохион байгуулсан.

Дүүрэг дэх эртний дурсгалт газар, орчин үеийн хөшөө дурсгал, баримлууд болох Сонгино хайрхан уулын өвөрт орших туулын хар түнийн ордны туурь, Нүхтийн аман дахь Монголын ноёд нуруулаар зөвлөлдсөн газар, бичигт хад, Богдхан уул, Туул гол, Яармагийн дэнж, Айцын даваа, Энхтайвны гүүр, Хан-Уул дүүргийн өндөрлөг, Тэмээтэй хөшөө зэрэг түүх, соёлын үл хөдлөх дурсгалт 31 газрын танилцуулга бүхий " ХАН-УУЛ ДҮҮРГЭЭ ТАНЬЖ МЭДЭЦГЭЭЕ" номыг 500 ширхэг хэвлэн, иргэдэд сурталчилан ажиллаж байна.

Аялал жуулчлал, амралт сувилал, зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ахуйн нэгж байгууллагын удирдах ажилтнуудад

зочлох үйлчилгээний салбарын бодлого, олон улсын сайн туршлага, жуулчны бааз, амралтын газруудын стандартын талаар үзүүлэх сургалтыг "Монголика" зочид буудалд зохион байгуулж, харилцан туршлага солилцсон. Мөн дүүргийн зочлох үйлчлэх салбарын үйлчилгээний ажиллагсдыг мэргэшүүлэх, үйлчилгээний үндсэн технологи эзэмшүүлэх зорилготой ажлын байранд нь мэргэшүүлэх онол, практик хосолсон үзүүлэх сургалтыг "Зочлох үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төв"-тэй хамтран зохион байгуулж, 30 аж ахуйн нэгжийн 140 ажилчид хамрагдсан.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:

ЕБС-ийн сурагчдыг шүүхийн үйл ажиллагаа, шүүн таслах ажиллагаатай танилцуулах

Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын 15 сургуулийн ахлах ангийн **301** сурагчдыг Эрүү, Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны үйл ажиллагаатай танилцуулан ажилласан. Сурагчид хууль тогтоомж эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэн, хуулийг сахин биелүүлэх, зөв хэрэглэх ёс суртахуунд суралцан, зөрчигдөж байгаа эрх, хууль ёсны ашиг сонирхолоо хэрхэн хамгаалах талаар ойлголтыг өгөх зорилготой практикт тулгуурлсан сургалт зохион байгуулсан.

2018 оны 02 дугаар сарын 09-ний өдөр 52, 75-р сургуулийн ахлах ангийн нийт 40 сурагчдыг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хуралтай танилцуулсан.

2018 оны 03 дугаар сарын 16-ны өдөр 15, 18 дугаар сургуулийн 45 сурагчийг, 2 багшийн хамт Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хуралтай танилцуулсан.

2018 оны 05 дугаар сарын 11-ний өдөр 26, 59 дүгээр сургуулийн ахлах ангийн 45 сурагчдыг Захиргааны хэргийн анхан, давж заалдах шатны шүүхийн танхимтай танилцуулан шүүх хурлын үйл ажиллагаа талаарх мэдээлэл сургалтыг хийсэн.

2018 оны 06 дугаар сарын 14-ний өдөр 7, 114 дүгээр сургуулийн ахлах ангийн 40 сургачийг Захиргааны хэргийн анхан, давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаатай танилцуулах сургалт зохион байгуулсан.

2018 оны 10 дугаар сарын 17-ны өдөр 34, 41 сургуулийн 49 сурагчийг Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хуралдааны явцтай, 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 32, 115-р сургуулийн 42 сурагчийг Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хуралдаанд оролцуулж үйл ажиллагаатай тус тус танилцуулсан.

2018 оны 12 дугаар сарын 11-ний өдөр 60, 118 дугаар сургуулийн 40 сурагчыг багшийн хамт Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хуралдааны танхим болон шүүх хуралдааны үйл ажиллагаатай танилцуулах арга хэмжээг зохион байгууллаа.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: “ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

2.1 Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл;

2018 оны жилийн эцсийн байдлаар биелэлтийг тооцож мэдээлэх 12 төрлийн 105 захирамжлалын баримт бичгийн холбогдох 208 заалтыг http://monitoring.ub.gov.mn/ програм, http://www.legalinfo.mn/, http://ulaanbaatar.mn/ мэдээллийн эх үүсвэрээс түүвэрлэн авч Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасуудад жагсаалтаар, Засаг даргын дэргэдэх 26 хэлтэс, албадад Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн биелэлт ирүүлэх тухай 01/2261 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Тогтоол шийдвэрийн биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгүүлэн Засаг даргын Тамгын газрын 2018 оны 12 сарын 21-ний өдөр 01/2468 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Биелэлтийн хувь 99.2

ТОГТООЛ, ШИЙДВЭР	ТОО	ЗААЛТ
2018 оны жилийн эцсийн байдлаар		
УИХ-ын тогтоол	2	**3**
УИХ-ын байнгын хорооны тогтоол	4	**8**
Ерөнхийлөгчийн зарлиг	5	**7**
Засгийн газрын тогтоол	11	**30**
Засгийн газрын албан даалгавар	2	**19**
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	12	**19**
Ерөнхий сайдын захирамж	2	**5**
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	1	**1**
НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол	4	**17**
ДИТХ-ын тогтоол	1	**1**
Нийслэлийн Засаг даргын Захирамж	49	**79**
Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг даалгавар	12	**19**
ДҮН	**105**	**208**

Биелэлтийг LMonitoring програмаар мэдээллэсэн байдал:

2018 оны 1-р улиралд биелэлт гаргах Нийслэлийн Засаг даргын 22 захирамж хүлээн авч холбогдох 57 заалтын биелэлтийг тооцож Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст мэдээллэлээ. /Биелэлт 40,36 %/

2018 оны 2 дугаар улиралд нийт 38 захирамжлалын баримт бичгийн хяналтад авсан 59 заалтын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж /Биелэлт 73,2%/-тай үнэлэгдсэн.

2018 оны 3 дугаар удиралд Нийслэлийн Засаг даргын 7 захирамжийн хяналтад авсан 9 заалтын хэрэгжилтийг тооцож, Leader monitoring програмд байршуулсан. /Биелэлт 68,8%/

2018 оны 4-р улирлын байдлаар нийт 49 захирамжийн хяналтад авсан 79 заалтын хэрэгжилтийг гарган, биелэлт тооцсон захирамжлалын баримт бичгийн мэдээнд , хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгүүлэн 2018 оны 12 сарын 20-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнана.

Засгийн газрын 89 дүгээр тогтоолоор "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Нийслэлийн Засаг даргын А/335 дугаар

захирамжаар "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх журам"-ын хүрээнд Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт хариуцсан 22 албан хаагчид сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаа өгсөн.

Тогтоол шийдвэрийг Е Офисс програмаар мэдээлсэн байдал:

- ✓ 2018 оны 1 дүгээр улиралд 22 захирамжлалын баримт бичгийн хяналтад авсан 57 заалт,
- ✓ 2018 оны 2 дугаар улиралд нийт 50 захирамжлалын баримт бичгийн хяналтад авсан 99 заалт,
- ✓ 2018 оны 3 дугаар улиралд 28 захирамжлалын баримт бичгийн хяналтад авсан 81 заалтыг хэрэгжүүлэх хэлтэс албад бүрээр тус тус гаргаж http://eoffice.khanuul.mn/ програмын файлын санд байршуулж, хурдан хугацаанд захирамжлалын баримт бичигтэй холбоотой мэдээлэл авах, солилцох боломжийг бүрдүүлж ажилласан.
- ✓ 2018 оны 4 дүгээр улирлын захирамжлалын баримт бичгийн заалтыг нэгтгэн гаргаж http://eoffice.khanuul.mn/ програмын файлын санд байршуулна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан "Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам" болон Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/252 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын дагуу албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн http://www.edoc.ub.gov.mn системийг Засаг даргын Тамгын газар болон дүүргийн хэмжээнд өнөөдрийн байдлаар нийт 92 байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшил болгон ажилласан бөгөөд програмыг ашиглах үйл явцад зөвлөгөө, мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан.

Эхний хагас жилийн байдлаар ирсэн бичгийн шийдвэрлэлтийн нийт 35 удаагийн мэдээг Засаг даргын Тамгын газар болон дүүргийн EDOC програм ашиглагч 92 байгууллагыг хамруулан 7 хоног, сар, улирал, хагас жилээр гаргаж Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөн, Хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөн, Нийслэлийн Архивын Газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус танилцуулсан.

Засаг даргын Тамгын газрын албан бичиг боловсруулалтын үйл ажиллагаанд Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан MNS 5140-2011 стандартыг мөрдлөг болгон Улсын хэмжээнд цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэн ажиллах болсонтой холбогдуулан байгууллага бүр өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн албан хэрэг хөтлөлтийн дотоод зохицуулалт зайлшгүй шаардлага гарч ирсэн учир Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/252 дугаар захирамж, Дүүргийн Засаг даргын 2018 оны А/161 дүгээр захирамжийг тус тус үндэслэн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А/91 дүгээр тушаалаар "Засаг даргын Тамгын газрын албан хэрэг хөтлөлтийн дотоод журам"-ыг батлуулсан.

Тогтоол шийдвэрийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлуудаас:

Худалдаа, үйлчилгээний чиглэлээр: Салбарын хууль тогтоомж, стандартыг мөрдүүлэх үүднээс худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй **456,** хоол үйлдвэрлэлийн **191,**

аялал жуулчлалын **16**, ахуйн үйлчилгээний **102**, жижиг, дунд үйлдвэрлэлийн **27**, авто засвар, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй **34**, нийт **826** иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, гэрчилгээ олгоод байна.

2018 онд дүүргийн Засаг даргын 5 удаагийн захирамжаар 59 иргэн, аж ахуйн нэгжид тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгож, 15.045.000 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийг дүүргийн төсөвт төвлөрүүллээ.

Дүүргийн Засаг даргын 2018 оны А/36 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсэг "Үйлдвэрийн тооллого, судалгаа хийх" ажлыг зохион байгуулж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 80 иргэн, аж ахуйн нэгжээс судалгаа авч ажиглалтын судалгааг access программд шивж оруулсан.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, төрөөс хэрэгжүүлэх дунд хугацааны бодлого боловсруулах зорилгоор аж үйлдвэрийн салбарын цахим мэдээллийн санд үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэх ажлыг Үндэсний хөгжлийн газартай хамтран хэрэгжүүлсэн. Дээрх ажлын хүрээнд дүүргэт үйл ажиллагаа явуулж байгаа С ангиллын боловсруулах үйлдвэрүүдийн "Үйлдвэрийн тооллого"-ыг зохион байгуулж, нийт 328 байгууллагыг бүртгэсэн.

Дүүргийн Засаг даргын 2018 оны А/75 дугаар захирамжаар малын эмнэлэг үржлийн нэгжүүдийн дүүргийн Засаг даргатай 2017 онд байгуулсан хамтран ажиллах гэрээг дүгнэж. "ТҮДА"-32,3%, "Ганган буга" -45,3%, "Гүнтэрэм"-48,3%-иар тус тус хангалттүй дүгнэгдэж, мал эмнэлгүүдэд ажил сайжруулах хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг ханган ажилласан.

Мал амьтны гоц халдварт болон халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд төлөвлөгөөт 12 төрлийн вакцинжуулалтад 341757 мал амьтан, паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 67805 мал, ариутгал халдваргүйжүүлэлтийг давхардсан тоогоор 935000м^2 талбайд хийж гүйцэтгэсэн. Урьдчилан сэргийлэх зардалд 23,8 сая төгрөгийг зарцуулсан.

Мал, амьтныг эрүүлжүүлэх ажлын хүрээнд мал эмнэлгийн хяналт, ариутгал халдваргүйжүүлэлтийн цэгийг 12 дугаар хорооны Таван толгойн гүүрний уулзварт, 14 дүгээр хорооны Өлзийтийн товчоодод байгуулж, мал амьтанд халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг зохион байгуулж, мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал, амьтан оруулахгүй байх, зөвшөөрөлгүй малын шилжилт хөдөлгөөн, мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 27,5 сая төгрөгийг гарган, 10, 12, 13, 14 дүгээр хороонд мотоциклтой эргүүл томилон малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавин ажиллав.

Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүс буюу 4,5,6,7,8,9,10,11,16 дугаар хороонд нийт 79 өрхийн 2493 малыг зөвшөөрсөн бүс нутагт 100% нүүлгэн шилжүүлсэн.

МАЛТАЙ ӨРХИЙН МЭДЭЭЛЭЛ

Дүүргийн Засаг даргын 2018 оны А/227 дугаар захирамжаар мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс малаа нүүлгэн шилжүүлсэн өрхийн хашаа саравчийг буулгах, өтөг бууц ачих, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж **73** өрхийн малын хашаа саравчийг буулгаж, **378** тонн өтөг бууцыг цэвэрлэн тээвэрлүүлж, **23700м2** талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.

Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүс нутагт мал оруулахгүй байх, дүүргийн нутаг дэвсгэрт 2018 оныг дуустал мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан дүүргийн 4, 10 ,12, 14 дүгээр хороонд хөдөлгөөнт эргүүл, жижүүр ажиллуулахаар зорилгоор 4ш мотоцикл худалдан авч, хороодод хүлээлгэн өгсөн.

Сонгино-Хайрхан дүүргийн 21 дүгээр хороо 335 гарам, нарийн ферм байршилд нүүлгэн шилжүүлсэн мал бүхий өрхүүдийн өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцаж, хүнсний тусламж олгож, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, холбогдох газарт уламжилсан.

Дүүргийн Засаг даргын 2018 оны А/147, А/350 дугаар захирамжаар мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 2 удаагийн вакцинжуулалтыг гэрээт мал эмнэлэг үржлийн нэгжүүд хийж гүйцэтгэн давхардсан тоогоор 62 ажилтан албан хаагч 16 авто машинтай 55692 мал, 7175 амьтныг вакцинд хамруулан дүүргийн хэмжээнд 93.6 хувьтай хийгдсэн.

Өрх -**655**

Бог -**31344**

Бод -**24348**

Гахай -**7175**

"Манай хороо-Миний гудамж" аяны хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн өнгө үзэмжийг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн зүгээс Шаравын гудамжийг "Жишиг гудамж" болгон зүлэгжүүлж, цэцэгжүүлж, тохижуулахтай холбогдуулан "Хан-Уул агро" ОНӨААТҮГ-ийн дансанд 65 аж

ахуйн нэгжийн 9.291.000 төгрөгийг төвлөрүүлэн, тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг хийсэн.

Нийгмийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс хамтран 2018.05.24-ний өдөр зохион байгуулсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн өдөрлөг"-т оролцсон нийт 250 гаруй хүүхдэд "АПУ" ХК, "Витафит" группээс нийгмийн хариуцлагын хүрээнд бэлэг гардуулж, мэндчилгээ дэвшүүллээ.
- Мишээл экспо төв нь нийгмийн хариуцлагын хүрээнд 2018.03.09-ний өдөр тус төвд зохион байгуулагдсан "Хурд" хамтлагийн "Бүсгүй" тоглолтыг тус дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй 10 иргэнд үнэ төлбөргүй үзүүлсэн
- Боловсролын чиглэлээр: ЕБ-ын 10, 26, 114, 7, 118, 60-р сургууль дээр 3-р сараас эхлэн долоо хоногийн 3 өдөрт сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ явагдаж байна. Уг үйлчилгээг Монгол өрх болон Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэнгээс авч байгаа бөгөөд "Дэлхийн зөн" ОУБ-аас санхүүжүүлж байна.
- Албан бус насан туршийн боловсролын төвд дугуйлан секцэд хамрагддаг хүүхдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор "Гүүд нэйборс" ОУБ-аас 10 гитар хандивлалаа.
- Хөдөлмөр халамжийн чиглэлээр: Дэлхийн зөн ОУБ-д хамрагддаг зорилтот бүлгийн нийт 27 иргэнийг Албан бус, насан туршийн боловсролын төвд явагдаж байгаа оёдолын сургалтад 25, үсчин гоо сайхны сургалтад 2 иргэнийг хамрууллаа.
- Зорилтот өрхүүдийн санхүүгийн менежментийг сайжруулах хүрээнд 38 өрхөд нүүрс, 12 өрхөд хүнс, 8 өрхөд гэрийн дэмжлэгийг "Дэлхийн зөн" ОУБ-аас үзүүллээ.
- ОУБ, ТББ-уудын тэтгэлэгт хүүхдүүдийг шинээр нэмж хамруулах ажлын хүрээнд 3 жилийн хугацаатай хэрэгжих "Хүүхэд хамгаалалд орон нутгийн оролцоо" тусгай төсөлд 4,6,11-р хорооны 250 хүүхэд хамрууллаа.
- Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн чиглэлээр: ЕБ-ын 10, 26, 114, 7, 118, 60-р сургууль тус бүр дээр "Оролцоод хөгжье" клуб байгуулагдан нийт 240 хүүхэд хамрагдан тогтвортой ажиллаж байна.
- Гэр бүл хүүхэд залуучуудын хамгаалалын чиглэлээр Цагдаагийн 1-р хэлтэс дээр сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хамгаалах байрыг тохижуулахаар өгсөн хүсэлтийг үндэслэн холбогдох эд зүйлсийг авч өгсөн боловч, өрөө байр хүрэлцээгүй гэсэн шалтгаанаар зориулалтын дагуу ажиллуулаагүй байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 6 хүүхэдтэй ээжид хорооны хамтарсан багийн хурлын протоколыг үндэслэн Дэлхийн зөн ОУБ-аас гэр олгууллаа.
- "Дэлхийн зөн Хан-Уул орон нутгийн хөгжлийн хөтөлбөр"-т хамрагддаг зорилтот хороодын ЕБ-ын 10, 26, 114, 7, 118, 60-р сургууль дээр 3-р сараас эхлэн ажиллаж байгаа Монгол өрх болон Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэнгийн сэтгэл зүйчид сургуулийн нийгмийн ажилтан болон анги удирдсан багш нарын санал болгосон эрсдэлтэй бүлгийн хүүхэд болон өрхийн гишүүдэд сэтгэл зүйн ганцаарчилсан болон зөвлөх үйлчилгээг үзүүлж байна.

Өвөл, хаврын улирлын хурдан морины уралдааны тухай 2018.01.19-ний 19 дүгээр тогтоолын хэрэгжилт:

2018 оны хаврын тэргүүн сарын шиний 1-ний өдрөөс 4 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар тус дүүргийн нутаг дэвсгэрт албан ёсоор хурдан морины уралдаан, сунгаа явагдаагүй болно. Тус дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт малчид амьдардаг бөгөөд хорооны Хөгжлийн нийгмийн ажилтан хурдан морь унаач хүүхдүүдийн судалгааг гаргасан. Мөн 14 дүгээр хороонд бүртгэлтэй түр болон байнгын оршин суугаа хаягтай хурдан морь унаач 110 хүүхэд байна. Судалгаанд хамрагдсан унаач хүүхдүүдэд сургууль завсардалт гараагүй бөгөөд хүүхдүүд Нийслэлийн 59 дүгээр сургуульд суралцаж байна.

Дүүргийн 14 дүгээр хорооны Хөгжлийн нийгмийн ажилтан, 59 дүгээр сургуулийн Нийгмийн ажилтан нар хамтран 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс 03 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл хугацаанд хурдан морь унаач 51 хүүхдийн гэрээр очиж уулзалт хийн, зөвлөгөө өгсөн бөгөөд 2018 оны 03 дугаар сарын 22-ны өдөр хүүхдүүдийн эцэг эхчүүдэд /нийт 66 иргэн/ хорооны хамтарсан баг хүүхэд хамгаалллын тухай хуулиар сургалт зохион байгуулж, зөвлөмж, гарын авлага тараав.

ОУБ, ТББ-уудын тэтгэлэгт хүүхдүүдийг шинээр нэмж хамруулах ажлын хүрээнд 3 жилийн хугацаатай хэрэгжих "Хүүхэд хамгаалалд орон нутгийн оролцоо" төслийг төсөлд 4,6,11-р хорооны 250 хүүхэд хамрууллаа.

- Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн чиглэлээр:

ЕБ-ын 10, 26, 114, 7, 118, 60-р сургууль тус бүр дээр "Оролцоод хөгжье" клуб байгуулагдан нийт 240 хүүхэд хамрагдан тогтвортой ажиллаж байна.

Гэр бүл хүүхэд залуучуудын хамгааллын чиглэлээр Цагдаагийн 1-р хэлтэс дээр сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хамгаалах байрыг тохижуулахаар өгсөн хүсэлтийг үндэслэн холбогдох эд зүйлсийг авч өгсөн боловч, өрөө байр хүрэлцээгүй гэсэн шалтгаанаар зориулалтын дагуу ажиллуулаагүй байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 6 хүүхэдтэй зөжид хорооны хамтарсан багийн хурлын протоколыг үндэслэн "Дэлхийн зөн" ОУБ-аас гэр олгууллаа.

Дэлхийн зөн Хан-Уул орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдаг зорилтот хороодын ЕБ-ын 10, 26, 114, 7, 118, 60-р сургууль дээр 3-р сараас эхлэн ажиллаж байгаа Монгол өрх болон Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэнгийн сэтгэл зүйчид сургуулийн нийгмийн ажилтан болон анги удирдсан багш нарын санал болгосон эрсдэлтэй бүлгийн хүүхэд болон өрхийн гишүүдэд сэтгэл зүйн ганцаарчилсан болон зөвлөх үйлчилгээг үзүүлж байна.

Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг жигд хүртээмжтэй үзүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, Эрүүл мэндийн төвийн дарга Э.Бодьцэцэг нар 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нартай Гүйцэтгэлийн гурвалсан гэрээг байгууллаа.

Хүн амын бие бялдрын хөгжилт чийрэгжилтийн түвшин тогтоох сорил: Биеийн тамир, спортын хороо, Эрүүл мэндийн төвтэй хамтран "Хүн амын бие бялдрын хөгжилт чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ын 2 сарын аяныг 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 2018 оны 05 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус сорилын аяны хүрээнд Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, албад, аж ахуйн нэгж байгууллагууд, хороод, Ерөнхий боловсролын сургуулиуд, цэцэрлэгүүд зэрэг нийт 82 байгууллагын 19850 ажилтан, албан хаагч, иргэд, сурагч, хүүхдүүдийн бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг авч, дүнг нэгтгэн гаргасан.

"Улаанбаатар Марафон-2018" олон улсын гүйлтийн тэмцээн: Монгол Улсад гүйлтийн спортыг хөгжүүлэх, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх, өсвөр, залуу үеийнхэнд өөрийн дотоод нөөц боломжийг нээж, тэсвэр хатуужил, бие бялдрын болон оюун санааны өв тэгш хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэдийг өдөр тутмын биеийн тамираар хичээллэх идэвх санаачлагыг дэмжих зорилгоор "Улаанбаатар Марафон-2018" олон улсын гүйлтийн тэмцээнд Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, албад, хороод, аж ахуйн нэгж байгууллагын нийт 6000 гаруй ажилтан, албан хаагчид, иргэд амжилттай оролцлоо. 55-аас дээш насны ангилалд 4 дүгээр хорооны иргэн З.Сундуй 4 дүгээр байрт, гэр бүлийн ангилалд Тэмүүжингийн гэр бүл 2 дугаар байр эзэллээ.

Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг дэмжин ажиллах: Нийслэлийн Засаг даргын 2007 оны 621 дүгээр захирамжын дагуу Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг спортын 9 төрлөөр байгуулсан. Үүнд:

- Сагсан бөмбөгийн дасгалжуулагчаар Спортын мастер М.Гантөмөр

- Волейболын дасгалжуулагчаар Спортын мастер Ж.Пүрэвжав
- Жүдо бөхийн дасгалжуулагчаар Монгол Улсын Гавьяат дасгалжуулагч Ш.Цэвэлмаа
- Тэшүүрийн дасгалжуулагч Олон улсын хэмжээний мастер Л.Алтанцэцэг
- Хөл бөмбөгийн дасгалжуулагчаар Спортын мастер Б.Болд
- Ширээний теннисний дасгалжуулагчаар Спортын мастер Д.Мөнхсайхан
- Чөлөөт бөхийн дасгалжуулагчаар Ж.Баярхүү
- Софт теннисний дасгалжуулагчаар А.Хулан
- Шатрын дасгалжуулагчаар Ш.Ганбаатар

2018 онд өсвөрийн шигшээ багийн 238 тамирчид ОУАШТ-ээс хүрэл-4, УАШТ-ээс алт-21, мөнгө-10, хүрэл-12, ХАШТ-ээс алт-16, мөнгө-20, хүрэл-24, нэрэмжит тэмцээнээс алт-9, мөнгө-11, хүрэл-4611 ширхэг нийт 138 медалиудыг хүртсэн.

“Илрүүлэлт-2018” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулав: Өвлийн улиралд хүүхдийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлж, хараа хяналтгүй болон хараа хяналт сул хүүхдийг илрүүлж хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх, бүрттэл хяналтад авах Нийслэлийн Засаг даргын 2018 оны 11 сарын 02-ны 03/698 дугаар захирамжийн дагуу “Илрүүлэлт-2018” нэгдсэн арга хэмжээний 4 дүгээр улирлын арга хэмжээг 2018 оны 11 дүгээр сарын 12-22-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг илрүүлэлтэд ГБХЗХХ, дүүргийн Прокурорын газар, Цагдаагийн 1,2 дугаар хэлтсийн албан хаагч нар хамтран ажилласан. Үйл ажиллагааны үеэр 14-17 насны нийт 34 хүүхдийг илрүүлж 27 хүүхдийг ар гэрт нь, 5 хүүхдийг ХТУ-108-ын түр хамгаалах байранд, 2 хүүхдийг хэлтсийн харьяа түр хамгаалах байранд тус тус хүлээлгэн өгсөн.

Нийт 25 цахим тоглоомын газар илрүүлэлт хийж зөрчилтэй 2 цахим тоглоомын газрыг хааж толгой компьютерыг хурааж авч арга хэмжээ авсан, 14 караоке паб, шөнийн цагаар архи согтууруулах ундаа борлуулж байсан 5 хүнсний дэлгүүр, 4 зочид буудал, 1 амралтын газарт хяналт тавьж эргүүл хийсэн.

Тохижилтын чиглэлээр:

МУЗГ-ын 2018 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай”

Эрчим хүчний яамны 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 7, 8 дугаар хороодын 60-р сургууль, 118-р сургууль, 209-р цэцэрлэгийг төвлөрсөн халаалтад холбох 1.5 км урт шугам хоолойн угсралт, под станц барих ажлыг “Тэргүүн инвест” ХХК гүйцэтгэж, ашиглалтад оруулсан.

Эрчим хүчний яам, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газар, Эрчим хүчний зохицуулах хороотой хамтарч янданд шүүлтүүр суурилуулах ажлын судалгааг 4, 5, 6, 7, 8, 9, 10, 16 дугаар хороодын 15-100 кВт, 100 кВт-аас дээш хүчин чадалтай 12 уурын болон усан халаалтын зуухнуудад хийсэн.

Монгол Улсын Их Хурлын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 212 дугаар захирамжийн дагуу Улсын Их Хурал болон Байнгын хороо, дэд хорооноос агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01/01 дугаар тогтоол гаргаж Дэд ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг 2018 оны 01 дүгээр сарын 13,26-ны өдрүүдэд Хан-Уул дүүрэгт ажиллаж 7 дугаар хороонд байрлах "Түшигт хангай" ХХК-ийн уурын зуухаар дулаанаа хангадаг 60 дугаар сургууль, 73-р цэцэрлэг, "Говийн 16" ажилчдын байр, 7, 8 дугаар хорооны байр зэрэг 2018 онд төвлөрсөн халаалтын шугамд холбогдох газрууд болон агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн, цаашид хэрэгжүүлэх ажлын явц, 11 дүгээр хорооны "Монгол түлш" ХХК-ийн газрын гүний дулаанаар ашиглан хэрэглээний халуун ус, хөргөлт, дулаан хангамжаа шийдвэрлэсэн "Ногоон шийдэл" технологитой тус тус танилцсан.

МУЗГ-ын 62 дугаар тогтоолоор батлагдсан "Түүхий нүүрсийг хориглох тухай" журмын дагуу хийгдсэн ажил

"Байгальд ээлтэй техник технологийн" үзэсгэлэн худалдааг 1 сарын хугацаанд хороодод бүсчлэн зохион байгуулж, 9750 иргэнийг оролцуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2018 оны 08 дугаар сарын 9-ний өдрийн "Түлээ нүүрсний цэгийн тоо гаргах" тухай удирдамжийн дагуу Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газартай хамтарч дүүргийн хэмжээнд байгаа нүүрс борлуулах цэгийн нэгдсэн тооллого

явуулж, дүн мэдээг гаргасан. Дүүргийн хэмжээнд нийт 90 цэгт 135024 шуудай буюу 810.34 тн мод, 891760 шуудай буюу 22294 тн нүүрс худалдаалдаг гэсэн дүн гарсан.

Энэ тогтоолын хүрээнд 4, 5, 6, 7, 8, 9, 10, 16-р хорооны нутаг дэвсгэрт сайжруулсан болон боловсруулсан түлш худалдан борлуулах цэг тогтоож, хаягжилт хийсэн.

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын "Агаарын бохирдлыг бууруулах хяналтын алба"-тай хамтарч "Уурын зуухаңд боловсруулсан түлш хэрэглэх" талаар үзүүлэх сургалтыг 8 дугаар хорооны 118-р сургуулийн уурын зуухаңд зохион байгуулсан.

2017 он, 2018 онд Агаарын бохирдлын чиглэлээр хийгдсэн ажлын харьцуулалт

Д/д	Зохион байгуулсан ажил	2017	2018
1	Уурын халаалтын зуухаңд хийсэн хяналт шалгалтын тоо	30	35
2	Уурын халаалтын зуухны галч нарт зохион байгуулсан сургалт	2	4
3	Уурын халаалтын зуухны удирдлагуудад зохион байгуулсан сургалт	2	4
4	Цахилгаан халаалт олгосон өрх	-	28
5	Сайжруулсан түлш олгосон өрх	-	12

2.2 Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд хэрэгжүүлэхээр зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын холбогдолтой мэдээлэл;

"Тохижилт, төрийн үйлчилгээг сайжруулах жил"-ийн хүрээнд дүүргийн иргэд, ААНБ-уудад Засаг даргын Тамгын газраас уриалга хүргүүлж, "Манай хороо-Миний гудамж" аяны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган биелүүлэхийн тулд дүүргийн дэд ажлын хэсэг байгуулж, 88 ажлыг гүйцэтгэх нэгдсэн төлөвлөгөө гаргаж ажилласан.

"Манай хороо-Миний гудамж" аяны удирдамжийн шалгуур үзүүлэлтүүдийг иргэд, олон нийтэд сурталчилж, дүүргийн хэмжээнд 1500 аж ахуйн нэгж байгууллага, 16 хорооны иргэдтэй хамтран ажиллалаа. Аяны хүрээнд аж ахуйн нэгж байгууллагууд өөрсдийн хөрөнгөөр 9 ажлыг шинээр санаачлан ЗДТГ-тай хамтарч 1,7 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажлыг хийж хэрэгжүүлсэн.

Аяны хүрээнд хийгдсэн томоохон тохижилт, бүтээн байгуулалтууд:

Дүүргийн 15 дугаар хорооны "Баясгалант дэлхий эмнэлэг" өвөрийн 25:0 сая төгрөгийн хөрөнгөөр орчноо тохижуулсан.

Дүүргийн 9 дүгээр хорооны "Авто шил" ХХК-ийн 2018 онд хийсэн тохижилт

Дүүргийн хэмжээнд шинээр нийт **475** автомашины зогсоолыг шинээр байгуулж, **2762** авто зогсоолыг засварласан.

Дүүргийн нутаг дэвсгэрт явган хүний зам шинээр хийсэн талаар:
Дүүргийн хэмжээнд нийт 14816 м^2 талбайд явган хүний зам шинээр байгуулж, 2502 м^2 талбайн явган хүний замыг засварласан.

Аяны хүрээнд нийт шинээр 114 ширхэг сандал, 102 ширхэг хогийн сав байршуулж, 229 ширхэг сандал, 28 ширхэг хогийн савыг засварлах ажлыг зохион байгуулсан.

Тус аянд идэвхи санаачлагатай оролцож Хан-Уул дүүрэг **“Шилдэг дүүрэг” 1-р байр,** шилдэг тохижилттой ААНБ /орон сууц хороллын/ номинацид Гоёо ХХК” 1-р байр, “Баясгалант дэлхий эмнэлэг” тусгай байр; шилдэг тохижилттой ААНБ /гэр хороллын/ номинацид “Авто шил” ХХК 2-р байр; шилдэг тохижилттой гэр хороллын айл өрх номинацид Ж.Очирбат 1-р байр, “Шилдэг гэр хороо” номинацид 13 дугаар хороо 2 –р байрт тус тус шалгарсан.

ГЭРЭЛТҮҮЛГИЙН ЧИГЛЭЛЭЭР: “ГЭРЭЛТЭЙ ХОТ” АЯН

Нийслэлийн Засаг даргын санаачлагаар хэрэгжүүлж байгаа “Гэрэлтэй хот” аяны хүрээнд бүртгэлгүй, ашиглагч эзэн тодорхойгүй, асдаггүй 197 ширхэг гэрэлтүүлгийн судалгааг гарган бүртгэлжүүлж “Новэлнэтворк” ХХК-д хүлээлгэн өгсөн. Судалгааны дагуу ашиглагч эзэн тодорхойгүй гэрэлтүүлгүүдийг засварлах ажил үе шаттайгаар хийгдэж байна.

Тус аяны хүрээнд 15 дугаар хорооны “Japan town” хотхоны зам дагуух асдаггүй, тусгал муутай 100 Вт-ийн 22 ширхэг хос, 12 ширхэг дан гэрэлтүүлгийн толгойн хүзүүг сунгаж 150 вт болгон сайжруулж засварласан.

15 дугаар хорооны Гандийн гудамжинд байрлах Соёмботой хөшөөг гэрэлтүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хаяг рекламны байгууламжийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/242 дугаар тушаалын дагуу нийтийн эзэмшлийн гудамж талбайд хаяг реклам байршуулахад дагаж мөрдөх журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор стандартын шаардлага хангаагүй томоохон аж ахуйн нэгж байгууллагуудад хаяг рекламыг буулгах албан мэдэгдэл өгч ажилласан. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн хана болон хашаан дээр байршуулсан 272 ширхэг хэвлэмэл хулдаасан хаягийг хуулж, 15 ширхэг модон самбар, 11 ширхэг төмөр самбарыг буулгаж ажилласан.

Наадамчдын замын голоор байршуулсан төмөр суурьтай хаяг рекламуудыг буулгасан.

Хотын Ерөнхий менежерийн А/32 дугаар тушаалын дагуу дүүргийн Чингисийн өргөн чөлөөний замын 2 талаар байрлах хулдаасан болон төмөр хаягийн байгууламжтай 26 аж ахуйн нэгж байгууллагын хаяг рекламыг пластик материал дээр товгор үсэгтэй, хаягийн байгууламжийн гэрэлтүүлэгтэй болгон шинэчилж, журмын хэрэгжилтийг ханган ажилласан.

Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн шон болон хашаан дээр наасан нийт **803** ширхэг массажны зарыг хуулж ажиллаж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: "БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН"

3.1 Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл;

Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийслэл, дүүргийн төр, захиргааны байгууллагын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн: Нийслэлийн төр захиргааны байгууллагын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 23 удаа зохион байгуулагдан нийт 177 үүрэг даалгавар өгөгдөж, 88,9 хувьтай биелсэн байна. Биелэлтийг 14 хоног тутам пүрэв гарагт хугацаанд нь https://backend.ulaanbaatar.mn/ программ мэдээлж ажилласан.

Дүүргийн төр, захиргааны байгууллагын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 12 удаа зохион байгуулсан. Шуурхай зөвлөгөөнөөс дүүргийн Засаг даргын өгсөн нийт 131 үүрэг даалгавар 87,5 хувьтай биелэгджээ. Шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгавар болон биелэлтийг http://www.khanuul.mn/ сайтад тухай бүр байршуулж байна.

Нийслэлийн төр, захиргааны байгууллагын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд мэдээллэдэг дүүргийн 14 хоногийн Гэмт хэрэг, зам тээврийн осол, аваарын нөхцөл байдал, Онцгой комиссын мэдээлэл, Газрын харилцааны зөрчил, Хөрөнгө оруулалтын ажлын явц, үр дүнгийн талаарх мэдээллийг холбогдох хэлтэс, албадаас хүлээн авч нэгтгэн ажилласан.

Засаг даргын зөвлөлийн хурал: Засаг даргын зөвлөлийн хурал 16 удаа хуралдан 87 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн.

Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөн: 2018 онд Засаг даргын Тамгын газрын шуурхай зөвлөгөөнийг нийт 38 удаа зохион байгуулсан 318 үүрэг даалгавар өгөгдөн жилийн эцсийн байдлаар 96%-тай хэрэгжсэн байна.

Хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөн: Хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөн 9 удаа зохион байгуулагдаж, 52 үүрэг даалгавар өгөгдсөн 90.7 хувьтай хэрэгжсэн.

Тамгын газрын тайлангийн хурал: Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын эхний хагас жилийн тайлангийн хурлыг 2018 оны 06 дугаар сарын 09-ний өдөр, жилийн эцсийн тайлангийн хурлыг 12 дугаар сарын 26-ны өдөр тум тус зохион байгуулж, хурлаар хэлтэс, тасгуудын 2018 оны үйл ажиллагааны тайланг сонсч, Тамгын газрын дарга 2018 онд хийсэн ажлын алдаа, оноог дүгнэн үг хэлж, ажлын үр дүнгээрээ хамт олноо мангайлсан албан хаагчдыг шагнаж урамшуулсан. Зөвлөгөөнд 9 хэлтэс, тасгийн нийт 64 албан хаагч оролцсон.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар: Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Хан-Уул дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгасан зорилтуудыг удирдлага болгон 2018 оны Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан заалтуудыг хэрэгжүүлэхэд гол анхаарлаа хандуулан ажиллав.

Гадаад томилолт:

Япон Улсын Мусашимураяама хотод НЗД-ын А/238 дугаар захирамжиийн дагуу Засаг дарга Ж.Алдаржавхлан тэргүүтэй Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид 2018 оны 03 дугаар сарын 26-31-ний өдрүүдэд тус хотын даргын урилгын дагуу албан айлчлал хийв.

Айлчлалын үеэр боловсрол, соёл урлаг, спорт, эрүүл мэнд зэрэг чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тохиролцов. Үүнд: хоёр тал бага ангийн сурагчдын дунд зохиогдох сумо бөхийн тэмцээнд Хан-уул дүүрэг болон Мусашимураяама хотын сургуулийн бага ангийн сурагчдыг идэвхтэй оролцуулах, хоёр талын соёлын өдрүүдийг зохион байгуулж сурталчлах зэрэг ажлуудыг зохион байгуулахаар болов. Мөн Хамтын ажиллагааны Санамж бичгийг 2018 оны 07 дугаар сард байгуулахаар тохиролцов.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Гёнсан аймгийн Хаман Сумтай 2011 оноос хойш хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Цэрэн тэргүүтэй Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон ИТХ-ын төлөөлөгчид 2018 оны 04 дүгээр сарын 19-нөөс 04 дүгээр сарын 25-ны өдрүүдэд тус сумаңд албан айлчлал хийв. Айлчлалын хүрээнд Хаман сумын Мэдээллийн Хяналтын Төв болон Гёнсан Их Сургуулийн үйл ажиллагаатай танилцаж Аражэ соёлын арга хэмжээнд оролцов.

Цаашид хамтын ажиллагааг тогтворжуулж, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, Эко дүүрэг болох зорилтын дагуу ногоон байгууламжийн чиглэлээр хамтарч ажиллах талаар харилцан санал солилцсоны үр дүнд тарвасын хүлэмж байгуулах, И Тэ Жүн багшийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнг засварлаж тохижуулах ажлыг хийхээр тохиролцов.

Бүгд Найрамдах Болгар Улсын Софи хотын Изгрев дүүрэгт НЗД-ын А/484 дүгээр захирамжийн дагуу Засаг дарга Ж.Алдаржавхлан тэргүүтэй Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон ИТХ-ын төлөөлөгчид 2018 оны 06 дугаар сарын 09-нөөс 06 дугаар сарын 16-ны өдрүүдэд тус дүүргийн Засаг даргын урилгын дагуу албан айлчлал хийв.

Хоёр дүүргийн хамтын ажиллагааг өргөжүүлж, шинэ шатанд гаргах зорилгоор хийсэн тус айлчлалаар дэд бүтэц бүтээн байгуулалт, хот төлөвлөлт, тохижилт, ногоон байгууламжийн чиглэлээр хамтран ажиллахаар болов.

Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотод зохион байгуулагдсан "Боловсрол-2018" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд дүүргийн ЗД-ын А/186 дугаар захиражийн дагуу Засаг даргын нэгдүгээр орлогч Г.Батсайханаар ахлуулсан Засаг даргын Тамгын газрын албан хаагчид 2018 оны 06 дугаар сарын 26-наас 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд оролцож туршлага судлав.

Бага хурлын үеэр дүүргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж, өргөжүүлэхээр олон улсын их дээд сургууль, шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн эрдэмтэд, төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулж цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов.

БНХАУ-ын ӨМӨЗО-ын Эрээн хотод зохион байгуулагдсан "БНХАУ, ОХУ, Монгол Улсын Эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны Эрээн хот чуулга уулзалт"-д ИТХ-ын дарга Б.Цэрэн тэргүүтэй дүүргийн төлөөлөгчид 2018 оны 08 дугаар сарын 16-наас 08 дугаар сарын 21-ний өдрүүдэд тус хотын даргын урилгын дагуу оролцов.

Айлчлалын үеэр БНХАУ, ОХУ, Монгол Улсын худалдаа аж үйлдвэрийн салбарын дээд хэмжээний уулзалтад оролцож 3 улсын худалдаа аж үйлдвэрийн тэнхимийн дарга нартай уулзав. Мөн түүнчлэн, "Орон нутгийн шинэ хамтын ажиллагаа, шинэ хөгжлийг дэмжих нь" сэдэвт БНХАУ, ОХУ, Монгол Улсын бүс нутаг хоорондын Захиргааны хамтын ажиллагааны форумд оролцож 3 улсын хот, сум, дүүргүүдийн засаг дарга нартай уулзав.

Тус арга хэмжээ нь БНХАУ, ОХУ, Монгол Улсын эдийн засгийн коридорыг байгуулах тухай хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Монгол, ОХУ руу нээлттэй шинэ бүтцийг байгуулах, гурван улс хоорондын найрсаг хамтын ажиллагаа өргөжүүлэх өргөн хүрээний арга хэмжээ болов.

БНХАУ-ын Гуанжоу хотод зохион байгуулагдсан “Кантон Фэйр /Canton Fair/” үзэсгэлэн болон олон улсын худалдааны хөгжлийн чуулганд дүүргийн ЗД-ын А/335 дугаар захирамжийн дагуу дүүргийн төлөөлөгчид 2018 оны 10 дугаар сарын 18-наас 10 дугаар сарын 26-ны өдрүүдэд оролцож олон улсын жижиг дунд бизнес эрхлэгч, үйлдвэрлэгчидтэй харилцаа холбоо тогтоох чиглэлээр уулзалтууд зохион байгуулав.

Япон Улсын Мусашимураяама хоттой 2018 оны 07 дугаар сарын 10-ны өдөр “Токио-2020” зуны Олимп, Пара-Олимпын наадмын “Хүлээн Авагч Хот (Host Town)” төслийн хүрээнд байгуулсан харилцан ойлголцлын Санамж бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор сурагч солилцооны хөтөлбөрийг эхлүүлэв. Тус хөтөлбөрт тэнцсэн дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг дүүргийн ЗД-ын А/12 дугаар захирамжийн дагуу Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Ц.Одонтунгалаг ахалж 2018 оны 10 дугаар сарын 26-наас 10 дугаар сарын 29-ний өдрүүдэд тус хотод албан томилолтоор ажиллав.

Айлчлалын үеэр Мусашимураяама хотын дарга Фужино Масару, Мусашимураяама хотын ИТХ-ын дарга, Монгол улсаас Япон улсад суугаа Элчин сайд Батжаргал тэргүүтэй төлөөлөгчид болон тус хотын сургуулийн сурагчдын хамт нийт 110 хүн хүлээн авч уулзав. Мөн түүнчлэн, тус хотын соёлын Дээдара арга хэмжээнд оролцов. Үүнээс гадна, өсвөрийн сумо бөхийн тэмцээнд дүүргийн хүүхдүүд амжилттай оролцож 2 хүүхэд хүрэл медалийн эзэд болов.

“Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд Тамгын газрын албан хаагчдыг гадаадын дунд болон богино хугацааны сургалт, семинарт хамруулах зорилгоор Австрали Улсын Сидней хотод зохион байгуулагдсан мэргэшсэн нягтлан бодогчдын олон улсын бага хурал, сургалт семинарт дүүргийн ЗДТГ-ын даргын А/144 дүгээр тушаалын дагуу Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг хамруулав. Тус арга хэмжээнд 2018 оны 11 дүгээр сарын 03-наас 11 дүгээр сарын 13-ны өдрүүдэд Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга М.Цогзолмаа болон ерөнхий нягтлан бодогч З.Буянт нар оролцов.

Тус чуулганаар технологийн хувьсал, санхүүгийн мэдээллийн зөв ашиглалт, хиймэл оюун ухаанаар дамжуулан шийдвэр гаргах зэрэг дэлхий нийтийн анхаарал татаж буй асуудлуудыг хэлэлцэж 4 өдрийн турш нийт 6 нэгдсэн хуралдаан, 30 салбар хуралдаан, 14 мэргэжлийн үзэсгэлэн зохион байгуулагдав.

Америкийн Нэгдсэн Улсын Сан Франциско, Денвер хотуудад дүүргийн ЗД-ын А/362 дугаар захирамжийн дагуу Засаг даргын Тамгын газрын дарга Б.Энхболд нь 2018 оны 11 дүгээр сарын 23-наас 12 дугаар сарын 02-ны өдрүүдэд НЗДТГ-ын дарга болон бусад 8 дүүргийн ЗДТГ-ын дарга нарын хамт албан томилолтоор ажиллав.

Зочид төлөөлөгчид

Гадны зочид, төлөөлөгчдийн албан айлчлалын үеэр шаардлагатай бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллав.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон БНСУ-ын Жинжу хотын Гёнсан Их Сургууль нь 2015 онд хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна. Тус сургуулийн төлөөлөгчдийг 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр хүлээн авав.

Хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор тус их сургуулийн танилцуулах нээлттэй өдөрлөгийг 2018 оны 04 сарын 28-ны өдөр Хан-Уул Соёлын ордонд дүүргийн ерөнхий боловсролын бүх сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулав.

Үр дүнд 2019 оны хаврын элсэлтэнд зориулсан Солонгос хэлний эрчимжүүлсэн сургалт болон бакалаврын түвшний хөтөлбөрт Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 11 төгсөгчийг сонгон шалгаруулж 100%-ийн тэтгэлгээр суралцуулж байна.

БНСУ-ын Улсын Бусан хотын Хэүндэ дүүргийн дэргэдэх “Сайн дурын үйлчилгээ үзүүлэх төв” байгууллагаас тэргүүн Рай Ва Сон-аар ахлуулсан нийт 24 хүний бүрэлдэхүүнтэй баг, хамт олон 2018 оны 05 дугаар сарын 06-13-ны өдрүүдэд хүрэлцэн ирж сайн дурын үйлчилгээ үзүүлэв.

Тус төвийн баг хамт олныг дүүргийн ЗДТГ-ын даргын А/79 дүгээр тушаалын дагуу 2018 оны 05 дугаар сарын 09-ний өдөр дүүрэгт хүлээн авч уулзаж цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Мөн түүнчлэн, тус байгууллага нь 29 дүгээр цэцэрлэгийн гадна талбайн засвар тохижилтыг хийж цэцэрлэгийн хүүхэд багачуудад эрүүл мэнд, боловсролын чиглэлээр сургалт зохион байгуулан нийт 40 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэв.

Нэг цэгийн үйлчилгээний танхимын үйл ажиллагааны чиглэлээр:

"Нэг цэгийн үйлчилгээ"-ний өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг ханган хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 121045 иргэн үйлчлүүлсэн байна. Нэг цэгийн үйлчилгээний төвөөр өдөрт 200-300 иргэн тогтмол үйлчилгээ авдаг бөгөөд Төрийн үйлчилгээний мэдээлэл лавлагаа, Өргөдөл гомдол хүлээн авах төв, Эд хөрөнгийн бүртгэл, Гадаад паспорт хүлээн авах, Улаанбаатар хотын банк, Нотариат , Кадастр, Зурагчин, канон зэрэг 11 цонхоор 45 төрлийн үйлчилгээ хүргэдэг. Үүнээс гадна иргэдэд зориулан лавлагаа авдаг ТҮЦ машин, Ухаалаг мэдээллийн самбар байрлуулсан. Энэхүү самбараар дамжуулан иргэд төрийн үйлчилгээ авахад ямар бичиг баримт бүрдүүлэх хэрэгтэй байна тэр бүхний мэдээлэл бүрэн харагдана. Түүнчлэн шаардлагатай бичиг баримтаа энэхүү ухаалаг самбараасаа шууд удирдан хэвлэн авах боломжтой юм.

Мөн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадаас ухаалаг мэдээллийн самбарын мэдээллийг шинэчлэх болсонтой холбогдуулан ЗДТГ-ын даргын 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01/861 тоот, 2018 оны 11 сарын 28-ны өдрийн 01/2305 албан бичгээр саналыг хүлээн авч мэдээллийг байршуулсан. Ухаалаг мэдээллийн дэлгэцээр бүтэн жилийн хугацаанд 4000 гаруй иргэн үйлчлүүлээд байна. Дараах хэлтэс, албад төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна. Үүнд:

ЗДТГ-ын хэлтэс, тасаг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Татварын хэлтэс, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Албан бус насан туршийн боловсролын төв, Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ, Биеийн тамир спортын хороо, Бүртгэлийн хэлтэс, Соёлын ордон, Газрын алба, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Цагдаагийн нэгдүгээр хэлтэс, Статистикийн хэлтэс

Нийт үйлчлүүлсэн иргэдийн тоо /давхардсан тоогоор/

Д/д	Үйлчилгээний төрөл	Бүтэн жилийн байдлаар
		/Өссөн дүнгээр/
1	УБ хотын банк /гүйлгээ/	65319
2	ЭХЭБ	25699
3	Гадаад паспорт	11506
4	Нотариат	5269
5	Канон, түргэн зурагчин	8700
6	Газрын кадастр	4552
	Нийт дүн	121045



Мэдээлэл технологийн чиглэлээр:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон 16 хороодод Нийслэлийн Архивын газрын Албан хэрэг хөтлөлтийн EDOC.UB.GOV.MN болон ERP.ULAANBAATAR.MN нэгдсэн систем, Khanuul.mn, Eoffice.khanuul.mn болон 16 хороодын цахим хуудсуудын мэдээллийн баяжилт болон вэб серверүүдийн өдөр тутмын тасралтгүй хэвийн ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Хан-Уул Дүүргийн Засаг Даргын Тамгын газар болон 16 хороодод цаг бүртгэлийн нэгдсэн системийг бүрэн хянаж, ажлаас чөлөөлөгдсөн болон шинээр ажилд томилогдсон албан хаагчдын бүртгэлийг цаг тухай бүрт нэмж, 300 орчим алиан хаагчдын нэгдсэн болон дэлгэрэнгүй тайланг шуурхай гарган ажиллаж байна.

Засаг даргын Тамгын газар, хороодод 2018 оны жилийн эцсийн байдлаар компьютер болон дагалдах техник хэрэгслийн засварын чиглэлээр нийт 114 ажил хийгдэж, Вэб сервер, Санхүүгийн сервер, цаг бүртгэлийн сервер, СМС илгээх програм хангамжийн сервэр, Kaspersky серверүүдийн байнгын найдвартай хэвийн ажиллагаанд өдөр бүр хяналт тавин ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны хуулийн дагуу шаардлагатай мэдээллүүдийг khanuul.mn цахим хуудсанд тогтмол байршуулж байна.

Албан хаагчдын компьютерт суулгах вирусны эсрэг програм хангамжийг 2018 оны 05-р сарын 16-ны ОРГИЛ ДЕЛЬТА ТРЕЙД ХХК-тай байгуулсан гэрээний дагуу нийт 160 хэрэглэгчийн эрх бүхий програмийг бүрэн суулгаж хяналт тавин ажиллаж байна.

Khanuul.mn домэйн нэр болон цахим шуудангийн 160 хэрэглэгчийн үйлчилгээ үзүүлэх гэрээг “Мэйжик нэт” ХХК-тай үргэлжлүүлэн сунгаж хамтран ажиллаж байна.

2018 оны 1 дүгээр сарын 09-нд Хан-уул дүүргийн 16 хорооны байрны аюулгүй байдлыг хамгаалах, нэгдсэн систем бий болгох гадна хяналтын камер, дагалдах тоног төхөөрөмж суурилуулах ажлын 16 ширхэг хяналтын камер, нэгдсэн сервер, өргөн 32” дэлгэц суурилуулан, камеруудын бичлэг хийх бүхий тохиргоог хийж хэвийн ажиллагаанд оруулан засвар үйлчилгээг хариуцан ажиллаж байна.

2018 оны Хан-Уул дүүргийн ээлжит хавар, намрын 2 удаагийн цэрэг татлагын товчооны гишүүнээр ажиллаж, цэрэг татлагын байрны хяналтын камерын системийг шинээр солин хэвийн ажиллагаанд оруулж хяналт тавин ажлласан.

Хан-Уул дүүргийн 14-р хорооны 12 корын шилэн кабель тасарч гэмтлийг “МТМК” ХХК тай засвар үйлчилгээний 1/21 дугаартай ажил гүйцэтгэх гэрээг 4 дүгээр сарын 03 –ны өдөр байгуулан засварлаж, тохиргоог хийн ашиглалтад оруулсан.

Хан-Уул дүүргийн 12-р хорооны нутаг дэвсгэрт хөрсний нуралт болсны улмаас 12,14 дүгээр хороодыг холбосон шилэн кабель дахин тасарсан тул гэмтлийг "Женерэйшн" линк ХХК тай 11 дүгээр сарын 05-ны өдөр гэрээ байгуулан хамтран ажиллаж хэвийн ажиллагаанд оруулсан.

Нийслэлийн Засаг Даргын 2018 оны А/668 дугаар захирамжын дагуу Улс, Нийслэлийн төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр суурилуулсан хяналтын камеруудын дэлгэрэнгүй судалгааг маягтын дагуу 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр нийслэлийн мэдээлэл технологийн газарт илгээсэн.

Хууль эрх зүйн чиглэлээр:

Захирамж, тушаалын эрх зүйн үндэслэлийг хянах, бүртгэлжүүлэх чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд гаргасан Засаг даргын **402** захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын **555** тушаалын төслийг хянаж бүртгэлжүүлэн, шинээр 4 журам, 2 хөтөлбөрийг хянаж, хууль эрх зүйн зөвлөмж, зааварчилгаа өгсөн.

Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн WWW.UBLEGAL.MN мэдээллийн санд дүүргийн Засаг даргын 2017 оны **300** захирамжийн нөхөн бүрдүүлэлтийг хийж, 2018 онд батлагдан гарсан **238** нийт **538** захирамж тус тус байршуулсан.

Гэрээний эрх зүйн үндэслэлийг хянах, бүртгэлжүүлэх чиглэлээр:

Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, тасгаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан **347** гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, бүртгэлжүүлсэн байна.

№	Гэрээний индекс	Хэлтэс, тасгийн нэр	Гэрээ
1	1/01	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	57
2	2/01	Санхүү, төрийн сангийн хэлтэс	21
3	3/01	Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс	5
4	4/01	Нийгмийн, бодлогын хэлтэс	71

5	5/01	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	55
6	6/01	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	9
7	Ц/01	Цэргийн штаб	28
8	х/01	Хууль зүй, архивын тасаг	-
9	а/01	Аж ахуйн тасаг	59
10	Хо-17/01	Дүүргийн хөрөнгө оруулалт	42
		НИЙТ	347

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагын захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан **28** хамтын гэрээг хянан бүртгэлжүүлсэн.

Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр:

Эрх зүйн сургалтыг 12 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 524 албан хаагчдыг хамруулж, 2.700 ширхэг гарын авлага тараан, 1.783.100 төгрөгийн төсөв зарцуулан ажилласан.

Хууль эрх зүйн сургалт сурталчилгааны хүрээнд Засаг даргын Тамгын газрын даргаар эрх зүйн сургалт сурталчилгааны төлөвлөгөө батлуулан сургалтыг зохион байгуулж ажилласан. 2017 онд эрх зүйн сургалтыг хороод болон Тамгын газрын албан хаагчид, сургууль цэцэрлэгийн багш ажилчид, сурагч, хувийн аж ахуйн нэгж байгууллагуудын ажилчдын дунд түлхүү зохион байгуулсан бол 2018 онд Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын албан хаагчид, мөн зорилтот бүлгийн иргэдийг хамруулан шинээр гарсан хуулиудыг сурталчлах, таниулах сургалтыг зохион байгуулж ажиллалаа.

Захиргааны ерөнхий хуулийн сургалт: 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн албан хаагчдад 3 цагийн сургалт зохион байгуулсан. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн багш А.Түвшинтулга Захиргааны Ерөнхий хуулийн бүтэц, зарчим, хамрах хүрээ, онцлогийн талаар сургалтыг удирдан хүргэлээ. Сургалтад 40 гаруй албан хаагч оролцсон.

Зөрчлийн тухай хуулийн сургалт: 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Шүүхийн судалгаа мэдээлэл сургалтын хүрээлэнгийн судлаач багш, хууль ч Л.Галбаатар Зөрчлийн тухай хуулийн бүтэц, зарчим, хамрах хүрээ, зөрчлийн төрөл, шийтгэл, хянан шалгах харьяалал, зөрчил шалгах хугацаа зэрэг сэдвүүдийн хүрээнд сургалтыг удирдан хүргэлээ. Сургалтад 62 албан хаагч оролцсон.

2018 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Цагдаагийн 1 дүгээр хэлтэстэй хамтран Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад Зөрчлийн тухай хуулийн сургалт зохион байгуулж 41 албан хаагч сургалтад хамрагдсан.

Дүүргийн Прокурорын газартай хамтарч дүүргийн нутаг дэвсгэрт гарч байгаа зөрчил болон эрүүгийн хэргийн нөхцөл байдал, Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх танилцуулга, зөвлөлдөх уулзалтыг 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж Цагдаагийн 1,2 дугаар хэлтэс, Замын Цагдаагийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Хороодын Засаг дарга нийт 41 албан хаагч оролцсон.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай, батлан хамгаалах багц хуулиудын шинэчлэл өөрчлөлтийн талаар сургалт:

Сургалтыг Гал түймэр унтраах, аврах 14, 30, 65 дугаар ангиудын алба хаагчдад 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан.

Сургалтыг Батлан хамгаалах яамны Стратеги төлөвлөлтийн газрын Хууль зүйн хэлтсийн дарга, хурандаа Г.Энхболд, ХУД-ийн ЗДТГ-ын Цэргийн штабын төлөвлөлт, сургалтын офицер, дэд хурандаа Г.Жаргалсайхан удирдан хүргэсэн. Хурандаа Г.Энхболд нь тухайн хуулиудыг шинэчлэн боловсруулах ажлын гишүүнээр ажиллаж байсан тул хуулиудын үзэл баримтлал, хэрэглээг нэг мөр ойлгох асуудлыг дэлгэрэнгүйгээр тайлбарлан, алба хаагчдын сонирхсон асуултад хариулж хүртээмжтэй сургалт болсон. Нийт **96** алба хаагч хамрагдсан.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга: Тус хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон Хороодын Засаг дарга, зохион байгуулагч, нийгмийн ажилтан, хороо тус бүрээс 2, нийт **91** хүн оролцлоо. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга А.Даваажаргал шинэчилсэн найруулгын төслийн бүтэц, төсөлд орсон онцлог заалтууд болон хуулийн 14 бүлэгт орсон зүйл заалтыг тайлбарлан танилцуулсан. Төсөлд өгсөн санал, хүсэлтийг 2018.04.19-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.

Иргэний хуулийн "Өв нээх" сургалт: 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Хан-Уул дүүргийн тойргийн нотариат С.Наранцэцэгтэй хамтран өв нээх, өвлөх эрх үүсэх тодорхойлолт гаргахад анхаарах асуудал сэдвээр хороодын Засаг дарга нарт давтан сургалтыг зохион байгуулсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх "Ёс зүйн сургалт": Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.5-д заасны дагуу шүүхээс үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийг **дахин гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс урьдчилан сэргийлэх хүрээнд ёс зүй, харилцаа хандлагын** мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн "Хувь хүний ёс зүй, харилцаа хандлага" сэдэвт сургалтыг 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор Н.Цолмонтуяа удирдан зохион байгуулсан. Харилцаа хандлагын чиглэлээр лекц уншиж, сургалтад Шүүхээс үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан Хан-Уул дүүргийн иргэний харьяалалтай 54 гаруй этгээд хамрагдсан.

Захиргааны үйл ажиллагааны зарчим, захиргааны байгууллага, захиргааны акт, захиргааны гэрээ, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны төлөвлөлт, захиргааны шийдвэр гүйцэтгэл сэдэвт сургалт:

Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах, албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор Захиргааны ерөнхий хуулиар хэлтэс алба болон хороодын Засаг дарга нарт 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдөр сургалт зохион байгуулсан.

Эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх чиглэлээр: Зөвлөгөө өгөх ажлын хүрээнд нийт 3 удаа үйл ажиллагаа зохион байгуулан ажлын байранд давхардсан тоогоор 864 иргэнд зөвлөгөө өгч, 4600 гаруй ширхэг гарын авлага тараан, 131.400 төгрөгийн төсөв зарцуулан ажилласан.

Эрх зүйн зөвлөгөөг 2 төрлөөр иргэдэд хүргэж ажилласан. Үүнд:

1 Ажлын байранд 125 албан хаагч, 641 иргэнд эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч, 25 төрлийн эрх зүйн гарын авлагыг **4600** гаруй ширхгийг тараан ажилласан.

2 Монголын өмгөөлөгчдийн холбоотой хамтран хуулийн зөвлөгөө өгөх өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж нийт **98** иргэнд зөвлөгөө өгч ажилласан. Өдөрлөгөөр 1 иргэнд 15-40 минутын хугацаа зарцуулан зөвлөгөө өгсөн.

"Өмгөөлөгч танд тусалъя" өдөрлөгийг 2018.05.23-ны өдөр Жижиг дүнд үйлдвэрлэлийг дэмжих төвийн сургалтын танхимд зохион байгуулж 60 гаруй иргэн хамрагдсан. Иргэд гэр бүл, хөдөлмөрийн харилцаа, тэтгэвэр тэтгэмжийн асуудлаар ихэвчлэн зөвлөгөө мэдээлэл авсан байна. Д.Батжаргал, Б.Нямхай, Л.Ононбаяр, Б.Гантөмөр өмгөөлөгч ажилласан.

Хууль зүйн туслалцааны төвийн Хан-Уул дүүрэг дэх салбар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтэс хамтран 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны иргэдэд эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан бөгөөд тус өдөрлөгт 200 гаруй иргэд оролцож шинээр батлагдан гарсан хуулиудыг сурталчлах, таниулах мөн гэр бүлийн хүчирхийлэл, газрын тухай хууль, иргэний бүртгэл, татвар, нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмжийн нөхөн олговор зэрэг өөрт хэрэгтэй олон чиглэлээр зөвлөгөө авсан.

Хууль, хяналтын байгууллагатай харилцах чиглэлээр:

Нийслэл дэх Захиргааны болон Иргэний хэргийн шүүхэд иргэн, аж ахуй нэгж, байгууллагын нэхэмжлэлээр Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын даргад холбогдуулан үүсгэсэн 29 хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон холбогдох материалуудыг судалж тайлбар, нотлох баримт гаргаж өгөх, газрын 32 үзлэг хийхэд байлцан, шат шатны 76 шүүх хуралдаанд оролцон ажилласан.

Дээрх хэрэг маргаанаас иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн захиргааны актын холбогдох хэсгийг хүчингүй болгосон 2, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 1 хэрэг, 1 захиргааны актыг түдгэлзүүлж шийдвэрлэсэн байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүхээс 1 хуулийн этгээд, 1 иргэнийг эрэн сурвалжлах захирамж гаргуулан Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.

Нийт хэрэг, маргааны тоо	**29**
Он дамжсан	10
Тайлант онд гардсан нэхэмжлэл	15
Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон тоо	4
Нийт оролцсон шүүх хуралдаан	76
Анхан шатны	55
Давж заалдах шатны	15
Хяналтын шат	6
Шүүхийн үзлэг/ Газар, баримт/	32

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүй, архивын тасаг, дүүргийн Прокурорын газар, Нийслэлийн Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх газар хамтран шүүхийн шийдвэрээр үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд хяналт тавихад сэдвээр зөвлөлдөх уулзалтыг 2018 оны 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Уулзалтад Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүй, архивын тасаг, дүүргийн Прокурорын газар, Нийслэлийн Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн

Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

Засаг даргын Тамгын газарт цаасан болон цахим хэлбэрээр ирсэн нийт **4060** бичгийг байгууллага дээр хүлээн авч холбогдох удирдлага болон хэлтсүүдэд тухай бүрт бүртгэж шилжүүлсэн бөгөөд байгууллагаас боловсруулсан нийт **2799** албан бичгийг бүртгэж цаасан болон цахим хэлбэрээр илгээсэн.

Хүснэгтээр харуулбал:

Д/д	Хэлтсийн нэр	Нийтирсэнбичиг	Үүнээсхариутайбичиг	Хариутайбичгийн хаалт, %	Үүнээсхариугүйбичиг	Хариугүйбичгийн хаалт, %	Хугацаахэтэрсэнбичиг	Зөрчил /Т хоног/	Нийтирсэнбичгийн шийдвэрлэлт, %	Явуулсанбичиг
1	Удирдлага	46	5	56,25	41	76,92	4		52,69	38
2	01. ТЗУХ	887	112	84,82	775	94,78	1		86,81	345
3	02. СТСХ	413	90	94,38	323	98,41	0		95,19	241
4	03. ЭЗТХ	407	46	94,44	361	97,62	0		95,08	249
5	04. НБХ	467	44	95,45	423	98,67	0		96,09	308
6	05. ТНААХ	598	77	95,14	521	97,75	0		95,66	463
7	06. ХХҮХ	381	51	96,08	330	98,77	1		96,62	294
8	07.Цэргийн штаб	31	2	100	29	98,28	0		99,66	14
9	08. ХЗАТ	756	123	87,19	633	98,89	0		89,53	537
10	09.Аж ахуйнтасаг	74	10	94,44	64	94,35	0		94,42	310
Нийт		**4060**	**560**	**86,77**	**3500**	**86,77**	**6**		**86,77**	**2799**
11	ДИТХ	454	177	86,99	277	95,17	4		88,63	270
12	Хороод	4910	1270	92,66	3640	98,30	15		93,79	3071
13	Дэргэдэххэлтэс, албад	14368	5110	90,67	9258	95,88	58		91,71	10168
14	Сургууль	2195	495	92,17	1700	96,07	35		92,95	1825

15	Цэцэрлэг	2018	405	90,22	1613	96,94	6		91,56	1175
Нийт		23945	7457		16488		118			16509
Дүүргийнхэмжээ ннднийт		28,005	8,017		19,988		124			19308

Жилийн эцсийн байдлаар ирсэн бичгийн шийдвэрлэлтийн нийт 65 удаагийн мэдээг Засаг даргын Тамгын газар болон дүүргийн EDOC програм ашиглагч 92 байгууллагыг хамруулан 7 хоног, сар, улирал, хагас жилээр гаргаж Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөн, Хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөн, Нийслэлийн Архивын Газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус танилцуулсан.

Дээрх ажлын хүрээнд 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Хороодын Засаг дарга, зохион байгуулагчид, тус дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын захирал, бичиг хэргийн ажилтан, Цэцэрлэгүүдийн эрхлэгч, бичиг хэргийн ажилтнуудад "EDOC-ийн хэрэглээ, албан бичиг боловсруулах стандарт" сэдвээр, Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагч, нэгжийн удирдлагуудыг хамруулан 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдөр "EDOC систем дэх зөрчлийн төрлүүд" сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан.

Нийслэлийн Архивын Газрын даргын 2018 оны А/05 дугаар тушаал "Ирсэн бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих эрх"-аар Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт албан ёсоор шилжүүлсэнтэй холбогдуулан дүүргийн хэмжээнд EDOC програм ашиглагч 92 байгууллагад ирсэн бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж ажилласан бөгөөд энэ ажлын хүрээнд нийт 25105 бичгийн шийдвэрлэлтэд хяналт хийж үүнээс 24119 бичгийн шийдвэрлэлтийг хангалттай гэж үзэн баталгаажуулан, 986 бичгийн шийдвэрлэлтийг хангалттүй гэж үзэн хаалтыг цуцалсан.

Ирсэн бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт хийсэн ажлын мэдээ



2018 оны байдлаар нийт **8758**ширхэг хэвлэмэл хуудас зарцуулагдаж, үүнээс 8097 ширхэг ашиглагдсан. Үүнд захирамжлалын баримт бичиг Засаг даргын захирамж 1293, Тамгын газрын даргын тушаал1743, зохион байгуулалт, мэдээлэл, лавлагааны баримт бичиг Засаг даргын**1296**, Тамгын даргын **4348** баримт бичгийн төслийг хүлээн авч **405** ширхэг

хэвлэмэл хуудсан дээр хэвлэж, Монгол улсын MNS 5140:2011 стандартыг бүрэн мөрдөж, хяналт тавьж ажиллаж байна.

Зарцуулалтын тайлан хүснэгтээр:

№	Хэлтэс, албад	Нийтхэвлэмэл хуудас	Алдаатай хэвлэмэл хуудас
1	Засаг даргын захирамж	0001-1131/1131	162
2	Засаг даргын албан даалгавар	0001-0010/10	2
3	Засаг даргын А4	0001-381/381	35
4	Засаг даргын А5	0001-799/799	81
5	Засаг даргын гадаад	0001-0027/27	1
6	Тамгын газрын даргын тушаал	0001-1664/1664	79
7	Тамгын газар А4	0001-778/778	56
8	Тамгын газар А5	0001-3272/3272	242
9	Тамгын газар гадаад	0001-0035/35	3
	НИЙТ	**8097**	**661**

2018 оны байдлаар хэвлэмэл хуудасны захиалга Захирамж 1000, тушаал 2000, Тамгын газрын А53000 ширхгийг хэвлэмэл хуудсыг тус тус Архивын ерөнхий газрын хяналтын Улсын байцаагчийн хяналтаар баталгаажуулан захиалга хийж хэвлүүлсэн. 2017 онд үргүй зарцуулсан 590 ширхэг хэвлэмэл хуудсыг төрөл тус бүрээр ангилан акт үйлдэн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/65 дугаар тушаалаар хүчингүй болгож, устгах ажлыг зохион байгуулан, Архивын ерөнхий газрын даргын 2016 оны А/142 дугаар тушаалын дагуу хэвлэмэл хуудсанд өдөр бүр хяналт тавьж, бүртгэлжүүлэн ажилласан.

Архив: Дүүргүүдийн архивын тасгийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 2018 онд Сонгинохайрхан дүүрэгт 03 дугаар сард, Баянзүрх дүүрэгт 04 дүгээр сард тус тус зохион байгуулагдсан бөгөөд 2018 оны 05 дугаар сарын 03ны өдрийн 09:00 цагт Хан-Уул дүүргийн 7 давхрын хурлын танхимд Нийслэлийн Архивын газар, 9 дүүргийн Архивын тасгийн удирдлагууд болон мэргэжилтнүүдийн хамтарсан шуурхай хурлыг зохион байгуулсан.

Хуралд Нийслэлийн Архивын газрын дарга С.Гаваа, Нийслэлийн Архивын газрын Мэргэжлийн удирдлагын хэлтсийн дарга Н.Оргилболд нар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цаашдаа анхаарах асуудлыг ярилцав. Нийт 14 албан хаагч хамрагдаж санал бодлоо солилцсон. Хурлын тэмдэглэлийг 05 дугаар сарын 08-нд Нийслэлийн Архивын газар албан бичгээр хүргүүлэн ажилласан.

2018 оны 03 дугаар сарын 19-ны өдөр Засаг даргын дэргэдэх 99 байгууллагад шинэчлэгдсэн програм хангамж суулгах заавар, захирамжлалын баримт бичиг хэрхэн үйлдэх талаар мэдээллийг 08/489 тоот албан бичгээр хүргүүлэн 05 дугаар сарын 25-ны байдлаар 99 байгууллагаас 87 байгууллагын актыг хүлээн авч бүрэн хангалттай үнэлгээ авсан 17 байгууллагад батламж олгуулахаар Нийслэлийн архивын газрын Мэдээлэл технологийн хэлтэст хүргүүлсэн.



	Хороо	Цэцэрлэг	Сургууль	Дэргэдэх байгууллага	Хороо
Нийт	16	29	18	20	16
Өгсөн	13	25	15	17	16
Буцаагдсан	3	4	3	3	0

Тамгын газрын хэлтэс, албадын 2017 оны нөхөн бүрдүүлэлт: Засаг даргын Тамгын газрын 6 хэлтэс, 1 тасгийн 2017 оны 540 баримтыг хүлээн авсан.

№	Хэлтэс, тасаг	Байнга	түр	70 жил
1	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс	91	180	10
2	Санхүү, төрийн сангийн хэлтэс	14	94	
3	Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс	61	1	
4	Хууль зүй, архивын тасаг	3	7	
5	Нийгмийн бодлогын хэлтэс	13	18	
6	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	3	29	
7	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	6	10	
Нийт -540		191	339	10

Дүүргийн архивын нөхөн бүрдүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх хүрээнд Засаг даргын Тамгын газрын даргаар “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын удирдамж”-ийг батлуулан ЕБ-ын 18 сургууль, 29 цэцэрлэгийн сан хөмрөгтэй танилцан архивын баримтад хяналт шалгалт хийж зөвлөн туслах ажил хийгдсэн бөгөөд шалгалт явуулсан тухай илтгэх хуудсыг байгууллага тус бүрт 2018 оны 08/2271 тоот албан бичгээр хүргүүлсэн.

ЗДТГ-ын даргаар Архивын нөхөн бүрдүүлэлтийн хуваарийг батлуулж 2018 оны 09 дүгээр сарын 24-ны 08/1825 тоот албан бичгээр 30 байгууллагад хүргүүлсэн. Тус байгууллагуудын архивын хадгаламжийн нэгжийг ач холбогдлын дараалал, баримт бичгийн стандартын дагуу нэгбүрчлэн шалгаж, арга зүйн заавар зөвлөгөө өгч эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлыг хийсний үр дүнд төлөвлөгөөт байгууллагуудын нөхөн бүрдүүлэлт 70 хувьтай байгаа бөгөөд 2019 оны 1 дүгээр улиралд багтаан дуусгахаар төлөвлөсөн.

Мөн татан буугдсан байгууллагуудын баримтыг нөхөн бүрдүүлэлтээр татан авах ажлыг эрчимжүүлэх хүрээнд 15 дугаар цэцэрлэгийн 1987-1997 оны 85 хадгаламжийн нэгж, 137 дугаар цэцэрлэгийн 1991-2014 оны 185 хадгаламжийн нэгжийг олж илрүүлэн Нийслэлийн Архивын газар акт үйлдэн хүлээлгэн өгсөн.

Баримт бичиг нягтлан шалгах комисс: Дүүргийн Засаг даргын 2018 оны А/53 дугаар захирамжаар дүүргийн дэргэдэх ББНШК-ыг шинэчлэн батлан 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. 2018 онд 4 удаа хуралдаж 26 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Архивын сургалт, арга зүй: Архивын арга зүйн сургалтыг 3 удаа зохион байгуулж, 87 албан хаагчдыг хамруулж ажилласан.16 хороо, 18 сургууль, 29 цэцэрлэгийн архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдөр "Нөхөн бүрдүүлэлт хийхэд анхаарах асуудал" сэдэвт сургалтыг архивын арга зүйч Т.Райса зохион байгуулсан.

Дүүргийн архивын сангаас хуулбар олгосон баримт:

- 2018 оны жилийн эцсийн байдлаар Тамгын газрын архивын сан хөмрөгөөс 170 удаа лавлагаа хуулбар олгож, 312 хадгаламжийн нэгж түр ашиглуулсан нийт 167 иргэнд үйлчилсэн байна.
- Байгууллагын архивын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой тоон мэдээ, тайлан биелэлтийг 7 хоног сар улирлаар гарган Тамгын газар болон Нийслэлийн Архивын газарт тайлагнан ажиллалаа.
- Архивын албан хэрэгцээнд ашиглагдах хадгаламжийн нүүрний дардас, хуулбар үнэн, тоолов тэмдэг зэргийн заавар журмын дагуу хадгалан хяналт тавьж бүртгэлжүүлж ажилласан.



Гүйцэтгэлийн хяналт шалгалт: Нийслэлийн Архивын газраас "Гүйцэтгэлийн хяналт шалгалт" хийх зөвлөмжийн дагуу 2018 оны 04 дүгээр сарын 10, 12, 13-ны өдрүүдэд дүүргийн дэргэдэх 6 байгууллагад Нийслэлийн Архивын газартай хамтран хяналт шалгалт хийсэн.

	Хороо	Цэцэрлэг	Сургууль	Дэргэдэх байгууллага	Иргэдийн нийтийн хурал
Нийт	16	29	18	20	16
Өгсөн	13	25	15	17	16
Буцаагдсан	3	4	3	3	0

Мөн эх үүсвэрийн жагсаалтад орсон дүүргийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх 6 сургуулийн **1413** цаасан суурьт баримтыг шалгаж стандартад нийцүүлэх талаар албан хаагчдад арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Мал тооллогын А данс: 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн Нийслэлийн Архивын газраас ирүүлсэн 02/102 дугаар албан бичгийн дагуу мал тооллогын данс бүртгэлийг дүүргийн архивт хүлээн авах ажлын хэсгийг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/55 дугаар тушаалаар батлуулсан.

Дээрх ажлын хүрээнд 2018 оны 03 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд 12 хорооноос нөхөн бүрдүүлэлтээр дүүргийн архивт 23021 хуудас бүхий 151 хадгаламжийн нэгжийг хүлээн авч, иргэдээс ирсэн өргөдөл, мөн малчдын тэтгэвэртэй холбоотой А дансны лавлагааг, тодорхойлолтыг хуулбар үнэн дардсаар баталгаажуулж өгч байна. Одоогийн байдлаар тодорхойлолт 15 иргэнд өгсөн байна.

Өмч хөрөнгийн бүртгэл ашиглалт хамгаалалтын талаар: Нийт 15 албан бичгийг Нийслэлийн өмчийн харилцааны газар, Газрын алба, АЕГ, Цагдаагийн 1 дүгээр хэлтэс рүү тус тус боловсруулан явуулсан. Хөрөнгө бүртгэх, хөрөнгө гаргах, ажлын хэсэг байгуулах 12 тушаал гаргасан байна. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас ирсэн албан бичгийн дагуу тус дүүргийн 1,2,3,5,9,11,13,14,15,16-р хороодын нутаг дэвсгэрт хийгдсэн Нийтийн эзэмшлийн хөрөнгө бүртгэх 12 тушаал боловсруулан батлуулж төгрөгний хөрөнгийг бүртгэн авсан.



Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ болон Хан-Уул Агро ОНӨААТҮГ-тай хог тээврийн авто машины ашиглалтын гэрээ, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Ахмадын хороо,

Худалдан авах ажиллагааны албатай интернет ашиглалтын гэрээ мөн 6-р хороо болон 16 дугаар хороонд байрлах нийтийн халуун усны байр ашиглалтын гэрээг тус тус байгуулсан.

15-н хороодын байр болон Иргэдэд үйлчлэх төв байрны газар эзэмших гэрчилгээнд бүртгэлийн хэлтсээс "Г" дугаар авч баталгаажуулсан.

Иргэдэд үйлчлэх төв байр болон 16 хорооны байр, халуун усны 2 барилгын албан ёсны хаягийг Нийслэлийн хот төлөвлөлтийн газраас албан ёсоор авч хаягжуулсан. Өмч хамгаалах байгууллагын зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, Өмч хамгаалах байгууллагын зөвлөлөөс нийт 9 удаагийн хуралыг зохион байгуулан ажилласан .

Тамгын газрын хагас жил болон жил эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулж өмч бүртгэлийн шинэ программыг нэвтрүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх болон нийтийн эзэмшлийн хөрөнгийн дахин үнэлгээний тооллого зохион байгуулсан.

Засаг даргын Тамгын газрын техник хяналтын комиссын гишүүнээр дүүргийн төсвийн хөрөнгө болон орон нутгийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудад хяналтаар явсан.
Засаг даргын Тамгын газрын баяр наадмын үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан.
Тамгын газрын балансанд бүртгэлтэй барилга байгууламж, авто машин болон худгийн барилгуудыг зурагжуулж, хаягжуулсан мөн зургийн цомог бий болгосон.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Дүүргийн Төсвийн орлогын талаар: **2018 оны** орон нутгийн төсвийн **төлөвлөгөөгөөр 25 тэрбум 725 сая 520,6 мянган төгрөгийн** орлого төвлөрүүлэхээс **35 тэрбум 584 сая 113,8 мянган төгрөг** орж, **138,3** хувиар биелэгдэж байна.

Хүснэгтээр харуулбал /сая.төг/

Төсвийн төрөл	Төлөвлөгөө /өссөн/	Гүйцэтгэл /өссөн/	Хувь
Үйл ажиллагааны орлогын албан татвар	2,369,027.0	6 588,073.2	278.1%
Үл хөдлөх хөрөнгийн эрх борлуулсны орлогын албан татвар	2,581,200.0	3,840,649.8	148.8%
Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар	4,468,078.3	6,836,835.1	153.0%
Хадгаламжийн хүүгийн орлогын албан татвар	7,000,000.0	9,057,712.8	129.4%
Галт зэвсгийн албан татвар	70,800.0	78,370.0	110.7%
Улсын тэмдэгтийн хураамж	5,500,000.0	5,059,658.1	92.0%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	78,000.0	31,025.8	39.8%
Ус, рашаан ашигласны төлбөр		1,982.6	
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,757,217.5	1,523,032.4	86.7%
Хүү, торгуулийн орлого	1,621,918.1	2,257,895.3	139.2%
Төсвийн байгууллагын өөрийн орлого	199,280.0	206,933.4	103.8%
Бусад ангилагдаагүй орлого	80,000.0	101,945.1	127.4%
Нийт дүн	**25,725,520.9**	**35,584,113.8**	**138.3%**

Нийслэлийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний дагуу нийслэлд нийт ***7 тэрбум 990.8 сая төгрөгийг хугацаанд нь*** бүрэн төвлөрүүллээ.

Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу 2019 оны төсвийн төслийг олон нийтэд танилцуулах Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан батлуулж, хэлэлцүүлгийг 2018 оны 12 сарын 07-ны өдөр зохион байгуулсан.

Дүүргийн орон нутгийн төсвийн 2019 оны төслийг холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн 2019 оны батлагдсан төсвийн үзүүлэлттэй нийцүүлэн боловсруулж, Засаг даргын зөвлөл, МАН, АН-ын бүлэг, Төсвийн хорооны хурлаар хэлэлцүүлэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд 2018 оны 12 сарын 10-ны өдрийн 02/559 тоотоор өргөн барьж, 12 сарын 14-ний өдрийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VI хуралдаанаар батлуулсан.

Орон нутгийн байгууллагуудын зарлага, санхүүжилт:

Дүүргийн төсвөөс санхүүждэг байгууллагуудын төсвийн жилийн болон сар, улирлын хуваарийг төлөвлөлтийн "Фискал" программд шивж оруулан баазыг Сангийн яаманд электрон шуудангаар хүргүүлж, Засгийн газрын Санхүүгийн удирдлагын мэдээллийн системд татуулан төрийн сангийн гүйлгээ хийх нөхцлийг бүрдүүлэн ажилласан.

Орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилтийг хүснэгтээр харуулбал:
/мян.төг/

№	Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл /12 сарын 27/
1	ИТХ	2,480,149.40	2,480,149.40
2	ЗДТГ	6,594,761.90	6,594,761.90
3	Туул тосгоны ажлын алба	338,741.90	338,741.90
4	ХАААлба	166,924.80	166,924.80
5	Дотоод аудитын алба	119,387.90	119,387.90
6	ЖДҮДТөв	195,416.40	195,416.40
7	ГБХЗХТөв	305,404.50	305,404.50
8	УССТөв	365,874.70	365,874.70
9	Аж ахуйн тооцоот байгууллагууд	7,845,990.30	7,845,990.30
10	Төсвийн хөрөнгө оруулалт	1,922,000.30	1,922,000.30
11	Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг	7,990,868.80	7,990,868.80
12	Орон нутгийн хөгжлийн сан	369,748.80	369,748.80
	Нийт санхүүжилт	**28,695,269.7**	**28,695,269.7**

Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын батлагдсан төсвийн жил, сарын хуваарийн дагуу 2018 онд орон нутгийн 23 нэгжид 19 тэрбум 155 сая 929,2 мянган төгрөг, Тусгай шилжүүлгийн 163 байгууллагад 41тэрбум 343 сая 620,9 мянган төгрөг, ХХҮХэлтэст 12 тэрбум 421 сая 391,4 мянган төгрөг, нийт 72 тэрбум 920 сая 941,5 мянган төгрөгийн санхүүжилт олгож ажиллалаа.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага, санхүүжилт

Нийслэлийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний дагуу улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг Ерөнхий боловсролын сургууль 32, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд 108, Соёлын ордон 1, Биеийн тамир, спорт хороо 1, Өрхийн эмнэлгүүд 15, Туул тосгоны хүн эмнэлэг 1 нийт 158 байгууллагын төсвийн сар, улирлын төсвийн хуваарийг зардал тус бүрээр хуваарилан хянуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулан харьяалах байгууллагуудад хүргүүллээ.

ТУСГАЙ ШИЛЖҮҮЛГИЙН БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮЖИЛТ

/мянган төгрөг/

№	Тусгай сангийн шилжүүлэг	Батлагдсан төлөвлөгөө	Жилийн гүйцэтгэл /Өссөн дүнгээр/
1	Сургууль	20,850,608.1	20,850,608.1
2	Цэцэрлэг	17,538,354.4	17,538,354.4
3	Өрхийн эмнэлэг	2,565,215.2	2,565,215.2
4	Биеийн тамир спорт хороо	190,207.1	190,207.1
5	Соёлын ордон	199,236.1	199,236.1
	Нийт санхүүжилт	**41,343,620.9**	**41,343,620.9**

Нийслэлийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд Төсвийн тухай хуулийн 61.1-д заасан:

- Сургуулийн өмнөх боловсрол,
- Ерөнхий боловсрол,
- Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ,
- Нийтийн биеийн тамир,
- Соёлын үйлчилгээ гэсэн 5 чиг үүргийг дүүргийн нутаг дэвсгэрт төлөөлөн хэрэгжүүлэхээр үүрэг хүлээн ажиллаж байна.

✓ Төсвийн тухай хуулийн 39.4-т заасныг баримтлан:

- Тусгай зориулалтын санхүүжилтээс орон нутгийн төсөвт болон бусад санхүүжилтэнд шилжүүлэн зарцуулаагүй, зориулалтын дагуу зарцуулсан.

Эдгээр салбаруудын үйлчилгээний стандарт, тоо хэмжээ, чанар хүртээмжийг бууруулахгүй байхаар төсвийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

✓ Төсвийн тухай хуулийн 42.2-т заасны дагуу төсвийн шууд захирагчдын төсөв хооронд зохицуулалт хийн дутагдалтай байгаа төсвийн зардал хооронд зохицуулах замаар төсвийн байгууллагад өр авлага үүсгэхгүй байхаар төлөвлөсөн. Төсөвт байгууллагуудын анхан шатны бариментанд хяналт тавьж, 64 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийт 916,6 сая төгрөгөөс 916,6 сая төгрөгийн хүсэлтийн эрхийг 328 журнал бичилтээр Сангийн яаманд илгээн, нэгдсэн зарцуулалт эрхийн хүрээнд өр төлбөр үүсгэхгүй байхад анхааран ажилласан.

✓ Сангийн сайдын 73 дугаар тушаал болон 2018 оны 134 дугаар тушаалаар "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Төрийн сангийн үйлчилгээний талаар: "Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээлэл" системийн сүлжээ буюу "Фрийбаланс" программын зардлын ваучерт 12 сарын 25-ны өдрийн байдлаар **нийт 26009 ширхэг 128 тэрбум 162 сая 7,0 мянган** төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн хяналтын хуудастай тулган шивж, гүйлгээнд хяналт тавьж, баталгаажуулан, нийгмийн даатгалын болон халамжийн сангууд, хөнгөлөлт, чөлөөлөлт, нөхөн олговор, ажилгүйдэл, хүүхдийн мөнгөн сангууд, төсөвт байгууллагуудын гүйлгээг анхан шатны баримттай тулган төлбөр тооцоог шуурхай, чирэгдэлгүй гүйцэтгэлээ.

Төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбогдуулан "Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээлэл"-ийн системд бүртгэлгүй байсан 137 аж ахуй нэгж, байгууллагыг шинээр бэлтгэн нийлүүлэгчээр нэмж бүртгэсэн.

✓ Улсын төсвийн 12, тусгай зориулалтын шилжүүлгийн 165, орон нутгийн төсвийн 12 байгууллагын нийт **189** данснаас 21 хөтөлбөрийн санхүүжилтийг хөтөлбөрийн төсөв, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн болон Засаг даргын баталсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан гүйцэтгэсэн.

✓ Дүүргийн төрийн сан нь Засгийн газрын зарим чиг үүргийг хэрэгжүүлэгч орон нутгийн байгууллага тус бүрийн санхүүжилтийг төсвийн дансанд ажлын гурав хоногт багтаан шилжүүлэн ажиллалаа.

✓ Дүүргийн төрийн сан банктай харилцагч төсөвт байгууллагуудын 185 дансны баталгаат гарын үсгийг 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн Засгийн газрын 24 дугаар тогтоолоор батлагдсан маягтын дагуу шинэчлэн авсан. Мөн 1, 2 дугаар гарын үсгийн хэв маяганд өөрчлөлт орсон 27 байгууллагын 97 дансны гарын үсгийн баталгааг тухай бүрд нь шинэчлэн авч баталгаажуулан ажилласан. Мөн сургуулийн өмнөх боловсролын 4 цэцэрлэгт нэмэлт санхүүжилтийн данс нээлгэсэн.

✓ Төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбогдуулан "Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээлэл"-ийн системд 1361 данс болон бүртгэлгүй байсан аж ахуй нэгж байгууллага, иргэнийг шинээр бэлтгэн нийлүүлэгчээр нэмж бүртгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээний талаар:

Төсвийн байгууллагуудын тайлан хүлээн авалт: 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд дүүргийн төрийн сан, орон нутгийн төсвийн 8 байгууллага, 1 сан, ОНХО, ОНХС, ХО барьцаа, 4 ОНӨААТҮГазар, тусгай зориулалтын шилжүүлгийн 20 сургууль, 29 цэцэрлэг, БТСХороо, Соёлын ордон, Туул тосгоны НЭ, 15 ӨЭМТөв, Хувийн хэвшлийн 13 ЕБСургууль, 82 СӨБ нийт 178 байгууллага нэгтгэгдэж "Дүүргийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх НЭГТГЭСЭН санхүүгийн байдал,

санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний болон төсвийн гүйцэтгэлийн тайлан нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын батлагдсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлэгдсэн байна" гэж Нийслэл дэх төрийн аудитаас дүгнэв.

2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн зөрчил, өгсөн зөвлөмжийн дагуу хийх ажлын төлөвлөгөөг хийж "Төсвийн үр өгөөжийг сайжруулах, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" дүүргийн Засаг даргын А/156 тоот захирамж гарган цаашид алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх тал дээр шат шатандаа анхааран ажилласан.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн шалгалтаар зөрчилгүй, явцын шалгалтын зөрчлийг залруулан ажилласан 47 байгууллагуудын санхүүгийн ажилтнуудыг урамшуулах, акт, албан шаардлага авсан, зөрчил гаргасан 12 байгууллагын шууд захирагч болон санхүүгийн ажилтнуудад арга хэмжээ авах тухай дүүргийн Засаг даргын А/160 тоот захирамж гарч албан тоотоор хүргүүлэв.

Нийт 180 байгууллагын 2018 оны 1,2,3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэлийн "ТАЛСТ" програмаар тулган шалгаж баталгаажуулав.

Аж ахуйн нэгж байгууллага болон бусад байгууллагуудын тайлан хүлээн авалт:

Хан-Уул дүүрэгт харъяалагдах аж ахуйн нэгж, байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн тайлан тэнцлийг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд, Зөрчил шалган шийдвэрлэх, Зөрчлийн тухай хууль, Сангийн сайдын 242-р тушаалыг баримтлан үлдэгдэл б аланс, Орлого үр дүнгийн тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан С ангийн яамны шинэчилсэн "E-Balance" нэгтгэлийн программд бүрэн шивүүлж, илгээсэн тайланг хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч баталгаажуулан, нэгтгэлийг заавар журмын дагуу тайлагнаж байна.

Нэгтгэлийн программд 8497 аж ахуйн нэгж, байгууллага тайлангаа шивж, санхүүгийн тайлан өгөвөл зохих нийт 10609 аж ахуйн нэгж, байгууллагаас 8497 тайлан буюу 80.10%-ийг хүлээн авлаа.

Нэгтгэлийн программ дээрх нийт тайлан өгөвөл зохих 10609 аж ахуйн нэгж, байгууллагаас тайлан огт өгөөгүй 2369, тайлангаа цахимаар илгээсэн боловч аудитын компанийн нэр сонгоогүй 253 аж ахуйн нэгж, байгууллага байна.

Хүлээн авсан Санхүүгийн нийт тайлангуудаас хуулийн дагуу Аудитын дүгнэлт шаардлагата й 2405 тайлангаас Санхүүгийн тайланг Аудитын дүгнэлт, Аудитын байгууллагын албан тоот той хүлээн авсан бөгөөд 89.40%-тай байна.

2018 оны санхүүгийн тайлан тушаалтын байдлыг харуулбал:

- ✓ Шинээр бүртгүүлсэн-322 ААНБ
- ✓ Санхүүгийн тайлангийн залруулга хийлгэсэн- 43 ААНБ
- ✓ Татан буугдсан –12 ААНБ
- ✓ Нууц үг сэргээсэн- 16 ААНБ
- ✓ Шилжиж ирсэн-1 ААНБ

Санхүүгийн тайлангийн хуулийн хугацаа хожимдуулж, зөрчил гаргасан 36 байгууллагын захирал, нягтлан бодогч нарт нийт 18,0 сая төгрөгийн хариуцлагын арга хэмжээ авч 100% барагдуулан төсөвт төвлөрүүлэн ажиллалаа.

Дүүргийн хөрөнгө оруулалт: 2018 онд дүүргийн хөрөнгө оруулалтаар нийт 19 төсөл арга хэмжээг 1 тэрбум 922,0 сая төгрөгөөр хийхээр батласан бөгөөд эдгээрээс 17 төсөл арга хэмжээнд 1 тэрбум 264,3 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, 657,7 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжихээр байна.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 онд 369,7 сая төгрөгийн 21 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан бөгөөд үүнээс 19 төсөл арга хэмжээнд 329,6 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, он дамжин хэрэгжих 40,1 сая төгрөгний 2 төсөл арга хэмжээ үлдсэн байна.

✓ Засаг даргын тамгын даргын 2018.05.11-ны "Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын өмч, эд хөрөнгийн тооллого зохион байгуулах тухай" А/80 тоот тушаалын дагуу Засаг

даргын тамгын газрын өмч хөрөнгийн 2018 оны хагас жилийн тооллогыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.

Шилэн дансны мэдээлэл:

- Дүүргийн төсвийн байгууллага болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын төсвийн орлого, зарлага, тайлангийн бүх мэдээллийг олон нийтэд ил тод байхаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллалаа.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Хүүхэд харах үйлчилгээ: Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 513, 2018 оны 71 дүгээр тогтоолын дагуу Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч 38 иргэний үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг тухайн хорооны ажлын хэсгийн дүгнэлт, Засаг даргын албан бичгийг харгалзан Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/140 дугаар захирамжаар "Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл"-ийг олголоо.

Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчтэй үр дүнгийн гэрээ байгуулав.

Дүүргийн Засаг даргын захирамжаар Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын үр дүнгийн гэрээг дүгнэх ажлын хэсгийг байгуулан дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 18 сургуулийн захирал, 29 цэцэрлэгийн эрхлэгчийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэж дүнг Нийслэлийн Боловсролын газарт хүргүүлэв. Ажлын хэсгийн үнэлгээгээр хангалттайгаас дээш үнэлгээтэй дүгнэгдсэн 16 захирал, 28 эрхлэгчтэй Төсвийн ерөнхийлөн захирагчтай төсвийн шууд захирагчийн байгуулах үр дүнгийн гэрээг байгуулах ажлыг зохион байгуулсан. Мөн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус өмчийн 17 сургууль, 83 цэцэрлэгийн эрхлэгчтэй хамтран ажиллах гэрээг байгууллаа.



Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн үр дүнгийн гэрээний үнэлгээ: 2018 оны 06 дугаар сарын 28-29, 07 дугаар сарын 2-ны өдөр дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 16 захирал, 28 цэцэрлэгийн эрхлэгчийн Засаг даргатай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээний эхний хагас жилийн биелэлтийг дүгнэж дүнг Нийслэлийн Боловсролын газарт хүргүүллээ.

ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ЧИГЛЭЛЭЭР:

"Эко дүүргийн хүүхдүүд бидэнд үе тэнгийн гадуурхал үгүй" чуулган: 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр "Эко дүүргийн хүүхдүүд бидэнд үе тэнгийн гадуурхал үгүй" сэдэвт хүүхдийн чуулганыг дүүргийн Соёлын ордонд зохион байгуулав. Чуулганы үеэр үе тэнгийн гадуурхлыг бууруулахад сургууль, багш, эцэг, эх, хүүхдийн оролцооны талаар 4 бүлэгт

хуваагдан илтгэл хэлэлцүүлсэн бөгөөд оролцсон төлөөлөгчид англи хэл дээр илтгэл, хэлэлцүүлэг явагдаж зөвлөмж боловсруулан гаргаж дүүргийн удирдлагуудад хүргүүллээ. Тус чуулганд төрийн болон төрийн бус өмчлөлийн нийт 20 сургуулийн 80 сурагч оролцов:

“Хүүхэд хамгаалалд эцэг, эх, багш, төрийн байгууллагын хамтын ажиллагаа” сэдэвт өдөрлөг: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газраас санаачлан хүүхэд хамгааллын ажлыг эрчимжүүлэх, хүүхдийг гэмт хэрэг, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, цахимын хор хөнөөл, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, өсвөр насныхны сэтгэл зүйн онцлогийн талаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эцэг, эх, багш нарт мэдээлэл хүргэх, хүүхэд хамгаалалын чиглэлээр хэрэгжүүлж буй ажлыг танилцуулах зорилгоор “Хүүхэд хамгаалалд эцэг, эх, багш, төрийн байгууллагын хамтын ажиллагаа” сэдэвт өдөрлөгийг 2018 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр “Буянт-Ухаа” спорт цогцолборт зохион байгуулав.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газраас “Цахлай” төслийг хэрэгжүүлэн 2017 оны 12 дугаар сараас 2018 оны 03 дугаар сарыг хүртэлх 3 сарын хугацаанд 9-12 дугаар ангийн 1000 гаруй хүүхдийн цахим хэрэглээнд мэргэжлийн байгууллагатай хамтран, мэдээллийн технологийг ашиглан тандалт судалгааг хийсэн. Өдөрлөгийн үеэр хүүхэд хамгаалллын “Цахлай” төслийн хэрэгжилтийн талаарх тайлан судалгааг эцэг эхчүүдэд тайлагнав. Энэхүү үйл ажиллагааг зохион байгуулснаар эцэг эх, багш, сургууль хоорондын уялдаа холбоо сайжирч, хүүхдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсооход дэвшилтэт технологийг ашиглах, хүүхэд хамгаалллын ажлыг сайжруулах ач холбогдолтой болов.

“Эко дүүргийн залуус-Тогтвортой хөгжилд” залуучуудын чуулган: Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Хан-Уул дүүргийн Залуучуудын нэгдсэн холбоо, Шинэ хөгжлийн түлхүүр ТББ, Монголын үйлдвэрчний эвлэлийн залуучуудын хороо хамтран “ЗАЛУУСЫН ОРОЛЦОО–ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД” арга хэмжээг 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Монголын үйлдвэрчний эвлэлийн соёлын төв ордонд амжилттай зохион байгууллаа. Тус чуулга уулзалтын зорилго нь хороо, дүүрэг, нийслэлийн хөгжилд залуучуудын оролцоог идэвхжүүлэх, залуу хүний хувь хүний хөгжлийн манлайлал, хөдөлмөрийн зах зээл дээр чадварлаг залуучууд болон гарч ирэхэд нь дэмжлэг үзүүлэх, Монголын томоохон ААНБ-ын нээлттэй ажлын байр - JOB FAIR-танилцуулах, шилдэг Лекторуудын илтгэлээс сонсон сэдэлжүүлэлтийг өгөх, хороодод бий болсон Залуучуудын оролцооны шилдэг

бүлгүүдийн хороондоо хийж буй нийгмийн ажлынхаа талаар бусадтай хуваалцах боломжийг олгоход чиглэсэн болно.

Уг чуулга уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн 16 хороон дээр " Хан-Уул Эко дүүргийн хөгжилд- хороодын залуусын оролцоо" сургалтыг 2018 оны 03 дугаар сарын 05-15-ны хооронд хороо тус бүр дээр зохион байгуулж залуучуудтай уулзан, эхний "СЭДЭЛЖҮҮЛЭХ" үйл ажиллагааг Шинэ Хөгжлийн Түлхүүр ТББ-ын TES-EDU сургалтын баг амжилттай явуулсан болно.

Нийт 48 цагийн сэдэлжүүлэх сургалтад 786 залуучууд хамрагдсан бөгөөд тус сургалтаар " Залуу хүний үүрэг роль өөрийн оршин суугаа хорооны хөгжилд хэрхэн нөлөөлөх, бие хүн болон төлөвшихөд Залуу хүний хандлага, оролцоо гэж юу хэлэх вэ? ялагаад залуучууд хороо дүүргийнхээ хөгжилд гар бие оролцох ёстой, Хамт олон болж эвлэлдэн нэгдсэнээр Залуучууд амар амжилтанд хүрч болохыг уриалан дуудсан сургалт болж чадсан.

Энэхүү *"сургалтын үр дүн"* хороо бүрээс манлайлагч залуучууд өөрсдөө эвлэлдэн нэгдэж ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦООНЫ булгүүд байгуулж эхлэсэн нь залуучууд өөрсдөө хамт олон болж хороо, дүүрэгтээ өөрсдийн хувь нэмэрийг оруулах хүсэл эрмэлзлэлтэй болж чадсанд оршино.

Сургалтын үр дүнд үүсэн байгуулагдсан Залуучуудын оролцооны клубүүдээс Дэлхийн Зөн ОУБ-ын Хан-Уул дүүргийн ОНХХөтөлбөрөөс зарласан "Бичил төслийн уралдаан"-д идэвхитэй оролцож нийт ирсэн төслүүдээс 10, 13, 15 дугаар хороодын Залуусын булгийн бичсэн төслүүд шалгарч, "ЗАЛУУСЫН ОРОЛЦОО–ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД " чуулга уулзалтын үеэр шагналаа гардан авсан нь Залуусын Оролцооны булгүүдэд урам өгсөн сайхан арга хэмжээ боллоо. Шалгарсан төсөл тус бүр 3000 ам.долларын санхүүжилтээ Залуучуудын чуулганы үеэр гардан авсан бусад хороодын залуучуудыг сэдэлжүүлж өгсөн арга хэмжээ болж чадсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эхийн өдөрлөг: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эхчүүд нь ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй, орлого багатай, амьжиргааны түвшин доогуур, сэтгэл зүйн хувьд хямралтай, нийгмийн харилцаанд төдийлөн оролцож чаддаггүй, хууль эрх зүйн талаарх мэдээлэл хомс байдаг тул тэдэнд мэдээ, мэдээлэл өгч нэг өдрийг баяр баясгалантай өнгөрүүлэх боломжийг бүрдүүлэх, амьдралын итгэл үнэмшлийг олгох зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эхийн өдөрлөгийг 2018 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Хан-Уул дүүргийн Соёлын ордонд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Тусгай олимпын хороотой хамтран зохион байгуулав. Өдөрлөгийн арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 250 гаруй хүүхэд эцэг эхийн хамт оролцов.

"Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"ийг тэмдэглэн өнгөрүүлэх: Дүүргийн Засаг даргын 2018 оны А/151 дүгээр захирамжаар Олон улсын хүүхдийн

эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээг зохион байгуулах Ажлын хэсгийг батлуулсан. "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх, соёл урлаг, спортын арга хэмжээг хороо тус бүр өөрийн нутаг дэвсгэрийн онцлог байдлаар 2018 оны 05 дугаар сарын 27-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгууллаа. Дүүргийн бүтэн өнчин, хагас өнчин, хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн 1600 хүүхдэд дүүргийн Засаг даргын гарын бэлгийг хороодын баярын үйл ажиллагааны үеэр гардуулан өгч хүүхдүүдийг урамшуулласа.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнөрүүлэх

Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эмэгтэй төлөөлөгчдийн санаачлагаар дүүргийн Засаг даргын Тамгын газраас "Ээж бол ертөнц" хүндэтгэлийн нэгдсэн арга хэмжээг 2018 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Монголын Хүүхдийн ордонд зохион байгуулласа. Хүндэтгэлийн арга хэмжээнд Хан-Уул дүүргийн 444 ээж уригдаж Монгол Улсын өрөнхийлөгчийн зарлигаар олгодог "Эхийн алдар 1" одонгоор 21, "Эхийн алдар 2" одонгоор 423 ээжийг шагнаж Хан-Уул дүүргийн удирдлагууд хүндэтгэл үзүүллээ.

Соёлын чиглэлээр: Улсын хамгаалалтын зэрэглэлтэй "Их тэнгэрийн амны хадны зураг" дурсгалт газар нь Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлалтайг нотлох баримтыг Дүүргийн Газрын албаны албан бичгийг үндэслэн Баянзүрх дүүргийн хамгаалалтад шилжүүлэхээр НСУГ-т санал хүргүүлэн шийдвэрлүүлэв.

Соёлын өвийн тухай хуулийн заалтад үл хөдлөх дурсгалын бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалалт хамгаалалтын талаар хуулийн дагуу Хан-Уул дүүргийн хамгаалалтад байгаа 29 биет өвийн бүртгэл мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг нөхөж хийлээ. Үүнд:

- Соёлын өвийн тухай хуулийн дагуу Бүртгэл мэдээллийн санг Соёлын ордонд хүлээлгэж өгөх
- Дүүргийн хамгаалалтад байгаа нэр бүхий 11 дурсгалыг кадастрыг улсын бүртгэлд бүртгүүлэх
- Уг хөшөө дурсгалын засварлалт, түүхэн эх сурвалжийг нөхөн бичилтийг хийх

НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 35 дугаар тогтоолоор баталсан Соёл урлагийн сургалт цэнгээнт үйлчилгээний журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хан-Уул дүүргийн нутаг

дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын судалгааг шинэчлэн гаргаж нийслэлийн Соёл урлагийн газарт хүргүүлэв.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу "Байгууллагын бүртгэл мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг хийж Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн судалгаа, угийн бичиг хөтөлдөг иргэн, өрхийн судалгааг гарган нийслэлийн Соёл урлагийн газарт хүргүүлэв.

Хороодын хөгжлийн нийгмийн ажилтнуудад угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог нэмэгүүлэх, хэсгийн ахлагч нартай хамтран иргэдийн дунд үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэдээллийг өгөх зорилгоор "Монголын ураг удам уламжлал холбоо"-ны тэргүүн Ж.Түдэвдоржтой уулзалт ярилцлагыг зохион байгуулав.

Соёлын биет бус өвийн "Ардын урлагийн их наадам"

Хан-Уул дүүргийн Соёлын биет бус өвийн "Ардын урлагийн их наадам"-ын анхан шатны шалгаруулалт дүүргийн Соёлын ордонд 2018 оны 06 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Наадамд 16 хорооны 120 гаруй иргэд оролцов.

"Нүүдэлчин Монгол" наадам, Соёлын биет бус өвийн Ардын урлагийн их наадам

2018 оны 08 дугаар сарын 10-аас 13-ны өдрийг хүртэл Хүй долоон худаг дахь "Монгол наадам" цогцолборт зохион байгуулагдсан "Нүүдэлчин Монгол" наадам, Соёлын биет бус өвийн Ардын урлагийн их наадмын 2-р шатанд оролцогчдыг зохион байгуулан оролцлоо. Хан-Уул дүүргээс 30 соёлын өв тээгч ардын авъяастан оролцлоо. Ардын урлагийн 5 ай савын 3 төрөлд дүүргийн иргэд шалгаран шагнуулсан.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР

"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" сарын аян: 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян"-ы нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Сарын аяны хугацаанд нийт 12 ажлыг төлөвлөж, хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Нээлтийн үйл ажиллагаанд оролцсон 52 аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнуудад хууль тогтоомжийг сурталчлах, ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажилтны эрүүл мэндийг хамгаалах,

ажлын байрны соёлыг төлөвшүүлэх, аж ахуйн нэгж байгууллагуудад хийх хяналт шалгалтын хуудсын талаар мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа.

Барилгын аюулгүй ажиллагааны үзүүлэх сургалт: Нийслэл Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа барилга угсралтын 226 байгууллагын 367 ажил олгогч, барилгын инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан ажилтнуудад "Барилгын талбайд үзүүлэх сургалт"-ыг зохион байгууллаа.

Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд 2018.04.18-ны өдөр 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй "Номин констракшн деволопмент" группийн "Гарден Сити" барилга угсралтын талбайд барилгын аюулгүй ажиллагааны үзүүлэх сургалт зохион байгууллаа. Сургалтад Нийслэл Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй барилга угсралтын 226 байгууллагын нийт 367 ажил олгогч, барилгын инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан ажилтнууд хамрагдлаа.

Зорилтот өрх рүү чиглэсэн ажил:

"Зорилтот өрхийн хөгжлийн үнэлгээ хийх арга зүй аргачлал" сургалт 2018.03.20

Хөтөлбөрт хамрагдсан өрхийн 32 хүүхдэд олон улсын цирк үзүүлэв. /2018.03.30/

Хөтөлбөрт хамрагдаж буй өрхийн 85 иргэнд"Гэр бүлийн харилцаа,сэтгэл зүй" сургалт

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай" хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт заасны дагуу тус дүүргийн Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын дүгнэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй 1742 иргэнийг бүртгэн үнэмлэх олгосон.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэмлэх олголт: Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүгнэлтийн үндэслэн нийт 2302 иргэд хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх олгосон.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

“Халуун сэтгэлт Хан-Уулчууд” цус хандивлах үйл ажиллагаа

Цус судлалын төв, Улаан загалмайн хороотой хамтран нийгмийн хариуцлагаа биелүүлэн сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх “Халуун сэтгэлт Хан-Уулчууд” аяныг 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан. Уг цусны донорын өдөрлөгт Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, албадын нийт 80 гаруй ажилтан, албан хаагчид хамрагдаж цусаа хандивласан.

Төрийн бус, олон улсын байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр: Олон улсын байгууллага болон ТББ-ын хамтарсан зөвлөгөөн болж 2018 онд боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр халамж, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгаалал, хүнс, хөдөө аж ахуй, онцгой байдал, сайн дурын идэвхтэнтэй хамтран ажиллах чиглэлээр нийт 42 ажлыг 368,5 сая төгрөгний төсөвтэйгөөр хийхээр шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийн дагуу төлөвлөгөөг боловсруулан батлуулж 2018 оны 1 дүгээр сарын 30-ний өдөр дэргэдэх хэлтэс, алба болон хамтран ажилладаг 5 олон улсын байгууллага, 1 төрийн бус байгууллагад хүргүүлсэн.

2018 оны 02 дугаар сарын 13-ны өдөр “Үнэ цэнэтэй Ахмадууд – Эко хуримтлалын бүлэг” төслийг дүүргийн ахмадуудын дунд хэрэгжүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, “MSDI – Шинэ хөгжлийн түлхүүр” ТББ-тай хамтран санамж бичиг байгууллаа. Санамж бичигт Засаг даргын Тамгын газрын дарга Б.Энхболд, “MSDI - Шинэ хөгжлийн түлхүүр” ТББ-ын захирал Б. Анхбаяр, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний хэлтсийн дарга Б. Бадамсүрэн, Ахмадын хорооны дарга Д. Совдоо нар гарын үсэг зурлаа. Энэхүү “Үнэ цэнэтэй Ахмадууд – Эко хуримтлалын бүлэг” төслийн хүрээнд дүүргийн хэмжээнд сургалт, нөлөөллийн ажлууд зохион байгуулан ахмад настнуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэн, тэдэн рүү хандсан нийгмийн чиглэлийн олон талт үйл ажиллагаанд хамтран ажиллах юм.

Хан-Уул дүүргийн иргэдийн оролцоог төрийн үйлчилгээний салбаруудад идэвхжүүлэн хамтран ажиллах зорилт бүхий сайн дурын үйл ажиллагааны аргачлалыг танилцуулах, боломж, нөөцийг тодорхойлох зорилгоор Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Дэлхийн зөн Хан-Уул орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, Монголын сайн дурынхны төвтэй хамтран “Сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх боломж-хэрэгцээ” хэлэлцүүлгийг 2018 оны 02 дугаар сарын 13-аас 28-ны өдрүүдэд 8 удаа зохион байгуулаа. Хэлэлцүүлэгт Хан-Уул дүүргийн Боловсролын хэлтэс, сургуулийн удирдах ажилтнууд, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Цагдаа 1, 2 дугаар хэлтсийн албан хаагчид, Хороодын зохион байгуулагч, хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг,

ӨЭМ-ийн төвийн дарга нар оролцож сайн дурын үйл ажиллагааны талаар ерөнхий мэдээлэл авч, харилцан туршлага солилцон хамтран ажиллах талаар ярилцлаа.

2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Дэлхийн зөн ОУБ-ын Хан-Уул салбарын бичил төсөл шалгуруулах үйл ажиллагаат зохион байгууллаа. Төслийн уралдаанд 21 иргэн төслөө танилцуулснаас 3 төслийг шалгаруулан хэрэгжүүлэхээр боллоо.Үүнд:

1. "Сэтгэлийн сан" 12-р хорооны дундын халамжийн бүлэг нэгдэж "Хүүхдийн тоглоомын талбай" байгуулах төсөл.
2. 10-р хорооны иргэн О. Баяржаргалын "Эко орчин" сэдэвт төслийг ирүүлсэн бөгөөд энэхүү төсөл нь "Залуучуудын бүлэг" хамтран ногоон орчинг бий болгож хүүхэд, залуучууд, настангуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх талбайг байгуулах төсөл юм.
3. 13-р хорооны "Шувуун фабрик" залуучуудын бүлгэмийн гишүүн Б. Бямбахүүгийн хүүхдийн тоглоомын талбай байгуулах төслүүд шалгарсан.

Япон улсын Жайка хөтөлбөрийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын зохицуулагч Камеда Харуо, хөтөлбөрийн ажилтан Болор нартай уулзалт зохион байгуулж Монгол дахь төлөөлөгчийн газарт Хан-Уул дүүргийн зүгээс дараах саналуудыг хүргэлээ. Үүнд:

- Боловсролын нийгмийн ажилтан
- Сэргээн засалч, сувилагч
- Хорооны нийгмийн ажилтнуудад хамтран ажиллах Сайн дурын гишүүнийг ажиллуулах, салбар бүрээс нэг ажилтныг томилон "Алтан портнер" болгох хүсэлтэй байгааг илэрхийлэв.

Койка ОУБ-тай хамтарч ажиллах чиглэлээр уулзалт зохион байгууллаа. Койка Монгол дахь төлөөлөгчийн газар нь Сайн дурын гишүүд томилох хөтөлбөр, төр хувийн хэвшлийн түншлэлийн хөтөлбөр, Глобал сургалт зэрэг хөтөлбөрүүдийн хэрэгжүүлдэг. Хан-Уул дүүргийн зүгээс нийгмийн халамж, хүүхэд хөгжлийн чиглэлээр Сайн дурын гишүүнийг ажилуулах хүсэлтэй байгааг илэрхийлсэн бөгөөд бидний хүсэлтийг хүлээн аван авлаа.

Хан-уул дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг нийт 23 шашны байгууллагуудтай уулзалт зохион байгуулж дүүргийн ЗДТГ-ын зүгээс хамтран ажиллах хүсэлт тавьж, шашны байгууллагуудад тулгардаг асуудлуудыг сонсож санал бодлоо хуваалцлаа. Цаашид Төр-шашны байгууллагуудын хамтарсан зөвлөл байгуулан дүүрэгт иргэдийн сайн сайхны төлөө чиглэсэн үйл ажиллагаа, хүмүүнлэгийн үйлс хийхээр боллоо. Уулзалтад хийдүүдийн Пастер, лам нар нийт 26 хүн оролцсон бөгөөд цаашид хамтарч ажиллахаар боллоо.

Япон улсын Элчин сайдын яамнаас хэрэгждэг "Өвсний үндэс" буцалтгүй тусламжийн хөтөлберт ерөнхий боловсролын 59, 115 дугаар сургууль, 121 дүгээр цэцэрлэг, 6 дугаар хорооны дээврийн засвар, Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн дотоод засвар, Хан-Уул дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны бууз, банш үйлдвэрлэх төсөл нийт 6 төслийн шаардагдах баримт материалыг бүрдүүлэн хүргүүлсэн.

2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын дарга, "Нийгмийн хөгжлийн гарц" ТББ-тай хамтран ажиллах гэрээг байгуулж "Хөгжлийн замаар" сэдэвт төслийг хэрэгжүүлэхээр боллоо. Уг төсөл нь БНСУ, Монгол улсын талаас Нийслэлийн Хан-Уул дүүргийн бүтээн байгуулалт, дүүрэг хөгжүүлэх хэтийн төлөв, эко хот, аж үйлдвэрийн хотын

жишиг хөгжлийг бүтээх төлөвлөгөө, хэрэгжүүлж буй үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, улмаар хотын соёлыг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилготой юм.

Энэ төслийн хүрээнд Хан-Уул дүүргийн Хотын аялал жуулчлал, Хот төлөвлөлт ба дагуул хотын хөгжил, Жижиг дунд үйлдвэрлэл гэсэн 3 сэдвээр нэвтрүүлэг бэлтгэсэн.

ТОХИЖИЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Агаарын бохирдлын чиглэлээр: Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газар, Нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөл, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтарч дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг Уурын болон усан халаалтын зуухтай аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлагуудад "Магадлан итгэмжлэх" гэрчилгээ олгох, хяналт шалгалтын талаар мэдээлэл, зөвөлгөө өгөх сургалт зохион байгуулсан. Сургалтад халаалтын зуухны 35 аж ахуйн нэгж байгууллагын удирдлагууд оролцсон.

Нийслэлийн Агаарыг бохирдлыг бууруулах газартай хамтарч **"Агаар орчны бохирдлыг бууруулахад иргэд, аж ахуйн нэгжүүдийн оролцоо"** сэдэвт нээлтэй хаалганы өдөрлөгийг 2018 оны 08 дугаар сарын 18-ны зохион байгуулсан. Тус өдөрлөгт 11 аж ахуйн нэгж байгууллага 16 хорооны 2200 гаруй иргэд оролцлоо.

"Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник технологи"-ийн үзэсгэлэн худалдааны үр дүн.

Д/Д	Үзэсгэлэнд оролцсон иргэд	2017	2018
1	Үзэсгэлэн худалдаанд оролцсон иргэдийн тоо	7260	9340
2	Үзэсгэлэнгээс худалдан авалт хийсэн өрхийн тоо	21	29
	Үзэсгэлэнгээс худалдан авалт хийсэн төрөл		
3	Цахилгаан халаалт худалдан авсан өрхийн тоо	12	17
5	Сайжруулсан түлш худалдан авсан өрхийн тоо	5	7
4	Дулаалганы обой худалдан авсан тоо	4	5

Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч ААНБ-ын хүнд даацын автомашины тээвэрлэлтэд хяналт шалгалт хийж ажилласан талаар:

Дүүргийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтарч нэгдсэн ерөнхий шалгалтыг 10 удаа зохион байгуулсан.

Дүүргийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож байгаа аж ахуйн нэгж байгууллагын хүнд даацын автомашиныг технологийн замаар тээвэрлэлт хийлгэх” тухай А/94 дугаар захирамжийн хүрээнд хүнд даацын автомашинуудад хяналт шалгалт хийж, тэмдэг тэмдэглэгээ зөрчсөн, бичиг баримтын зөрчилтэй , даац хэтрүүлсэн нийт 210 автомашиныг журамлан саатуулж, 19,6 сая төгрөгний торгуулийг төсөвт төвлөрүүлсэн.

Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч ААНБ-ын хүнд даацын автомашины тээвэрлэлтэд хязгаарлалт хийх зорилгоор 2*9 метрийн хэмжээтэй 2 хурд сааруулагч, 8 ширхэг замын тэмдгийг шинээр байршуулсан. **Ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтын чиглэлээр:** Нийтийн эзэмшлийн зам талбай болон орон сууц хороолол дунд байрлах мод, бут, сөөгийг хэлбэржүүлэх ажлын хүрээнд 1300 ширхэг мод, сөөгийг тэгшиллээ.

Нийтийн эзэмшлийн талбайд байрлах мод бут, сөөгийн хавар намрын цэнэг усалгаа болон ногоон байгууламжийн өдөр тутмын усалгааг тогтмол хийгдсэн.

Гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ хийж ажилласан талаар: Иргэдийн аюулгүй амьдрах нөхцлийг хангах зорилгоор дүүргийн хэмжээнд асахгүй байсан нийт **1330** гэрэлтүүлгийн толгойн засвар хийж, бүрэн асаасан.

Засвар хийгдсэн гудамжны зат талбайн гэрэлтүүлгийн асалтын мэдээг хороодын Засаг дарга нараар батлуулж асалтын хувийг тогтмол 95%-аас дээш буюу бүрэн хангалттай байна.

Хог тээвэрлэлтийн талаар: Тохижилт Үйлчилгээний төв ОНӨААТҮГ, Хан-Уул агро ОНӨААТҮГ 2018 онд 16 хорооны аж ахуйн нэгж байгууллага, гэр болон орон сууц хороллын нийт 117928.6 тн хог хаягдлыг 27763 тн рэйсээр тээвэрлэсэн.

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЧИГЛЭЛЭЭР:

Батлан хамгаалахын сайд, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб нь Батлан хамгаалахын сайд, Нийслэлийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээ, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2018 оны зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус мөрдлөг болгон Цэргийн штабын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 84 арга хэмжээ төлөвлөснөөс 95,2 хувийн биелэлттэй байна.

Батлан хамгаалахын сайд, Нийслэлийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээнд 5 бүлэг 31 нэр төрлийн ажил, үйлчилгээтэй гэрээ хийгдсэнээс 2018 оны хэрэгжилт 100 хувьтай байна.

- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг спортын "Дөл тоглолт"-ыг 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр амжилттай явуулсан. Тэмцээнд Ерөнхий боловсролын сургуулийн 15 багийн 165 тамирчид оролцсон.

Тэргүүн байр - /4,27 онооогоор/ 114 дүгээр сургуулийн баг

Дэд байр - /4,27 онооогоор/ 15 дугаар сургуулийн баг

Гутгаар байр - /4,02 онооогоор/ Буянт-Ухаа цогцолбор сургуулийн баг тус тус шалгарсан.

Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах, албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Хууль зүй, архивын тасаг хамтран Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах, аврах 14, 30, 65 дугаар ангиудын албаа хаагчдад Цэргийн албаа хаагчийн эрх зүйн байдал, Цэргийн албаа хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай Цэргийн албаны тухай хуулиудаар сургалт зохион байгуулсан.

- Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагаагаар сурталчлах чиглэлээр Энхийг сахиулагчдын ёдрийг тохиолдуулан "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" сэдэвт сурталчилгааны ажлыг 2018 оны 05 дугаар сарын 01-20-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 120, 303, 327, 337 дугаар ангиудтай хамтран зохион байгуулсан.

Цэргийн насны залуучуудын цэргийн алба хаах боломжийг бүрдүүлэх зорилготой тэдний эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр "Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэх" болзолт уралдааныг дүүргийн Эрүүл мэндийн төв, хороод, өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд зарлаж, 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр жилийн ажлын үр дүнг шалгаж, дүгнэсэн.

- 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдөр ОХУ-ын эх орончдын өдөр, 05 дугаар сарын 09-ний өдөр Зайсан толгойн зөвлөлтийн дайчдын хөшөөнд Ялалтын баярын цэцэг өргөх арга хэмжээний бэлтгэл ажлыг тус тус ханган ажилласан. Хотын болон дүүргийн тохижилт үйлчилгээний төв, Замын цагдаагийн хэлтэс болон Цагдаагийн нэгдүгээр хэлтэстэй хамтран Танкийн хөшөөний орчмын талбайн цэвэрлэгээ, усалгаа, замын зохицуулалтын ажлыг зохион байгуулж, Оюуны ундраа ХХК-ны Зайсан скүэрийн LED дэлгэцээр ялалтын баярын мэндчилгээг явуулсан.

- Монгол цэргийн өдрийг тохиолдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, хорооны Засаг дарга нарын дунд 2018 оны 03 дугаар сарын 10, 13-ны өдрүүдэд гар бөмбөг болон боулингийн цогцолбор тэмцээнийг тус тус зохион байгуулсан. Тус тэмцээнд дүүргийн төрийн албан хаагчдыг бүрэн хамруулсан.
- Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 97 жилийн ойг угтан Боловсролын хэлтэстэй хамтран 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдөр дүүргийн Соёлын ордонд "Аавааараа бахархана" уулзалт өдөрлөгийг зохион байгуулсан.**Үр дүн:**

Батлан хамгаалахын сайд, Нийслэлийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээнд заасан ажил, үйлчилгээг Цэргийн штабын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаснаар иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх ажил дээшилж, Иргэн-цэргийн харилцаа бэхжин сайжирсан.

Дайчилгааны бэлэн байдал, төлөвлөгөө хавсралтуудын биелэлт, зарлан мэдээлэл, тодотгол, бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтын талаар: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн мн/01 дүгээр тушаалаар нийслэлийн Засаг даргаас өгөгдсөн дайчилгааны даалгаврын дагуу Зэвсэгт хүчний 10 ангийн 11 командад оногдуулан бүртгэгдсэн бэлтгэл офицер, цэргийн үүрэгтнүүдийг 2018 оны цэргийн бүртгэлийн материалтай тулгалт хийн шалгахад /шилжсэн, гадаадад, хаягандаа байхгүй, нас барсан гэх мэт/ шалтгаанаар өөрчлөлт орсон бэлтгэл офицерын 23,5 хувь, цэргийн үүрэгтний 10,4 хувийг шинээр оногдуулан бүртгэлтийг хийж, нэрийн жагсаалтыг анги, команд, хороодоор оногдуулан бүртгэлийн мэдээг улирал бүр хороодоос гаргуулан авч, гарсан өөрчлөлтийг тухай бүр өөрчлөлт оруулан ажилласан.

Цэргийн дайчилгааны тодотголыг тогтоосон хугацаанд 100 хувь зохион байгуулж, тодотгол явуулсан акт, илтгэх хуудсыг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүргүүлсэн.

Дайчилгааны төлөвлөгөөнүүдийн тодотголын талаар: Хан-Уул дүүргийн Улсын дайчилгааны төлөвлөгөө, Батлан хамгаалах товчоог дэлгэх төлөвлөгөө, Орон нутгийн цэргийг дэлгэх төлөвлөгөө, Зэвсэгт хүчний цэргийн анги байгууллагуудыг хүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө, дүүргийн цугларах байрыг дэлгэх төлөвлөгөө, техник шилжүүлэх байрыг дэлгэх төлөвлөгөөг 2018 оны 3 дугаар улиралд төлөвлөгөөнүүдийг боловсруулахад оролцсон холбогдох хэлтэс албадын дарга нарыг татан оролцуулан улсын дайчилгааны төлөвлөгөөг холбогдох чиглэлээр нь тодотгуулах ажлыг зохион байгуулсан.

Дайчилгааны зарлан мэдээллийн дохиогоор ажилласан талаар: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны мн/01 дүгээр албан бичгийг үндэслэн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2017 оны мн/01 дүгээр захирамжаар батлагдсан зарлан мэдээллийн дохиог дүүргийн дайчилгаа удирдах бүлгийн гишүүд, Цэргийн штабын тайван цагийн бүрэлдэхүүн, Хан-Уул дүүргийн 16 хороо, дүүргийн цугларах, шилжүүлэх байруудад зарлан мэдээлэл явуулан Дайчилгаа удирдах бүлэг, хороо, дайчилгааны томилгоот аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн зарлан мэдээллийн дохиогоор ажилласан тэмдэглэлтэй танилцан дараах дүгнэлт гаргалаа.

Дүүргийн Засаг даргын 2018 оны н/04 дүгээр захирамжаар томилогдсон дайчилгаа удирдах бүлгийн 16 гишүүн, дүүргийн хорооны дайчилгаа удирдах хэсэг буюу 16 хорооны Засаг дарга, дүүргийн цугларах болон шилжүүлэх байрын удирдлагад зарлан мэдээлийн дохиог 100 хувь хүлээн авч, үүрэг гүйцэтгэхээр бэлэн болох дадлага чадвар эзэмшсэн.

- Монгол Улсын Дайчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын 2018 оны н/01, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2018 оны н/14 дүгээр тушаалыг тус тус үндэслэн 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 24-ний өдрүүдэд Үндэсний Батлан хамгаалах их сургуулийн сургалтын материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан бэлтгэл офицерын сургалтад Хан-Уул дүүргийн 4 иргэн хамрагдаж, сургалтын хөтөлбөрийг ханган төгссөн.

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2018 оны сургалт, бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу **автын засварчин, С ангиллын жолооч, ариун цэврийн зааварлагч** мэргэжлээр дайчилгааны бэлтгэл нөөцийн бага мэргэжилтэн бэлтгэх сургалтыг Зэвсэгт хүчний 011, 027 дугаар ангиудын сургалтын материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан.

- Дүүргийн гэрээт харуул хамгаалалтын ажилтнуудтай дайчилгааны зарлан

мэдээллийг ажлын болон ажлын бус цагаар явуулах, томилгоот бүрэлдэхүүнд зарлан мэдээлэл хүргэх сургалт, дадлагыг 2018 оны 02 дугаар сарын 16, 11 дүгээр сарын 27-ны өдрүүдэд дүүргийн хурлын зааланд зохион байгуулсан.

- Дайчилгааны бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд Батлан хамгаалах товчоо,
- Дайчилгаа удирдах бүлгийн хэзрийн байрлалд байрлах майхан болон бусад

шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслийг бүрдүүлсэн.Дайчилгаа удирдах бүлгийн штабын дадлага, сургалтын бэлтгэл ажлын хүрээнд дүүргийн Дайчилгаа удирдах бүлгийн гишүүдэд зарлан мэдээллийн дадлагын дохиогоор 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр ажиллаж, Цэргийн штабын даргаас сургалт дадлагыг зохион байгуулах дүүргийн Засаг даргын захирамжийг танилцуулан бэлтгэл ажлыг хангах үүрэг, чиглэлийг өгсөн.

Дүүргийн цугларах, шилжүүлэх байрын дайчилгааны бэлэн байдлын зэрэгт шилжих үеийн бэлэн байдлыг 2018 оны 09 дүгээр сарын 14, 17-ны өдрүүдэд шалгаж, мэргэжлийн зөвлөгөө өгсөн. **Үр дүн:**

- Дүүргийн жижүүрүүдийн зарлан мэдээллийн дохиогоор үүрэг гүйцэтгэх дадлага чадвар нэмэгдсэн.

- Нийслэлээс өгсөн зарлан мэдээллийн дохиогоор, дотоодын зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх бодит хугацааг тогтоосон.

❖ **Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах талаар**

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 97 жилийн ойг тохиолдуулан 2018 оны 03 дугаар сарын 17-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороо, Зэвсэгт хүчний 011, 303, 120, 326 дугаар ангиуд, Монгол цэргийн музейтэй хамтран **“Нээлттэй өдөрлөг”**-ийн арга хэмжээг “ХҮННҮ МОЛЛ” худалдаа үйлчилгээний төвд зохион байгуулсан. Тус өдөрлөгийн арга хэмжээнд дүүргийн 300 гаруй иргэд оролцсон.

Дээрх арга хэмжээг тохиолдуулан Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд идэвхи зүтгэл, санаачлага гарган хамтран ажиллаж байгаа Зэвсэгт хүчний анги байгууллагын цэргийн алба хаагч, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, албан хаагч нарт дүүргийн ИТХ, Засаг даргын шагнал гардуулсан.

1945 оны чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин Х.Галжав гуай иргэдэд хандан сэтгэгдлээ хэлж, баярын мэнд хүргэсэн. Мөн 6 хүүхэд нь цэргийн алба хаасан алдарт эх Ж.Хандсүрэн гуайг алдаршуулсан.

Монгол цэргийн өдрийг тохиолдуулан дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан **"Монгол цэргийн алдар"** сэдэвт зохион бичлэгийн уралдааны шагналыг гардуулсан.

Тус зохион бичлэгийн уралдааны тэргүүн байр Буянт ухаа цогцолбор сургуулийн 12В ангийн сурагч М.Халиун, дэд байр 52 дугаар сургуулийн 12Д ангийн сурагч Г.Мандахай, гутгаар байр 34 дүгээр сургуулийн 11А ангийн сурагч Б.Хатансайхан нар эзэлж, шагнагдсан.

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Нийслэлийн Соёлын төв өргөөнд зохион байгуулсан Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 97 жилийн ойн баярын арга хэмжээнд идэвхтэй оролцож, иргэдэд Цэргийн штабын үйл ажиллагааны талаар ажлаа танилцуулсан. Тус арга хэмжээнд дүүргийн 320 иргэд, их дээд сургуулийн оюутнуудыг хамруулсан.

- Монгол цэргийн өдрийг тохиолдуулан Зэвсэгт хүчний анги байгууллага болон хүчний байгууллагын удирдлагыг 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдөр хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.

- Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит сар шинийн баярт зориулсан Өсвөр үеийн үндэсний бөхийн барилдааныг 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдөр дүүргийн Спорт хороотой хамтран зохион байгуулсан.

11-13 насны ангилалд 59-р сургуулийн бөх Дагвадорж түрүүлж, 59-р сургуулийн бөх Эрхэм-Эрдэнэ үзүүрлэсэн. 26-р сургуулийн бөх Баяртогтох, 59-р сургуулийн бөх Сүлдбаяр нар шөвгөрлөө. 14-15 насны ангилалд 26-р сургуулийн бөх Баярбаясгалан түрүүлж, 32-р сургуулийн бөх Төртогтох үзүүрлэн 41-р сургуулийн бөх Сумъяабазар, 10-р сургуулийн бөх Билгүүдэй нар шөвгөрсөн.

16-17 насны ангилалд Аварга сургуулийн бөх Өлзий-Орших түрүүлж, Аварга сургуулийн бөх Шатар үзүүрлэж, 114-р сургуулийн бөх Пүрэвжав, Аварга сургуулийн бөх Чимэдбатаа нар шөвгөрсөн.

Монгол Улсын Цэргийн албаны тухай хууль, Цэргийн штабын үйл ажиллагааг

сурталчилсан богино хэмжээний нэвтрүүлгийг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, иргэдэд цэргийн албыг сурталчлан таниулах ажлыг хэрэгжүүлж байна.Тус нэвтрүүлэгт дүүргийн нутаг дэвсгэрт оршдог Зэвсэгт хүчний 084, 120, 326 дугаар анги, Онцгой байдлын 14 дүгээр аврах, гал түймэр унтраах анги болон иргэдийг оролцуулсан.

Үр дүн:

- 2018 оныг **"Хууль тогтоомж – дайчилгааны бэлэн байдлыг хангах жил"** болгосонтой холбогдуулан гаргасан төлөвлөгөөнд эхний хагас жилд тусгасан ажил үйлчилгээг 100 хувь хэрэгжүүлсэн.
- Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулснаар олон иргэд хамрагдаж, иргэдийн хуулийн мэдлэг дээшилсэн.

Цэргийн штабаас аж ахуйн нэгж байгууллагуудад цэргийн үүргийн биелэлтэд хяналт шинжилгээ хийсэн дүнгийн талаар:

А. 2018 оны жилийн эцсийн байдлаар Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг дүүргийн Засаг даргын баталсан удирдамжаар зохион байгуулан шалгалтад 11 байгууллагын 18-50 насны 1212 цэргийн үүрэгтний нэрийн жагсаалт /4 дүгээр маягтаар/ авч, 1031 хүн буюу 85,1 хувийг хамруулснаас 40.8 хувь нь зөрчилтэй байсан. 1971-1991 онд төрсөн 6,7 хувьд нь цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр тогтоосноос **10,580,297** төгрөгийг нийслэлийн Төрийн санд төвлөрүүлсэн.

Б. Иргэд, ААНБ-ын ажилчин албан хаагчдад Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдөр "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын 100 гаруй ажилтан, албан хаагчидтай уулзалт зохион байгуулан шинэчлэн батлагдсан Батлан хамгаалах багц хуулиар танилцуулах мэдээллийг явуулсан.

Үр дүн:

- Байгууллага, аж ахуйн нэгжид цэргийн үүрэгтний үзлэг шалгалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу явуулснаар иргэний цэргийн зөрчил буурч байна.
- Батлан хамгаалах багц хуулиудыг байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, албан хаагчдад сурталчилсаны үр дүнд иргэнтэй холбоотой харилцааг зохицуулсан зүйл заалтууд, түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгүүдийн талаарх мэдлэг дээшилсэн.

Цэргийн бүртгэлийн талаар: 2018 оны 18-50 насны иргэдийн цэргийн бүртгэлийг зохион байгуулж явуулах дүүргийн Засаг даргын А/407 дугаар захирамжаар батлагдсан комисс, хороодод цэргийн бүртгэлийг цахим хэлбэрээр зохион байгуулах, хороо хариуцсан хэлтэс, албадын дарга нарт цэргийн бүртгэлийг хороодод зохион байгуулах, хяналт тогтоох, хамтран ажиллах, батлан хамгаалах төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх талаар дэмжлэг үзүүлж ажиллах чиглэл зөвлөмж өгч, хороодод ажиллах хуваарийг танилцуулан хэлтэс, албадын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч ажилласан.

2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр хороодын Засаг дарга, зохион байгуулагч, бүртгэлд ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хэсгийн ахлагч нартай тоо бүртгэлийг дүүргийн хэмжээнд зохион байгуулах комисс хамтарсан сургалт, семинарыг зохион байгуулсан. Сургалтыг 2 удаа зохион байгуулж, Цэргийн штабын офицеруудад хариуцаж ажиллах хорооны хуваарийг гарган хариуцуулан ажилласан.

2018 оны цэргийн бүртгэлийг 2018 оны 01 дүгээр сарын 04-20-ны өдрүүдэд Засаг захиргааны үндсэн нэгж хороодод төвлөрүүлэн, хорооны Засаг дарга эрхлэн явуулж, Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб цэргийн мэргэжлийн удирдлагаар, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс захиргааны удирдлагаар ханган ажиллаж, хороодын цэргийн бүртгэлийн хэсгийн ажиллах цагийн хуваарийг баталгаажуулан ажлын өдрүүдэд 08.30-19.00, амралтын өдрүүдэд 10.00-18.00 цагийн хооронд ажиллахаар зохион байгуулж, өдөр бүр салбар, комиссын гишүүд хариуцсан хороодод ажиллан цэргийн бүртгэлийн явц, үр дүн, иргэний мэдээллийн баяжилт, шинээр бүртгэгдэж байгаа иргэдэд хөтлөгдөж байгаа маягтуудын хөтлөлтөд хяналт тогтоон ажилласан.

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 25-аас дээш тооны цэргийн үүрэг хүлээсэн ажилтантай 117 ААН, 14 ерөнхий боловсролын сургууль, 12 их дээд сургуульд дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 01 дүгээр албан бичгээр цэргийн бүртгэлийг нэрийн жагсаалтаар явуулснаас 71 ААН буюу 77.6 хувь, ЕБС- 100 хувь, их дээд сургууль 73.3 хувь бүртгэлийг хугацаанд явуулан жагсаалтыг ЗДТГ-ын Цэргийн штабт ирүүлсэнийг цэргийн бүртгэлийн мэдээллийн сантай тулгалт хийн Хан-Уул дүүргийн харъяат иргэдийг бүртгэлд хамруулах ажлыг хороотой хамтран зохион байгуулсан. 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр дүүргүүдийн иргэдийн жагсаалтыг харъяа дүүрэгт нь хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

2018 оны Цэргийн бүртгэлийн мэдээ тайланг цаг хугацаанд нь гаргаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүргүүлсэн.

Цэргийн бүртгэлийн тоон үзүүлэлт: 2018 оны цэргийн бүртгэлд хамрагдсан цэргийн үүрэгтний тоо:

2018 ОНД ЦЭРГИЙН БҮРТГЭЛД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ТОО
0,7 ХУВИАР ӨССӨН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ БАЙНА.

	2017	2018
Хувь	96.4	97.1

Үр дүн:

Мэдээлэл, сурталчилгааны олон төрлийн хэлбэрийг ашиглан 2018 оны цэргийн бүртгэлийг журмын дагуу зохион байгуулалттай явуулснаар цэргийн үүрэгтний бүртгэлд дүүргийн цэргийн насны иргэдийн 97,1 хувь хамрагдсан нь **0,7** хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2018 оны 1 дүгээр ээлжийн цэрэг халалт, татлагын ажил:

2018 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг боловсруулан Цэрэг татлагын товчооны даргаар батлуулж, орон нутгийн төрийн захиргааны байгууллагын хэлтэс албадын дарга, шаардлагатай мэргэжлийн байгууллагын ажилтан, хорооны Засаг дарга, Цэрэг татлагын товчооны гишүүдийн ажил үүргийн хуваарийг гарган дараах ажил үйлчилгээг зохион байгуулан ажилласан.

Цэрэг татлагын явцын талаар:

2018 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг нийслэлийн Засаг даргын 2018 оны А/292, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2018 оны А/127 дугаар захирамжаар 2018 оны 05 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд дүүргийн өрөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн байранд зохион байгуулсан.

2018 оны нэгдүгээр эзлжийн цэрэг татлагад иргэдийн **6,6** хувь хамрагдаагүй бөгөөд ирээгүй шалтгааныг тогтоохоор хорооны Засаг дарга нарт үүрэг чиглэл өгсөн.

18-25 насны цэргийн үүрэгтнүүдээс ар гэрийн гачигдал болон бусад шалтгаанаар 62 өргөдөл, санал хүсэлтийг иргэдээс хүлээн авч "Цэргийн албаны тухай хууль" –ийн 13 дугаар зүйлийн 13.2.4 дэх заалтыг үндэслэн цэрэг татлагын товчоогоор оруулж, 56 иргэний хүсэлтийг хуулийн дагуу гачигдлаар түр чөлөөлөн шийдвэрлэсэн.

- Зарлан дуудах хуудасны тараалт 95,6 хувь
- Цэрэг татлагаар орсон 93,1 хувь

Үүнээс : Эрүүл мэндээр 30,1 хувь
Гачигдлаар 2,4 хувь
Суралцахаар 55,5 хувь
Хэргийн холбогдолоор 0,9 хувь

Нийслэлийн Цэрэг татлагын товчооноос Зэвсэгт хүчин бусад цэргийг нөхөн хангахаар өгсөн тоон даалгаварыг 100 хувь биелүүлсэн.

Цэрэг татлагын бэлтгэл ажил, явцын талаар **МҮОНРТ, NTV, ЭХ ОРОН, TV5 , E-TV** телевизүүдэд, 2018 оны цэрэг татлагын ажлын явцын талаар мэдээлэл өгч 34 дүгээр сургуулийн гадна дүүргийн цэрэг татлагын товчооноос электрон самбар байрлуулж цэрэг татлагын явцыг иргэдэд мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан.

Цэрэг татлагын байрны гадна "**Иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх байр**" гарган Эрүүл мэндийн төв, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Бүртгэлийн хэлтэс ажил үйлчилгээг иргэдэд үзүүлэх ажлыг зохион байгуулсан.

Хугацаа дуусгаж халагдсан дайчдыг байнгын болон түр ажлын байр, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулсан байдал: Зэвсэгт хүчин болон Хилийн цэргийн анги, байгууллагаас халагдсан дайчдыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс болон ажил олгогч байгууллагатай хамтран ажлын байраар хангах, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах үйл ажиллагаг 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Хан-Уул дүүргийн Соёлын ордонд зохион байгуулсан.

Тус арга хэмжээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга бөгөөд Цэрэг татлагын товчооны дарга Б.Энхболд, Цэргийн штабын дарга, хурандаа А.Баттулга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын ахлах офицер, дэд хурандаа Т.Мөнхбаяр нар оролцсон.

Хан-Уул дүүргийн Цэрэг татлагын товчооны дарга Б.Энхболд Монгол Улсын үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ нэр төртэйгээр хааж, халагдаж ирсэн дайчдад хандан баяр хүргэн дүүргийн Засаг даргын дурсамжийг гардуулсан.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Хөдөлмөр эрхлэлтийн албанаас уг арга хэмжээнд 24 ААНБ-ын 220 ажлын байрны захиалгатай оролцсон. Ажлын байранд нийт 38 иргэнийг бүртгэж, 19 иргэн ажил мэргэжлийн сургалтад хамрагдахаар бүртгүүлсэн. Байгнын ажлын байранд 3 иргэнийг "Магнай трейд" ХХК-д зуучилсан.

2018 оны 05 дугаар сард ЗХЖШ-ын Хуурай замын цэрэг болон Хилийн цэргийн анги байгууллагаас цэргийн жинхэнэ албаны хугацаа дуусган халагдаж ирсэн 122 байлдагчийг /цэргийн албаа үлгэр жишээ хааж сайшаалаар – **7**, өвчний учир - **7**, гачигдлаар - **9**/ Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, ажил олгогч байгууллагуудтай хамтран ажлын байранд зуучлах, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах ажлыг зохион байгуулан **42** иргэнийг байнгын болон түр ажлын байр, мэргэжил олгох сургалтад хамруулахаар зохион байгуулан ажилласан.

2018 оны 2 дугаар ээлжийн цэрэг халалт, татлагын ажил: 2018 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагын бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган Цэрэг татлагын товчооны даргаар батлуулан, Тамгын газрын ажилтан, хэлтэс, албадын дарга, хорооны Засаг дарга, Цэрэг татлагын товчооны гишүүдэд ажил үүргийн хуваарь гарган дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

18-25 насны цэрэгт татагдагчдын нэрийн жагсаалтыг дүүргийн Засаг даргын 2018 оны А/301 дүгээр захирамжийн хавсралтаар баталгаажуулж, тараасан зарлан дуудах мэдэгдлийн 96,03 хувь нь эзэндээ хүрсэн.

2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Цэрэг татлагын товчооны гишүүд болон хороо хариуцсан хэлтэс албадын дарга нартай Цэрэг татлагын товчооны хурал зохион байгуулан төрийн захиргааны болон үйлчилгээний **83** албан тушаалтанг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А/156 дугаар тушаалаар томилон ажиллуулсан.

Цэрэг татлагын явцын талаар: 2018 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг нийслэлийн Засаг даргын 2018 оны А/860, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2018 оны А/301 дүгээр захирамжаар 2018 оны 10 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд дүүргийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн байранд зохион байгуулсан.

2018 оны хоёрдугаар ээлжийн цэрэгт татагдах иргэдийн **6,3** хувь хамрагдаагүй бөгөөд ирээгүй шалтгааныг тогтоохоор хорооны Засаг дарга нарт үүрэг чиглэл өгч ажилласнаар 111 иргэний хил гарсан лавлагааг хүлээн авсан ба Цэргийн сургуулийн сонсогч 6, сануулах зөвлөмж 3, ял эдэлж байгаа 5, Эрүүл мэндээр 1, Зөрчлийн тухай хуулиар 22 иргэнд торгуулийн арга хэмжээ авч холбогдох баримт бичгийг дүүргийн Прокурорын газраар хянуулсан.

18-25 насны цэргийн үүрэгтнүүдээс ар гэрийн гачигдал болон бусад шалтгаанаар 54 өргөдөл, санал хүсэлтийг иргэдээс хүлээн авч "Цэргийн албаны тухай хууль" –ийн 13 дугаар зүйлийн 13.2.4 дэх заалтыг үндэслэн цэрэг татлагын товчоогоор оруулж, 45 иргэний хүсэлтийг хуулийн дагуу гачигдлаар түр чөлөөлөн шийдвэрлэсэн.

- Цэрэг татлагаар орсон нийт иргэдийн:

▪ Зарлан дуудах хуудасны тараалт	96,03 хувь
▪ Цэрэг татлагаар орсон	93,6 хувь
Үүнээс: Эрүүл мэндээр	34,06 хувь
Гачигдлаар	2,3 хувь
Суралцахаар	53,23 хувь
Хэргийн холбогдолоор	0,92 хувь

Нийслэлийн Цэрэг татлагын товчооноос Зэвсэгт хүчин бусад цэргийг нөхөн хангахаар өгсөн тоон даалгаврыг 100 хувь биелүүлсэн.

Хугацаа дуусгаж халагдсан дайчдыг байнгын болон түр ажлын байр, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулсан байдал:

Зэвсэгт хүчин болон Хилийн цэргийн анги, байгууллагаас халагдсан дайчдыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс болон ажил олгогч байгууллагатай хамтран ажлын байраар хангах, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах арга хэмжээг 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Хан-Уул дүүргийн Соёлын ордонд зохион байгуулж, Засаг даргын Тамгын газрын дарга бөгөөд Цэрэг татлагын товчооны дарга Б.Энхболд, Цэргийн штабын дарга, хурандаа А.Баттулга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын ахлах офицер, хурандаа Т.Мөнхбаяр нар оролцсон.

Хэвлэл, мэдээллийн байгууллагаас С1 телевиз сурвалжлага хийсэн. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Хөдөлмөр эрхлэлтийн албанаас уг арга хэмжээнд дэвсгэрийн бус 19 ААНБ-ын 89 ажлын байрны захиалгатай оролцсон. Ажлын байранд нийт 66 иргэнийг бүртгэж, 25 иргэн ажил мэргэжлийн сургалтад хамрагдахаар бүртгүүлсэн. Байгууллын ажлын байранд 18 иргэнийг зуучилсан.

Цэрэг татлагаар орсон иргэдтэй графикаар харуулбал



2018 ОНЫ 1 ДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГААС 2 ДУГААР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГА ЗАРЛАН ДУУДАХ МЭДЭГДЭЛ ЭЗЭНДЭЭ ХҮРСЭН **0,43 ХУВИАР**, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГТ ОРСОН ИРГЭН **0,5 ХУВИАР ӨССӨН** ҮЗҮҮЛЭЛТТЭЙ БАЙНА.

Он	Ээлж	Эзэндээ хүрсэн хувь	Үзлэгт орсон хувь
2018	I	95.6	93.1
2018	II	96.03	93.6

В. Эрүүл мэндээр тэнцээгүй иргэдийг эрүүлжүүлэх ажлын талаар:

"Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэх" болзолт уралдааны хүрээнд 5, 16 дугаар хороо дүүргийн Эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн эмч нартай хамтран 2018 оны 04 дүгээр сарын 19, 24-ний өдрүүдэд цэргийн насны иргэдийн дунд эрүүл мэндийн үзлэг, оношлогоо, сургалт сурталчилгааг явуулсан өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулсан.

Цэргийн насны залуучуудын цэргийн алба хаах боломжийг бүрдүүлэх зорилготой тэдний эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр "Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэх" болзолт уралдааныг дүүргийн Эрүүл мэндийн төв, хороод, өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд зарлаж, 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр жилийн ажлын үр дүнг шалгаж, дүгнэсэн.

Үр дүн:

- 2018 оны ээлжит цэрэг татлагаар Хуурай замын болон Хилийн цэргийг нөхөн хангах цэрэг татлагын тоон даалгаврыг 100 хувь биелүүлсэн.
- Цэргийн насны залуучуудын эрүүлжилтийн программыг нарийн мэргэжлийн эмч нарт ашиглагдах компьютерийг дотоод сүлжээгээр холбож ажилласан.
- Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр болзолт уралдааныг зарлаж ажилласнаар ээлжит цэрэг татлагаар эрүүл мэндээр тэнцээгүй 29 иргэн эрүүлжиж цэргийн албанд татагдсан

Цэргийн дүйцүүлэх албыг биеэр болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан байдал

А. Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж байгаа байдал

№		2016	2017	2018
1	Алба хаасан	6		
2	Алба хааж байгаа болон шинээр элссэн		5	6
3		Одоогоор 11 иргэн дүйцүүлэх албыг биеэр хааж байна.		

Б. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хааж байгаа байдал

№		2018 он
1	Мөнгөн төлбөр тогтоосон	252 иргэн
2	Мөнгөн төлбөр төлсөн	Нийслэлийн Төрийн сангийн 100200000984 тоот дансанд 252 иргэний 153,958,477 төгрөг төвлөрүүлсэн.
3	Мөнгөн төлбөрөөс чөлөөлөгдсөн	77 иргэн

В. Цэргийн албаны тухай Монгол Улсын хуулийн 33 дугаар зүйлийн 33.8, Засгийн газрын 2018 оны 79, 80 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/395 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2018 оны А/158 дугаар захирамжийн дагуу нийслэлийн 9 дүүргийн цэргийн дүйцүүлэх алба хаагч болон 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэнтэй "Цэргийн анхан шатны бэлтгэл сургалт"-ыг Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн сургалтын материаллаг баазыг түшиглэн 2018 оны 05 дугаар сарын 16-29-ний өдрүүдэд зохион байгуулж, сургалтад Хан-

Уул дүүргийн 11 иргэн хамрагдаж, бусад дүүргийн бүрэлдэхүүний хамт 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдөр "Гэрчилгээ" гардан авсан.

"Оюутан-цэрэг хөтөлбөр"-ийн талаар: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2018 оны А/60 дугаар захирамж, Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/10 дугаар тушаалын дагуу "Оюутан-Цэрэг" сургалтад хамрагдах оюутны бүртгэлийг 2018 оны 03 дугаар сарын 01-09-ний өдрүүдэд дүүргийн Соёлын ордонд зохион байгуулан явуулсан. Их, дээд сургуулиас ирүүлсэн нэрсийн жагсаалтын дагуу бүртгэлийг бүрэн явуулсан.

"Оюутан-цэрэг" цэргийн мэргэжил олгох сургалтын бүртгэлд хамрагдсан дүүргийн их, дээд сургуулийн оюутнууд 2018 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Цэргийн төв эмнэлэгт зөрүүл мэндийн үзлэгт орсон. Зөрүүл мэндийн үзлэгт тэнцээгүй 17, үзлэгт ирээгүй 11, нийт 28 оюутан хасагдсан. "Оюутан-цэрэг" сургалтад хамрагдах оюутнууд 2018 оны 03 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд Үндэсний батлан хамгаалах их сургууль бие бялдарын хөгжлийн шалгалтад орсон. Бие бялдарын хөгжлийн шалгалтад тэнцээгүй 9 оюутан хасагдсан.

2018 оны 08 дугаар сарын 14-ний өдөр ҮБХИС-ийн сургалтын материаллаг баазыг түшиглэн зохион байгуулж байгаа "Оюутан-цэрэг" цэргийн мэргэжил олгох сургалтын эцсийн шатны хээрийн дадлага сургалтад хамрагдаж байгаа Хан-Уул дүүргийн их, дээд сургуулиас оролцсон оюутнуудын Цэргийн үүрэгтний үнэмлэх дээрх цэргийн алба хаасан тухай тэмдэглэлийг хөтлөх ажилд дүүргийн Цэргийн штабын дарга, хурандаа А.Баттулга, тоо бүртгэлийн офицер, ахмад Н.Насанбат нар томилогдон ажилласан.

2018 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Шархадны сургалтын төвд "Оюутан-цэрэг" сургалтад хамрагдсан дайчдын **"Цэргийн тангараг"** өргөх баярын арга хэмжээнд дүүргийн Цэргийн штабын дарга, хурандаа А.Баттулга, тоо бүртгэлийн офицер, ахмад Н.Насанбат нар оролцсон.

Үр дүн:

- 2018 оны Оюутан-цэрэг цэргийн мэргэжил олгох сургалтад 9 их, дээд сургуулийн оюутан бүртгэлд хамрагдсанаас 8 их, дээд сургуулийн оюутан сургалтын хөтлөбөрийг ханган цэргийн тангараг өргөснөөр дайчилгааны бэлтгэл нөөцийг бүрдүүлж байна.
- Цэргийн албаны төрлүүдийг иргэдэд сурталчилж, оюутан залуусын цэргийн хэргийн мэдлэг дээшилж, цэрэг эх оронч үзэл төлөвшиж, бие бялдрын хөгжил сайжирсан.

Б. Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах, албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Хууль зүй, архивын тасаг хамтран Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах, аврах 14, 30, 65 дугаар ангиудын алба хаагчдад Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай Цэргийн албаны тухай хуулиудаар сургалт зохион байгуулсан. Сургалтыг Батлан хамгаалах яамны Стратеги төлөвлөлтийн газрын Хууль зүйн хэлтсийн дарга, хурандаа Г.Энхболд, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын төлөвлөлт, сургалтын офицер, дэд хурандаа Г.Жаргалсайхан удирдан хүргэсэн.

Цэргийн ар гэрт үзүүлэх халамж үйлчилгээ, халагдсан дайчдыг ажлын байраар хангасан талаар

/давхардсан тоогоор/

Хороод	Байгчын ажлын байранд зуучилсан, оруулсан	Мэргэжил олгох болон давтан сургалтад	Эрүүл мэндийн үзлэгт хамруулсан	Эд материалын тусламж үзүүлсэн	Бусад халамж үйлчилгээ	Нийт
1-р хороо	-	-	-	1	1	**2**
2-р хороо	1	-	2	4	6	**13**
3-р хороо	1	2	1	1	3	**8**
4-р хороо	1	1	-	1	2	**5**
5-р хороо	1	1	4	-	4	**10**
6-р хороо	2	3	-	1	6	**12**
7-р хороо	1	-	-	1	1	**3**
8-р хороо	16	4	11	1	-	**30**
9-р хороо	1	2	5	2	2 иргэнд 2тн нүүрс	**12**
10-р хороо	2	2	8	2	2 иргэнд 2тн нүүрс	**16**
11-р хороо	-	3	3	2	1 иргэнд 500,000 төг	**9**
12-р хороо	-	1	6	3	2 иргэнд 2тн нүүрс	**12**
13-р хороо	6	2	-	3	-	**11**
14-р хороо	4	6	5	3	2 иргэнд 0,6 куб түлээ	**20**
15-р хороо	-	-	1	-	1	**2**
16-р хороо	1	-	9	-	-	**10**
Нийт	**37**	**27**	**55**	**25**	**31**	**175**

Үр дүн:

Цэргийн алба хааж байгаа дайчдын ар гэрт болон халагдаж ирсэн дайчдад төрийн халамж үйлчилгээг хүргэснээр 68 хувь нь төрөл бүрийн халамж, үйлчилгээнд хамрагдсанаар цэргийн албаны нэр хүндийг өсгөн цэргийн албанд явах хүсэл, эрмэлзлийг төрүүлж, батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх иргэдийн тоо нэмэгдэхэд нөлөөлсөн.

Мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалтын талаар:

А. Цэргийн штабын 2018 оны үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний дагуу хорооны Засаг дарга, зохион байгуулагч нартай мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалтыг хангах чиглэлээр сургалтыг 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдөр мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулсан. Сургалтад 14 хорооны Засаг дарга, 16 зохион байгуулагч хамрагдсан.

Тус өдөр хорооны Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөний дараа Мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалтын чиглэлээр Зэвсэгт хүчний Жанжин штабын Холбоо, мэдээлэл технологийн хэлтсийн МАБ-ын албаны ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Ж.Баттөмөр "Мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалтын ажлын зохион байгуулалт" сэдвээр, нийслэлийн Мэдээлэл, технологийн мэргэжилтэн Н.Пүрэв "Мэдээлэл, сүлжээний аюулгүй байдал" сэдвээр хичээл явуулсан. Сургалтын дараа хувцасны үзлэг хийсэн.

Б. Архивын нягтаршуулсан шүүгээ авч, нууц хадгалалт хамгаалалтын өрөөнд байрлуулж, 4 ш цоожийг нэмэлтээр суурилуулсан.

Нууцын өрөө нь "Монгол Улсын Зэвсэгт хүчний нууцыг хамгаалах журам"-ын 7 дугаар бүлгийн 7.1 дэх хэсгийн шаардлагын дагуу төмөр хаалгатай цонх хөшиг, галын болон дуут дохиоллоор тоноглогдож, Тамгын газрын харуулын суурин утас, мэдээллийн аюулгүй байдлын офицерын гар утастай тус тус холбогдсон, галын булан гал унтраах багаж хэрэгсэл, сейф, цахим мэдээлэл боловсруулах, олшруулах техник хэрэгслээр хангагдсан нь нууц баримт бичиг боловсруулах, хадгалах, олшруулах, нууц хамгаалах журмын шаардлагыг ханган ажилласан.

Архивын үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн ажил: "Монгол Улсын Зэвсэг хүчний нууцыг хамгаалах журам"-ын 2 дугаар бүлгийн 2.2.12-д заасны дагуу 2018 оны нууц бичиг, хэрэг, данс бүртгэлийн ангиллыг 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Цэргийн штабын даргаар

батлуулж, 2017 оны нууц бичиг, хэрэг данс бүртгэлийн ангиллыг хааж, дайчилгааны 5 хавтаст хэрэг, нууцын 10 хавтаст хэргийг архивлан, хадгаламжийн нэгжийг Цэргийн штабын архивт шилжүүлэн архивын данс бүртгэлд авсан.

2000-2012 оны байнга хадгалах нууц 17, илт 23 нийт 40 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ-техник боловсруулалт хийж Батлан хамгаалахын төв архивт шилжүүлсэн.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт: 2018 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан ББНШК-ын хурлаар хэлэлцүүлэн батлуулж, жагсаалтын дагуу албан хэрэгцээний хавтаст хэрэг хөтлөлтийн зааврын дагуу хөтлөгдөж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хавтас хэргүүдийг шинэчилсэн.

3.2 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл;

2018 оны жилийн эцсийн байдлаар хүний нөөцийн холбогдолтой 27 захирамж, 363 тушаал шийдвэр гарснаас ажилд томилох тухай 122, албан тушаалаас чөлөөлөх тухай 92, буцалтгүй тэтгэмж олгох тухай 53, гэрээт ажилтан ажиллуулах тухай 5, чөлөө олгох тухай 8, жирэмсний болон амаржсаны амралт олгох тухай 15, нөхөн олговор олгох тухай 4, хугацааны нэмэгдэл олгох тухай 1, Хүүхэд асрах чөлөө олгох тухай 2, ажлаас чөлөөлж ажилд томилсон тухай 25 тушаал тус тус гарсан байна.

Нийт 242 албан бичиг ирснээс 242 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, хариу өгсөн. Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн хүний нөөцийн холбогдолтой нийт 48 өргөдөл, гомдлыг Smart city програмаар хүлээн авч судлан 48 өргөдлийг шийдвэрлэж, холбогдох эзэнд нь хариуг өгч ажиллалаа.

Хүний нөөцийн холбогдолтой шийдвэрийг графикаар үзүүлбэл:



Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

Засаг даргын Тамгын газрын Дотоод журмын дагуу албан хаагчдын ар гэр, эрүүл мэндэд нь зориулж нэр бүхий 53 албан хаагчид Буцалтгүй тусламжаар нийт 52,080,733 /Тавин хоёр сая наян мянга долоон зуун гучин гурав/ төгрөг олгосон.

Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр,төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн албан хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлагыг судлан санал, харьяа дээд байгууллагаас өгсөн зөвлөмжүүдийг үндэслэн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг боловсруулан зохих сургалтуудыг хэрэгжүүлэв. Төлөвлөгөөнд тусгасны дагуу дүүргийн 16 хороодын 180 гаруй хэсгийн ахлагч нарт, 16 хороодын 16 Засаг дарга нарт харилцаа хандлага, ёс зүй, байгууллагын соёлын сургалтыг зохион байгуулав. ЗДТГ-ын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 35 сургалт зохион байгуулагдлаа. Үүнд: Гэр бүлийн тогтвортой байдал, Зөрчлийн тухай хуулийн сургалт, Англи хэлний сургалт, "Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал", Албан хэрэг хөтлөлт, Ажлын байрны өрөө тасалгаанд эрүүл ажиллах тухай, үүлэн технологийн сургалт, харилцаа хандлагын тухай сургалтанд давхардсан тоогоор ЗДТГ-ын 450 гаруй албан хаагчид хамрагдлаа. Мөн дээд шатны байгууллагаас /Авлигатай тэмцэх газар, яам агентлаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн захиргачийн ажлын алба/ зохион байгуулсан 40 гаруй сургалтад ЗДТГ болон хороодын 450 гаруй албан хаагчид хамрагдсан.

АВЛИГЫН ЭСРЭГ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны "Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөө батлах тухай" 23/01 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан уг төлөвлөгөөт ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулахаар төлөвлөгөөт хуваарийн дагуу ажиллаж байна.

Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөөний хүрээнд дүүргийн Засаг даргын 2018 оны А/18 дугаар захирамжаар "Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө"-г боловсруулан батлуулж, нийт 20 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2018 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 93 хувьтай хэрэгжсэн. Авлигын эсрэг хөтөлбөрийн хүрээнд дүүргийн ЗДТГ, хороод, болон дэргэдэх хэлтэс албадын 200 орчим албан хаагчдыг Авлигын эсрэг сургалтад хамрууллаа.

2018 оны 12 дүгээр сард Авлигын эсрэг хөтөлбөр, тогтоомжийн эмхэтгэл товхимлыг хэвлэн дүүргийн 16 хороо, ЗДТГ, дэргэдэх хэлтэс албадад хүргүүлсэн. Авлигагүй тунгалаг дүүрэг болох зорилтын хүрээнд авлигыг мэдээлэх 1800-1969 дугаарын утсыг дүүргийн цахим хуудаст ил тод байдлаар байршүүлсан. Мөн Авлигад өртөх эрсдэлтэй албан тушаалын судалгааг ЗДТГ-ын нийт албан хаагчдаас авч жагсаалт хэлбэрээр дүүргийн цахим хуудаст ил тод байдал буланд байршүүлсан.

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ИЛ ТОД БАЙДАЛ

Дүүргийн засаг даргын 2018 оны А/32 дугаар захирамжийг үндэслэн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж,

батлуулсан.

Мөн болловсон хүчний хувийн хэгийн баяжилтыг сайжруулах, хувийн хэргийн стандартыг мөрдөж шинэлэг арга барилаар Засаг даргын Тамгын газрын болон хорооны 145 албан хаагдын хувийн хэргийн баяжилт, шинэчлэлийг хийсэн. Засаг даргын Тамгын газрын дотооддоо ашиглах хүний нөөцийн программыг нэвтрүүлэн 145 албан хаагчдын мэдээллийг оруулж, холбогдох цэсний баяжилтийг хийж байяжуулсан. Мөн нутгийн захиргааны байгууллагуудын ашиглах ERP нэгдсэн системд байгууллагын албан хаагчдын мэдээллийг оруулж, бүртгэх, хянах, засварлах ажлуудыг зохион байгуулсан. Дүүргийн цахим хуудаст 2018 онд зарласан сул орон тооны захиалга, дүүргийн Засаг даргын Тамгын газарт мөрдөгдөж буй дотоод журам, харилцаа хандлагын нийтлэг журам, Ажлын цаг ашиглалтын журмуудыг хүний нөөцийн ил тод байдал буланд байршуулсан.

3.3 Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлсэн үнэлгээтэй холбоотой мэдээлэл;

Төсвийн шууд захирагч, нэгжийн менежертэй, нэгжийн менежер, төрийн жинхэнэ албан хаагчтай Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолыг үндэслэн, 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Үр дүнгийн гэрээ байгуулж, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг хагас, бүтэн жилийн байдлаар дүгнэж, үнэлэн ажилласан.

Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Б/163 дугаар тушаалаар 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэсэн үнэлгээгээр “А” буюу “Маш сайн” үнэлгээгээр Тамгын газрын 50, хорооны 16, “В” буюу “Сайн” үнэлгээгээр Тамгын газрын 1, хорооны 15, “С” буюу “Хангалттай” үнэлгээгээр хорооны 2, нийт 84 албан хаагч тус тус үнэлэгдэн урамшуулал авсан.

Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Б/364 дүгээр тушаалаар 2018 оны жилийн эцсийн үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэсэн үнэлгээгээр “А” буюу “Маш сайн” үнэлгээгээр Тамгын газрын 45, хорооны 33, “В” буюу “Сайн” үнэлгээгээр Тамгын газрын 4, хорооны 2, нийт 84 албан хаагчдад тус тус урамшуулал олгосон.

2018 онд төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн гэрээгээр байгуулан ажилласнаас 100 хувийн урамшуулал авсан Тамгын газрын 23, хорооны 5, 50 хувийн урамшуулал авсан Тамгын газрын 1, хорооны 4, нийт 33 албан хаагчдад, мөн 16 хорооны 178 хэсгийн ахлагчтай хөлсөөр ажиллах гэрээ байгуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Б/365 дугаар тушаалаар 50 хувийн урамшууллыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус олгосон.

2017 онд гэрээ байгуулж ажилласан 45 албан хаагчийн үр дүнгийн гэрээг хүлээн авч архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгсөн.

3.4 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл;

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг

эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод төвшинд хүргэхээр зорин ажиллаж байна.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2018 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс нийт 785 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлжээ. Үүнээс 776 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, 8 өргөдөл, гомдол шийдвэрлэх шатанд, хяналтад байна.

Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног, 9 цаг, 43 минут байна. Дундаж хугацааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоногоор буурсан үзүүлэлттэй байна.



Нийт 785 өргөдлөөс

- шийдвэрлэсэн 776 буюу 98,8%
- шийдвэрлэх шатандаа байгаа 8 буюу 1,01%-тай шийдвэрлэгдсэн байна.

Бүтэн жилийн байдлаар хугацаа хэтэрсэн 1 өргөдөл,гомдол шийдвэрлэгдсэн байна

Өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэхэд анхаарч 7 хоног бүрийн баасан гаргт хэлтэс, албадын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үзүүлэлтийн тайланг бэлтгэн Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Засаг даргын Тамгын газрын шуурхай зөвлөгөөн дээр танилцуулж, шийдвэрлэлтийн явцын тэмдэглэл хөтлөх, өргөдөл гомдлыг удирдлагын түвшинд шуурхай шилжүүлж байх талаар мэдээлэл өгч, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлж ажиллахыг тухайлсан мэргэжилтнүүдэд анхааруулж ажиллаж байна.

Ангилж үзвэл:

Иргэдийн хандалтад дүн шинжилгээ хийж үзэхэд:

Эмчилгээний төлбөр, мөнгөн тусламж, хороодын үйл ажиллагаатай холбоотой нийт 139 өргөдлийн 17.7%-ийг, Цэргийн албанаас чөлөөлөгдөх хүссэн нийт 121 өргөдлийн 15.4% хувийг, СӨХ болон хог хаягдал, тохижилтын талаар 321 өргөдөл 40.9%-ийг тус тус эзэлж байна.

Хог тээвэрлэлт, золбин нохой устгах СӨХ-ийн асуудлуудаар хамгийн их хандаж гомдол ирүүлсэн бөгөөд сар бүр иргэдээс ирүүлсэн гомдлыг хэлтэс, тус бүрээр шуурхай зөвлөгөөн дээр танилцуулан ажиллаж байна.

Засаг дарга иргэдэд мөнгөн тусламж үзүүлсэн тухай:

Дүүргийн засаг даргын 2014 оны 04 сарын 16-ний өдрийн А/111 тоот захирамжаар “Иргэдээс мөнгөн тусламж хүссэн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх тухай журамд заасны дагуу хороодын хөгжлийн нийгмийн ажилтныг мөнгөн тусламж хүссэн иргэдийн гэрээр очиж судлуулан нөхцөл байдлын үнэлгээ хийлгэн нийт 43 иргэнд 15.070.000 /Арван таван сая далан мянган/ төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн байна.

Засаг даргын тамгын газрын болон дэргэдэх хэлтэс, албадын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар: Сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон ЗДТГ, дэргэдэх хэлтсүүдийн иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн дүүргийн статистикийн хэлтсээс эрхлэн гаргадаг статистикийн мэдээлэл гарын авлагад нийтлүүлж байна.

Хэлтэс, албадын жилийн эцсийн өргөдөл гомдол шийдвэрлэлт

№	Хэлтэс, албадын нэр	Нийт өргөдөл, гомдол	Шийдвэрлэх шатандаа байгаа	Бусад байгууллагад шилжүүлсэн	шийдвэрлэсэн
1	Засаг даргын Тамгын газар	777	9	/-/	768
2	Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний хэлтэс	128	/-/	/-/	128
3	Газрын алба	3009	1740	/-/	1269
5	Боловсролын хэлтэс	77	/-/	/-/	77
6	Онцгой байдлын хэлтэс	5	/-/	/-/	5
7	Албан бус насан туршийн боловсролын төв	320	/-/	/-/	320
8	Бүртгэлийн хэлтэс	40	/-/	/-/	40
НИЙТ		**4356**	1749	**0**	2607

Хороодын өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Хороо №	Нийт өргөдөл	Шийдвэрлэх шатанд байгаа			Шийдвэрлэсэн			Уламжилсан	Зөрчил
		Хугацаандаа байгаа	Хугацаа хэтэрсэн	Бүгд	Хугацаа хэтэрч	Хугацаандаа	Бүгд		
1 хороо	4	0	0	0	0	4	4	1	0
2 хороо	30	0	0	0	0	30	30	1	0
3 хороо	8	0	0	0	0	8	8	17	0
4 хороо	0	0	0	0	0	0	0	2	0
5 хороо	5	0	0	0	0	5	5	1	0
6 хороо	0	0	0	0	0	0	0	13	0
7 хороо	0	0	0	0	0	0	0	0	0
8 хороо	10	0	0	0	0	10	10	11	0
9 хороо	1	0	0	0	0	1	1	5	0
10 хороо	5	0	0	0	0	5	5	14	0
11 хороо	2	0	0	0	0	2	2	6	0
12 хороо	1	0	0	0	0	1	1	26	0
13 хороо	3	0	0	0	0	3	3	13	0
14 хороо	0	0	0	0	0	0	0	2	0
15 хороо	2	0	0	0	0	2	2	0	0
16 хороо	0	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	71	0	0	0	0	71	71	112	0

3.5 Засаг даргын Тамгын газрын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл;

- Харилцахын 1830 ширхэг баримтаар 5.195.660.925,17 төгрөгийн гүйлгээг хийж баталгаажуулсан.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын сангийн 60 ширхэг баримтаар 869,257,136 төгрөгийн гүйлгээг хийж баталгаажуулсан.
- Орон нутгийн хөгжлийн сангийн 34 ширхэг баримтаар 209,161,775 төгрөгийн гүйлгээг хийж баталгаажуулсан.
- Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар 48 ширхэг баримтаар 222,661,879 төгрөгийн гүйлгээг хийж баталгаажуулсан.

Тамгын газрын албан хаагчдын хувийн хэрэг бүрдүүлэлтийн материалын гэрээ, "Иргэний андгай өргөх ёслол"-ын арга хэмжээний дурсамжийг хэвлүүлэх гэрээ, дүүргийн нутаг дэвсгэрийн бохирдсон хөрсийг ариутган, халдваргүйжүүлэх ажлын гэрээг тус тус байгуулсан.

Хэлтэс, тасгуудаас зохион байгуулагдсан өртөөчилсөн аялал, Ниймийн бодлогын хэлтсийн "Бид эко дүүргийн хүүхдүүд 2018" чуулганы батлагдсан төсвийн дагуу худалдан авах ажиллагаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үнэмлэхийг захиалан хэвлүүлэх ажил, Засаг даргын нэрэмжит 5 төрөлт тэмцээний медаль, өргөмжлөлийг хэвлүүлэх, дүүргийн Засаг даргын өргөмжлөл, жуух бичиг, хүндэт тэмдэгийн загвар, зэргийг хэвлүүлэн хухудалдан авалт хийсэн.

2018 онд бараа материалын нийт 308,045,026 төгрөгийн худалдан авалтын гэрээг боловсруулан батлуулж санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлсэн.

Албан хэрэгцээнд шаардлагатай байгаа принтер, скайнерын худалдан авалтыг хийсэн бөгөөд нийт 28,000,000 сая төгрөгийн гэрээ байгуулж бараа, худалдаа үйлчилгээний худалдан авалтыг хийсэн.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: "Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал"

4.1 Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл;

Хэвлэл мэдээллийн чиглэлээр: Хан-Уул дүүргийн төр, захиргааны байгууллагуудын хийж хэрэгжүүлсэн цаг үеийн ажлуудыг олон нийтэд сурталчлах зорилгоор үйл явдлын талаарх 1020 гаруй мэдээ, мэдээллийг дүүргийн www.khanuul.mn сайт, "Хан-Уул Эко дүүрэг" facebook хуудас, "Хан-Уул дүүргийн Иргэдийн бүлэг", e-office системд байршуулсан.

Телевизүүдээр цацсан мэдээ: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс, алба, хороодын зохион байгуулсан үйл явдлын 240 гаруй мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэх үүднээс NTV, ECO TV, ETV, C1, TV5, VTV, Eagle TV, Монголын Үндэсний Олон нийтийн Радио телевиз, "Like TV", "MASS" TV зэрэг телевизүүдтэй хамтран 520 удаагийн давтамжтайгаар түгээж, өглөөний хөтөлбөр, тодруулга ярилцлага, шууд нэвтрүүлэгт холбогдох албан тушаалтныг оролцуулан ажилласан.

Цахим сайт буюу олон нийтийн сүлжээ: www.time.mn, www.news.mn, www.zaluu.com, www.ugluu.mn, www.grandnews.mn, monnews.mn, www.ontsloh.mn, www.24barimt.mn, www.Ulaanbaatar.mn зэрэг 40 гаруй сайтуудтай үйл явдлын онцлох мэдээ, мэдээллийг цаг тухайд нь давхар байршуулж, MGL радио нэвтрүүлэгтэй шууд холбогдон цаг үеийн мэдээллийг дамжуулсан.



Засаг даргын Тамгын газрын Ил тод байдлыг хангах ажлын хүрээнд www.khanuul.mn цахим хуудас болон e-office системд 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 220 захирамж, 65 ил тод байдлын мэдээ, 45 удаагийн шуурхай зөвлөгөөн, үр дүн зэргийг байршуулсан.

Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай хүргэх, иргэдийн санал, хүсэлт, гомдол мэдээллийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх зорилго бүхий "Хан-Уул дүүргийн иргэд " нэртэй цахим бүлгэмийг 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдөр шинээр нээн, идэвхитэй хөтлөн хөгжүүлж, 12 дугааар сарын 12-ны өдрийн байдлаар 19965 гишүүнтэй болсон бөгөөд 6156 иргэдийг дүүргийн бүлгэмд урисан байна. /Зөвхөн Хан-Уул дүүргийн иргэдийг бүлгэмийн гишүүнээр бүртгэсэн/



Дүүргийн page/хуудас/ 1189 like тай байснаас 2518 like 2552 дагагчтай болсон байна. 7 хоногт дунджаар 7000-10000 хүний хандалттай байдаг болсон.



Дүүргийн хаяг 2154 найзтай байснаас 5000 найзтай болж, шинээр найзын хүсэлт илгээж буй хүмүүс дагагч болон бүртгэгдэж байна.Одоогийн байдлаар 420 дагагчтай болсон.



Хан-Уул дүүргийн иргэд бүлгэмээр дамжуулан иргэдийн санал хүсэлт,өргөдөл гомдлыг хүлээн авч холбогдох мэргэжилтэнд шуурхай дамжуулан шийдвэрлүүлж байна.

QR kod байршуулсан цахим сувгуудын танилцуулга бүхий А3-н хэмжээтэй хэвлэмэлийг 500 ширхэг хэвлүүлэн СӨХ, хороодод тараан цахим сувгуудаар иргэд хэрхэн хурдан шуурхай санал хүсэлт өргөдөл гомдлоо шийдвэрлүүлэх,мэдээ мэдээллийг хүлээн авах солилцох талаархи заавар зөвлөгөөг өгч ажиллаж байна.

Мөн "Админ бүлгэм" нэртэй group нээж хороо ,сургууль , цэцэрлэгүүдтэй хамтран ажиллаж байна



Хан-Уул дүүрэгт хийгдэж буй бүтээн байгуулалтын 3D анимейшны ажлуудыг хариуцан одоогийн байдлаар 8 ажил бэлэн болсон байна. Үүнд:

- 4-р клиник сувилалын барилга
- 28-р цэцэрлэгийн барилга
- 14-р хороо цэцэрлэгийн барилга
- Наадамчдын замын уулзвараас Яармагийн автобусны шинэ эцсийн буудал хүртэлх хатуу хучилттай авто зам
- 49-р цэцэрлэгийн барилгын өргөтгөл
- 52-р сургуулийн барилгын өргөтгөл
- 53-р цэцэрлэгийн барилгын өргөтгөл
- Туул тосгоны барилгын ажлын өргөтгөл

Хан-Уул дүүргийн төрийн захиргааны байгууллагуудын үйлчилгээний мэдээллийг цуврал болгон цахим сувгуудаар мэдээллэхээс гадна дүүргийн иргэдийн гэрлэлт , шинэ хүүхэд төрөлт ,өрнийн зурлага , цаг агаар , өнөөдөр маргааш болох үйл явдал гэх мэт мэдээг бэлтгэн нийтэлж байгаа бөгөөд page , account group-г идэвхижүүлэн хөгжүүлэх иргэдийн гишүүнчлэлийг нэмэгдүүлэх ажил үргэлжлэн хийгдэж байна.

“Бидний Хан-Уул” фото мэдээллийн сэтгүүл:

Хан-Уул дүүрэгт 2017 онд хийгдсэн хөрөнгө оруулалт ,бүтээн байгуулалтын ажлууд болон дүүргийн иргэдийн талаарх онцлох мэдээ, мэдээллүүдийг багтаасан 68 хуудас бүхий фото мэдээллийн сэтгүүлийг **“БИДНИЙ ХАН-УУЛ”** нэртэйгээр гаргаж, төр, захиргааны байгууллагууд, хорооны иргэдэд хүргэсэн.

Мөн “Гранд” сэтгүүл, “Хөгжил зүтгэл” сэтгүүлүүдтэй хамтран 2017-2018 онд тус дүүрэгт хийж хэрэгжүүлсэн цаг үеийн асуудлын талаар мэдээлэл, ярилцлага, сурвалжлага

бэлтгэн хэвлүүлэн ажиллаж байна.

- Хан-Уул дүүргийн 16 хороо тус бүр бие даасан цахим сайттай бөгөөд тус цахим сайтуудаар дамжуулан хороодын иргэд дүүрэгт хийгдэж буй бүтээн байгуулалтын ажил болон хийгдэхээр төлөвлөж байгаа үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээллийг шуурхай хүлээн авдаг болсон. Мөн сайтаараа дамжуулан иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, өөрсдийн хүрээнд шийдвэрлэх боломжтой ауудлуудыг газар дээр нь хариу өгч ажиллаж байна.

Хан- Уул дүүргийн **1900-1965** тусгай дугаараар 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 16020 дуудлагыг хүлээн авч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад хариу мэдээлэл өгч ажилласан.

Жилийн эцсийн байдлаар нийт дуудлагын үзүүлэлтийг графикаар харуулвал:



Дүүргийн лавлах утсанд жилийн эцсийн байдлаар нийт 25 өргөдөл,гомдлыг хүлээн аван хариуцсан ажилтанд мэдэгдэн шийдвэрлэж ажилласан.

Өргөдөл, гомдол	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Нийт
	3	7	3	1	1	2	0	1	0	0	7	0	25

Лавлах утсанд холбогдсон иргэдийн дийлэнх дуудлагыг дараах хэлтэс, албадууд эзэлдэг байна. Үүнд:



	ЖДҮДТ	ТҮТ	МХХ	ЭМ,НД	ГА	ХХҮХ	ТА	УБ	Хороо	ЗДТГ
Үзүүлэлт	74	553	601	825	750	745	956	1402	3436	4867

Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн жилийн эцсийн дуудлагын ерөнхий үзүүлэлт



ТАВДУГААР БҮЛЭГ "Бусад мэдээлэл"

5.1 Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай мэдээлэл;

Дүүргийн хорооды өөрчлөх, шинэчлэн байгуулах чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 2017 оны А/229, 2018 оны А/101 дүгээр захирамжаар 2, 3, 10, 11, 15-р хороодын нутаг дэвсгэрт төрийн үйлчилгээг тогтвортой, түргэн шуурхай хүргэх зорилгоор өөрчлөх, шинэчлэн байгуулах ажлыг судлах ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсэг хуралдаж хүн амын байршил, эдийн засгийн чадавхи, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөлийг харгалзан дээрх хороодыг хувааж шинэээр 5 хороо байгуулах төсөл боловсруулж ДИТХ дахь намын бүлгүүд, хороодод танилцуулсан.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны А/43 дугаар тогтоол, Дүүргийн Засаг даргын 2018 оны А/357 дугаар захирамжийн дагуу дүүргийн 2,3,10,11,15 дугаар хороодын нутаг дэвсгэрийг өөрчлөх, шинэчлэн байгуулах ажлын хүрээнд сонсох ажиллагаа зохион байгуулсан.

Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.2-д, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу /хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн оролцсон тохиолдолд саналыг хүчинтэйд тооцно гэж зааснаар/ 2018 оны 11 сарын 02-ноос 05-ны хооронд сонсох ажиллагааг зохион байгуулж нийт санал асуулгад оролцсон өрхийн 95,3% нь дэмжсэн.

№	Хороо	Өрхийн тоо	Санал авбал зохих өрх	Санал өгсөн өрх	Дэмжсэн өрх	Дэмжээгүй өрх
1	2-р хороо	3068	154	810	786	24
2	3-р хороо	4674	234	1050	985	65
3	10-р хороо	3224	162	1000	937	63
4	11-р хороо	4691	235	505	502	3
5	15-р хороо	6846	343	2100	1999	101
	Нийт	**22503**	**1126**	**5495**	**5209**	**256**

2018 оны 11 сарын 15-ны өдрийн ДИТХ-ын ээлжит V дугаар хуралдаанаар хорооды хувааж, шинэчлэн зохион байгуулах тухай асуудлыг хэлэлцэн ДИТХ-ын 2018 оны 11 сарын 15-ны 02 дугаар тогтоолоор дэмжсэн ба хороод хуваах, өөрчлөн байгуулах саналыг дүүргийн Засаг даргын 2018 оны 11 сарын 17-ны өдрийн 03/517 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид уламжилсан.

Хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр:

Тэмдэглэлт ой, баяр наадмаар худалдаа, үйлчилгээ зохион байгуулсан арга хэмжээ:

Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, дэмжлэг үзүүлэх, борлуулалтыг дэмжих ажлын хүрээнд шинэ жил, сар шинийн баяр, Их хотын хямдрал зэрэг Нийслэл, дүүргээс зохион байгуулсан 10 удаагийн арга хэмжээнд 253 иргэн, ААНБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан, борлуулалтыг дэмжин ажиллаа.

Хяналт, шалгалт: Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, хоол үйлдвэрлэл, авто, засвар, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, ААНБ-д хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах үүднээс МХХ, ЦХ, НЗАА зэрэг холбогдох мэргэжлийн

байгууллагуудтай хамтран нийт 61 удаагийн хяналт шалгалт зохион байгуулж, 1147 иргэн аж ахуйн нэгжийг хамруулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын хоол үйлдвэрлэлийн газрын тогооч, зөөгчийг дүүргийн хоол үйлдвэрлэлийн "BROADWAY", "LOS BANDIDOS",

"ШОКОЛАДНИЦА /ВАБИ САБИ/", "MOUSTACHE" ресторанд 2018 оны 09 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд харилцан туршлага судлуулах ажлыг зохион байгуулан ажилласан.

Тулгар төр байгуулагдсаны 2227, Их Монгол улс байгуулагдсаны 812 жил, Ардын хувьсгалын 97 жилийн ойн Үндэсний их баяр наадмын үеэр Төв цэнгэлдэх хүрээлэнд худалдаа, үйлчилгээний 80 зөвшөөрөл олгосон. Дээрх аж ахуйн нэгжүүдэд баяр наадмын өрдүүдэд МХХ, ХХҮХ, ОБХ, Цагдаагийн хэлтэстэй хамтран анхаарах зүйл, тавигдах шаардлагын талаар зөвлөгөө өгч, зөвлөмж, сэрэмжлүүлгээр хангах сургалт, уулзалт зохион байгуулж, заавар, зөвлөмж өгч, малгай, футволк, хаяг, цаасан уут зэргийг тараан, гар дээрээс ил задгай худалдаа, үйлчилгээ эрхлэхийг таслан зогсоох, зөвшөөрөөгүй цэгт худалдаа хийхийг хориглон хяналт тавин ажилласан.

5.2 Байгууллагын харьяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай мэдээлэл;

Дүүргийн төр захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/365 тоот захирамжаар батлуулж, Тамгын газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/2302 дугаар албан бичгээр дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга нарт, мөн өдрийн 01/2302 дугаар албан бичгээр хороодын Засаг дарга нарт нийт 43 байгууллагад хүргүүлж, бэлтгэж ажил хангах тухай чиглэл өгч 2018 оны 12 сарын 03-ны өдрөөс эхлэн хуваарьт төлөвлөгөөний дагуу Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба ,хорооны үйл ажиллагааны ажлын хэсэг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу үлдсэн байгууллагуудаар хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, үр дүнг удирдлагад танилцуулна.

Дүүргийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх 5 бүлэг 106 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хагас жилийн биелэлт **50.7**, 3 дугаар улирлын биелэлт **82.5** хувьтай

үнэлэгдэж, илтгэх хуудсаар дүгнэлт, зөвлөмжийг удирдлагуудад танилцуулж, жилийн эцсийн биелэлт **90.1** хувьтай үнэлэгдэж 2018 оны 12 сарын 14-ний өдрийн дүүргийн ИТХ-ынээлжит VI дугаар хуралдаанаар хэлэлцэн 2018 оны үндсэн чиглэлийн биелэлтийг **"Бүрэн хангалттай"** дүгнэж, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2019 оны үндсэн чиглэлийн төслийг батлсан.

Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2018 оны 5 бүлэг 108 арга хэмжээний 3 дугаар улирлын биелэлт **89.7** хувьтай үнэлэгдэж, жилийн эцсийн биелэлтэд үнэлгээ хийгдэж байна.

Нийслэлийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс Хан-Уул дүүрэг хариуцан хэрэгжүүлж буй 37 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 3 дугаар улирлын биелэлт **78.9** , Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлээс Хан-Уул дүүрэг хариуцан хэрэгжүүлж буй 11 заалтын 3 дугаар улиирлын биелэлт **70** хувьтай үнэлэгдэж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан болох L MONITORING программд оруулж биелэлтийг тайлангийн хугацаанд илгээсэн ба жилийн эцсийн биелэлт, үр дүнг 2019 оны 01 сарын 05-ны дотор ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнахаар ажиллаж байна.

Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоолоор батлагдсан 31 үндэсний хөтөлбөрийн хагас жилийн биелэлт **85**, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан 26 дэд хөтөлбөрийн хагас жилийн биелэлт **75**, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан "Аз жаргалтай гэр бүл" хөтөлбөрийн хүрээнд 9, "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" хөтөлбөрийн хүрээнд 14, "Ахмадаа дээдэлье" хөтөлбөрийн хүрээнд 6, "Хороодын хөгжил-Төрийн үйлчилгээ" хөтөлбөрийн хүрээнд 8 төсөл арга хэмжээ буюу нийт 37 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн нийт 259.611.740 төгрөг зарцуулсан бөгөөд биелэлтийн дундаж **68.76**%-ийн гүйцэтгэлтэй байна. Жилийн эцсийн биелэлтийг Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадаас биелэлтийг хүлээн авч нэгтгэл хийгдэж байна. Тайлангийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлнэ.

5.3 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл хүсэлийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээлэл;

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгуудыг буулган дахин төлөвлөн барилгажуулах ажлын хүрээнд ашиглалтын шаардлага хангахгүй болсон нэхмэлийн 1,2,6,10 дугаар байранд худалдаа, үйлчилгээ явуулж буй газруудад ажлын хэсгийн хамт хяналт, шалгалт зохион байгуулж, 23 газар хамрагдсанаас 5 аж ахуйн нэгжийн согтуурулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг хураан авсан.

Дээрх ажлын хүрээнд Нэхмэлийн 1, 2, 6, 10 дугаар байранд худалдаа, үйлчилгээ явуулж байгаа газруудын захирал, эздэд сонсох ажиллагаа зохион байгуулсан ба нийт 20 иргэн, ААНБ оролцлоо.

Хан-Уул дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэр Буянт-Ухаа 23 дугаар гудамжны 883-6 тоотод байрлах “Эко мах трейд” ХХК нь зохих зөвшөөрөлгүй эрүүл ахуйн шаардлага хангахгүй орчин нөхцөлд толгойн цех ажиллуулан оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулан үйл ажиллагаа явуулж байгаа талаар иргэд болон хорооноос ирсэн гомдлын дагуу нөхцөл байдалтай танилцсан ба хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөгөөр нөлөөлөхүйц, бохирдсон орчин нөхцөлд зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсныг зогсоосон.

Цахим ертөнцөөр цацагдан олны анхаарлыг татсан 1-р хорооны нутаг дэвсгэр 120 мянгатын 4 дүгээр байрны 3-р орцонд зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан цехийн нөхцөл байдалтай танилцаж, “Мандах” СӨХ-той уулзаж, агуулахын зориулалтаар суурийн давхар түрээслэж байсан иргэн Уганцэцэг болон оршин суугч иргэдтэй тус тус уулзаж, үүрэг чиглэл өгч, дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэст мэдэгдэн, үйл ажиллагааг нь зогсоосон.

Дүүргийн 11-р хорооны иргэний гомдлын дагуу Зайсан хилл цогцолборын урд талбайд /чихмэл тоглоом базаж авдаг төхөөрөмжүүд байрлуулан/ үйл ажиллагаа явуулж буй иргэний тоглоомыг шалгаж тусгай тохируулгатай, зөвхөн нэг чиглэлд авах боломжтойг илрүүлж, шалгуулахаар хороон цагдаад хандсан.

5.4 Хөрөнгө санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт;

Хүндрэлтэй асуудлууд:

1. Дээд газруудаас ирж байгаа олон нийтийг хамарсан болон бусад цаг үеийн шинжтэй ажил зохион байгуулах, биелэлт, судалгаа, мэдээлэл авах тухай албан бичгүүд цаг тулгаж ирүүлдэг.

Цаашид анхаарах асуудлууд:

1. Зохион байгуулж буй үйл ажиллагааны үр дүн, ач холбогдлын талаар иргэдээс тухай бүр санал хүсэлт авч байх, дүн шинжилгээ хийж ажлаа төлөвлөх;

2. Олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, алба, хороодын албан хаагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх;

3. Төлөвлөсөн ажлыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэл сайтай хийж гүйцэтгэх, үр дүнг тооцож ажиллах;

4. Зохион байгуулах үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчилж, олон нийтэд ил тод мэдээлж байх;

5. Засаг даргын Тамгын газрын болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, тасаг хоорондын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулах;

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ЭНХБОЛД

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Н.БУЯНХИШИГ

БОЛОВСРУУЛСАН:
ТЗУХ-ИЙН ЗАХИРГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ч.АРИУНЖАРГАЛ